# ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД ХОРИХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**Судалгааны захиалагч:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

**Судалгааны багийн гишүүд:**


| | |
|---|---|
| Б.Алтангэрэл | Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа |
| М.Хүрэлбат | Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч |

# Агуулга


| | | |
|---|---|---|
| Өмнөх үг | | 3 |
| Товчилсон үгийн жагсаалт | | 4 |
| Нэр томьёоны тайлбар | | 5-7 |
| Зураг, хүснэгтийн жагсаалт | | 8 |
| Нийгэмшүүлэх ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн акт | | 9-10 |
| Удиртгал | | 11-14 |
| НЭГ. МОНГОЛ УЛСАД ӨСВӨР НАСНЫ ХҮНЭЭС ҮЙЛДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНД ШҮҮХЭЭС ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ | | |
| 1.1. | Өсвөр насны хүний үйлдэж буй гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцөлд хийсэн шинжилгээ | 15-34 |
| 1.2. | Шүүхээс гэмт хэрэг өсвөр насны хүнд оногдуулж буй ял шийтгэлд хийсэн шинжилгээ | 35-37 |
| ХОЁР. ШҮҮХЭЭС ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫГ ЭДЛҮҮЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ | | |
| 2.1. | Монгол Улсад өсвөр насны оногдуулсан хорих ялыг эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал | 38-73 |
| 2.2. | Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын чиг үүрэг, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ | 74-83 |
| ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫГ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ | | |
| 3.1. | Өсвөр насны хүнд ял оногдуулах, түүнийг эдлүүлэх талаарх олон улсын баримт бичиг | 84-92 |
| 3.2. | Гадаадын зарим орны өсвөр насны хүний хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог | 93-155 |
| ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ | | |
| 4.1. | Дүгнэлт | 156-157 |
| 4.2. | Зөвлөмж | 157 |
| ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ | | 158 |
| ХАВСРАЛТ | | 159-162 |

## Өмнөх үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгын дагуу Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв, ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага хамтран хийж гүйцэтгэсэн "Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт" судалгааны тайлан нь Монгол Улсад өсвөр насны хүнээс үйлдэж буй гэмт хэрэг, түүнд шүүхээс оногдуулж буй эрүүгийн хариуцлага, түүний эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн судалгааны бүтээл юм.

Дэлхийн улс орнуудын ял эдлүүлэх ажиллагааны нэг үндсэн анхаарч буй асуудал нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг ямар нөхцөлд, яаж ял эдлүүлэн, тэднийг хэрхэн нийгэмшүүлэх талаар өөр өөрсдийн хууль тогтоомж, практик үйл ажиллагаа байдаг.

Монгол Улс хэдийгээр өсвөр насны хүнд ял шийтгэл оногдуулан, эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын болон практик туршлага бий боловч, өнөөгийн хүчийн төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан "Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага"-ын талаар тусгайлан судалгаа шинжилгээний бүтээл хомс байна.

Түүнчлэн шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хүрээнд сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөл, журам, сургалт, нийгэмшүүлэх ажлыг бүрэн зохицуулаагүй орхигдуулсан нь практик хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна.

Судалгааны тайланд гадаадын зарим орны өсвөр насны хүнийг хорьж буй хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх үйл ажиллагааны онцлогын талаар мэдээлэл оруулсан нь танин мэдэхүйн болоод судалгаа, шинжилгээний чухал ач холбогдолтой материал болсон гэж найдаж байна.

Судалгаанд ашигласан статистик тоо баримт, үйл ажиллагааны мэдээлэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон холбогдох хорих ангиудын албан ёсны тайлан, мэдээнд тулгуурласан хэдий ч энэхүү судалгааны тайлан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагын байр суурь болон үйл ажиллагааны чиг хандлага, хэрэгжилтийн түвшинг илэрхийлээгүй, зөвхөн судлаачдын хөндлөнгийн судалгаа боловсруулалтын ажлын үр дүн болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хамтран ажилласан Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс болон судалгааны мэдээлэл цуглуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач, практик ажилтнууд, магистрант нарт талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

**Б.АЛТАНГЭРЭЛ**
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ, ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА

## Товчилсон үгийн жагсаалт:

| | |
|---|---|
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| УЕПГ | Улсын Ерөнхий Прокурорын газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ШШГТХ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль |
| ХЯЭА | Хорих ял эдлүүлэх алба |
| ХӨТЯЭА | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба |
| СХТБ | Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага |
| ХАДЖ | Хорих ангийн дотоод журам |
| НААЗ | Нийгмийн ажлын аргачилсан заавар |
| НСЗХ | Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |

## Нэр томьёоны тайлбар

(Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаанд хамаарах зарим нэр томьёог тайлбарлав.)

| | |
|---|---|
| **Ерөнхий боловсролын сургууль** | |
| | боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага |
| **Бүх нийтийн ерөнхий боловсрол** | |
| | 12 жилийн сургалтын агуулгын түвшин |
| **Суурь боловсрол** | |
| | 9 жилийн сургалтын агуулгын түвшин |
| **Албан боловсрол** | |
| | боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа |
| **Албан бус боловсрол** | |
| | боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа |
| **Насан туршийн боловсрол** | |
| | бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг |
| **Сургалтын орчин** | |
| | боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцаа |
| **Төлөвшил** | |
| | суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогц |
| **Гомдол** | |
| | төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт |
| **Гэмт хэрэг** | |
| | Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй. |
| **Гэм буруу** | |
| | бусдын өмнө хийсэн алдаа дутагдал, гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна. |
| **Дэглэм** | |
| | хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр |

| | |
|---|---|
| **Захидал** | |
| хүмүүсийн энгийн харилцаанд ашиглан илгээх бичиг | |
| **Зарчим** | |
| | Нийгмийн амьдралын эрх зүйн бодит байдлыг хангах, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж |
| **Итгэмжлэл** | |
| | өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээдэд бичгээр тодорхойлсон баримт |
| **Мэргэжлийн боловсрол, сургалтад хамруулах** | |
| | тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа |
| **Нийгэмшүүлэх ажил** | |
| | хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, сулласны дараах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй, нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай нөлөөллийн цогц арга хэмжээ |
| **Хорих ял** | |
| | иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжуулан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг төрийн албадлагын онцгой төрөл |
| **Хорих байгууллага** | |
| | эрүүгийн ял гүйцэтгэх тогтолцооны төрөлжсөн байгууллага |
| **Хорих ял эдлүүлэх ажиллагаа** | |
| | хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хуулиар эрхийн хязгаарлалт тогтоон, тодорхой дэглэм, журмын хүрээнд аюулгүй байдлыг хангаан хорьж буй арга хэмжээ |
| **Хоригдол** | |
| | хорих ял эдэлж байгаа ялтан |
| **Хорих анги** | |
| | шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага |
| **Сахилгын зөрчил** | |
| | мөрдөгдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан үйлдэл |
| **Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн** | |
| | 7 хүртэлх насны этгээд |

| | |
|---|---|
| **Иргэний эрх зүйн зарим чадамж** | |
| | 7-гоос 14 хүртэлх насны этгээд |
| **Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж** | |
| | Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд |
| **Иргэний эрх зүйн бүрэн чадамж** | |
| | буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 нас хүрсэн этгээд |

## Зураг, хүснэгтийн жагсаалт:


| | |
|---|---|
| Зураг 1. | Өсвөр насны хүн оролцсон гэмт хэргийн тоо, өсөлт бууралт: |
| Зураг 2. | Гэмт хэргийн түвшин |
| Зураг 3. | Нийт гэмт хэрэгт өсвөр насны хүний үйлдсэн болон оролцсон гэмт хэргийн эзлэх хувь |
| Зураг 4. | Өсвөр насны хүнээс үйлдсэн гэмт хэргийн ангилал |
| Зураг 5. | Өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн цаг |
| Зураг 6. | Гэмт хэрэг үйлдсэн гараг |
| Зураг 7. | Гэмт хэрэг үйлдэгдсэн газар |
| Зураг 8. | Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн боловсролын судалгаа: |
| Зураг 9. | Өсвөр насны хүмүүсийн ял шийтгүүлсэн байдал |
| Зураг 10. | Шүүхээс 2018,2019 онд өсвөр насны хүнд оногдуулсан ял шийтгэлийн судалгаа |
| Зураг 11. | Шүүхээс 2019 онд өсвөр насны хүнд хорих ялыг биечлэх эдлүүлсэн болон хойшлуулсан судалгаа |
| Зураг 12. | Шүүхээс 2019 онд өсвөр насны хүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан байдал |
| Зураг 13. | 18 хүртлэх насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг, шүүхээр ял шийтгүүлсэн хүүхдийн тоо /2014-2019/ |
| Зураг 14. | Өсвөр насны хоригдлын тоо /сүүлийн 20 жил/ |
| Зураг 15. | Сургуульд суралцсан хоригдлын тоо /сүүлийн 20 жил/ |
| Зураг 16. | Бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн хоригдлын тоо /сүүлийн 20 жил/ |
| Зураг 17. | Багшлах бүрэлдэхүүний тоо |
| Зураг 18. | Мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан хоригдлын тоо |
| Зураг 19. | Илэрсэн зөрчлийн тоо |
| Хүснэгт 1. | Өсвөр насны хүний үйлдсэн нийт гэмт хэрэг |
| Хүснэгт 2. | Өсвөр насны *ял шийтгүүлэгчдийн судалгаа* |
| Хүснэгт 3. | Өсвөр насны хүнд *оногдуулсан ялын төрөл* |
| Хүснэгт 4. | Өсвөр насны хүнийг хорихтой холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулалт |
| Хүснэгт 5. | Монгол Улсад өсвөр насны хүнээс үйлдсэн гэмт хэрэг, шийтгэгдсэн судалгаа |
| Хүснэгт 6. | Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны судалгаа |
| Хүснэгт 7. | Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан байдал |
| Хүснэгт 8. | Зөрчлийн мэдээ |

## Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн акт

| д/д | Журмын нэр | Дугаар | Огноо | |
|---|---|---|---|---|
| | | | Баталсан | Дагаж мөрдөж эхэлсэн |
| **Нэг. Хууль** | | | | |
| 1 | Үндсэн хууль | | | |
| 2 | Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ | | 2015-12-03 | 2017-07-01 |
| 3 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ | | 2017-06-09 | 2017-07-01 |
| 4 | Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ | | 2017-05-11 | 2017-07-01 |
| 5 | Боловсролын тухай хууль | | 2002-05-03 | |
| 6 | Бага, дунд боловсролын тухай | | 2002-05-03 | |
| **Хоёр. Засгийн газрын тогтоол** | | | | |
| 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | 204 | 2017-07-04 | |
| 2 | Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай | 204 | 2017-07-04 | |
| **Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал** | | | | |
| 1 | Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай | 87/111/118 | 2011-06-23 | |
| 2 | Хорих ангийн дотоод журам | А/183 | 2017-07-04 | |
| 3 | Зөвлөлийн бүрэлдэхүүн үйл ажиллагааны дүрэм батлах тухай | А186 А/74 | 2017-07-04 | |
| 4 | Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам | А/192 А/81 | 2017-07-18 | |
| 5 | Хорих ангийн харуул хамгаалалтын журам | А/197 | 2017-07-25 | |
| 6 | Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам | А/73 | 2017-04-04 | |
| 7 | Жишиг норматив шинэчлэн батлах тухай | А/247 А/167, 303 | 2017-09-29 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Хоригдлын нормын хувцас, ахуйн хэрэглэлийн нэр төрөл, тоо, эдэлгээний хугацааг тооцох журам | А/18 | 2018-02-01 | |
| 9 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм /Шинэчилсэн/ | А/183 | 2018-09-27 | |
| **Дөрөв. ШШГЕГ-ын даргын тушаал** | | | | |
| 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм | А/32 | 2008-02-18 | |
| 2 | Нийгмийн ажилтны аргачилсан заавар | А/129 | 2018-07-03 | |
| 3 | Сэтгэл зүйн ажлын заавар | А/110 | 2019-06-07 | |
| 4 | Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам | А/80 | 2013-04-24 | |
| 5 | ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм батлах тухай | А/51 | 2017-03-10 | |
| 6 | ШШГБ-ын бага бүрэлдэхүүний бодлогын баримт бичиг | А/96 | 2017-05-03 | |
| 7 | ШШГБ-ын хүний нөөцийн журам | А/192 | 2017-09-19 | |
| 8 | “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт | А/148 | 2018-08-31 | |

## Удиртгал

Îð÷èí γåä ýðγγãèéí ýðõ çγéí ñàëáàðò õèéãäýæ áóé ãóìàíèçàöèéí õγðýýíä өсвөр насны õγíä õγëýýëãýõ õîðèõ ÿëûí ýðõ çγéí γíäýñëýëèéã áîëîâñðîíãóé áîëãîõ, íýí ÿëàíãóÿà ýíýõγγ îîöëîã ñòàòóñ áγõèé ýòãýýäèéí ýðγγãèéí ýðõ çγéí äýãëýìèéã òóñãàéëñàí õóóëü òîãòîîìæîîð çîõèöóóëàõ øààðäëàãà өñөí íýìýãäñýýð áàéíà.

Ìîíãîë Уëñûí Yíäñэí õóóëèéí 16 äóãààð çγéëèéí 11 äγãýýð õýñýãò "...Ãýð áγë, ýõ íýëõàñ, õγγõäèéí àøèã ñîíèðõëûã òєð õàìãààëíà...", 16.13 äóãààð çγéëä "... Õóóëüä çààñàí γíäýñëýë æóðìààñ ãàäóóð äóð ìýäýí õýíèéã ÷ ... ýðõ ÷өëөөã íü õÿçãààðëàõûã õîðèãëîíî" ãýæ çààñàí áîë ÍYÁ-ûí 1948 îíû Õγíèé ýðõèéí òγãýýìýë òóíõàãëàëûí 10.3 äóãààð çγéëä " Ãýìò õýðýã γéëäñýí íàñàíä õγðýýãγé÷γγäèéã íàñàíä õγðýãñäýýñ òóñãààðëàæ, òýäíèé íàñ, ýðõ çγéí áàéäàëä íèéöñýí äýãëýìä áàéëãàíà. ÍYÁ-ûí 1989 îíû Õγγõäèéí ýðõèéí êîíâåíöèéí 37 äóãààð çγéëèéí á-ä "Õγγõäèéí ýðõ ÷өëөөã õóóëü áóñààð áóþó äóð ìýäýí õÿçãààðëàæ áîëîõãγé. Õγγõäèéã ...õîðèõ àðãà õýìæýýã õàìãèéí áîãèíî, òîõèðîìæòîé õóãàöààíä ýöñèéí áөãөөä îîöãîé àðãà õýìæýý áîëãîí õýðýãëýíý õýìýýí òóñ òóñ çààñàí áèëýý.

Òγγí÷ëýí ÍYÁ-ûí 1985 îíä áàòàëñàí Íàñàíä õγðýýãγé õγìγγñèéí òàëààðõ áàéöààí øèéòãýõ àæèëëàãààã ÿâóóëàõ íààä çàõûí æèøèã äγðìèéí 17.1 äγãýýð çγéëèéí á.ä "Íàñàíä õγðýýãγé õγíèé ýðõ ÷өëөөã õÿçãààðëàõ øèéäâýðèéí àñóóäëûã íàðèéâ÷ëàí, õÿìàí õýëýëöñýíèé äàðàà ýíý õÿçãààðëàëòûã áîëîìæòîéû õèðýýð õàìãèéí áàãààð òîãòîîíî... 17.1-èéí òàéëáàðûí 4 äýõ õýñýãò "Õîðèõîîñ өөð òөðëèéí ÿë õýðýãëýõ áîëîìæèéã ÿìàãò õàðãàëçàõ... Íàñàíä õγðýýãγé õγíèé ñàéí ñàéõàí áàéäàë, èðýýäγéã õàíãàõ ñîíèðõîë ÿìàãò òîãîðõîéëîã÷ õγ÷èí çγéë, õàðãàëçàõ áàðèìò áîëíî..." ãýæ çààæýý.

Õөãæèíãγé áîëîí õөãæèæ áóé îðíóóäûí ýðγγãèéí ÿëûí õóóëü, øγγõèéн ïðàêòèê æèøãýýñ γçýõýä өсвөр насны õγíä îíãäóóëàõ õîðèõ ÿëûн õγðýý ìàø õÿçãààðëàãäàìàë, íàñíû õÿçãààðëàëòûã äîîä õýìæýýíýýñ òàòàõыг /14- 16/ õîðèãëîõ, èõýíõäýý õîðèõîîñ өөð òөðëèéí ÿëûí õýðýãëýý òóõàéí ýòãýýäýä õγëýýëãýõ íèéò ÿëûí äîòîð çîíõèëîõ /70- 80 õóâü/ õóâèéã ýçýëæ áàéãàà íü àíõààðàë òàòàõ áîëîâ.

Äýýð äóðüäñàí Îëîí óëñûí ýðõ çγéí òγãýýìýë õýì õýìæýý áîëîí ãàäààäûí îðíóóäûí çîíõèëîõ õàíäëàãà, íèéòëýã æèøãýýñ γçýõýä íàñàíä õγðýýãγé ýòãýýäýä îíãäóóëàõ õîðèõ ÿë îîöãîé íөõөөë íèëýýä õÿçãààðëàãäàìàë òγâøèíä áàãà õóâèéã ýçëýí õýðýãëýãääýæ áàéãààãèéí äýýð òóõàéí ÿëûí ýðõ çγéí γíäýñëýë íü îîö îîòîé ãýìò õýðãèéí õóâüä õàìààðàëòàé äýýð ýíý íü íàðèéâ÷ëàí õóóëü÷èëãàñàí áàéõ áà ñγγëèéí õîðèîä æèëä íàñàíä õγðýýãγé õγíèé ýðγγãèéí ýðõ çγé ãýñýí áèå äààñàí ñàëáàð øèíýýð áèé áîëæ áγðýëäýæ áàéíà.

Ýäγãýý äýëõèéí óëñóóäûí ýðγγãèéí ýðõ çγéí ñàëáàðò ãëîáàëü÷ëàëûí γéë

ÿâö íýâòýð÷ áàéãààòàé õîëáîîòîéãîîð 2007 îíä ÍYÁ-ûí äýìæëýãòýéãýýð áîëîâñðóóëæ ãàðãàñàí Äýëõèé äàõèíû Ýðүүãèéí çàãâàð õóóëèéä íàñàíä õүðýýãүé ýòãýýäýä õүëýýëãýõ ÿëûí ñàíêöèéã àëü áîëîõ õîðèõîîñ өөð òөðëèéí ÿë áàéõààð òîìú¸îëñîíûã ýíä îíöëîí äóðüäààæ áîëîî.

Äýëõèéí íèéòèéí õýìæýýíä ãýìò õýðýã үéëäñýí íàñàíä õүðýýãүé ýòãýýäýä õүëýýëãýõ ýðүүãèéí õaðèóöëaãûг а.гүìò ýòãýýäèéã øèéòãýõ, ÿë îíîãäóóëaõ, á.нөõөí ñýðãýýõ ãýñýí õî¸ð àðãûã õýðýãëýæ áàéía.

Íөõөí ñýðãýýõ õóóëü çүéí aðãa íü îëîí îðíû øүүõèéí ïðaêòèêò òүãýýìýë õýðýãëýãäýæ áaéãaà áөãөөä ýíý íü ãýìò õýðýã үéëäýõүүñ өìө òóõàéí çөð÷èëäñөí õàðèëöaa ÿìàð áàéñaí òýð áàéäàëä îðóóëàõàä ÷èãëýãäñýí àðãà õýìæýý þì. Өөðөөð õýëáýë ÿëûí áóñ àðãaað ãýìò õýðýã áîëîí ãýìò õýðýãòýíòýé aæèëëàõ өâөðìөö àðãà ìөí. Ýíý íü íýã òàëaañ çөð÷èëäñөí õaðèëöaaã ñýðãýýõ, ãýìò ýòãýýäèéã çөâ çaìä îðóóëàõ, áóðóó үéëäëèéã íü îéëãóóëàõ íөãөө òàëàañ õîõèðîã÷ áîëîí ãýìò õýðýã үéëäñýí ýòãýýäèéã ýâëýðүүëýõ, ãýìò õýðãèéí óëìaañ ó÷ðóóëñaí õîõèðëûã íөõөí òөëөõ, ñaéí үéëèéã õîõèðîã÷èéí òөëөө õèéõýä ÷èãëýãääýã. Îð÷èí үåä íañaíä õүðýýãүé ýòãýýäýä õүëýýëãýõ äýëõèé íèéòèéí õaíäëaãa íөõөí ñýðãýýõ aðãaä øèëæèæ íýã òaëààñ õîõèðîã÷èéí ýðõèéã õàíãaõ íөãөө òaëaañ íañaíä õүðýýãүé ýòãýýäèéí õóóëü ¸ñíû ýðõ aøèãò íèéöүүëýõýä àíõààðëaa õàíäóóëàõ áîëæýý. Ãýòýë ìàíaé îðíû õóâüä ãýìò õýðýã үéëäñýí íañaíä õүðýýãүé ýòãýýäèéã øèéòãýõ, ÿë îíîãäóóëýõ añóóäëûã óðüäýë áîëãîñîîð өíөөäðèéã õүð÷ýý.

Өсвөр насны õүíä îíîãäóóëàõ õîðèõ ÿëûí ýðõ çүйí үíñиүã òîãтîîñîí эðүүãèéí õóóëü, õîðèõ ÿë ýäëүүëýõ àæèëëaãààã çîõиöóóëñàн øүүõèéí øèéäâýð ãүéöýòãýх òóõàé õóóëь áîëîí ÿë ýäëүүëýõ àæèëëàãààíû ïðàêòèêò õýðõýí õýðýãæèæ áàéãaa, ýäãýýðèéí óÿëäàà õîëáîî, õèéäýë, òóëãàìäñàí añóóäëûã судлах нь чухал ач холбогдолтой юм.

Өсвөр насны õүíä õîðèõ ÿëûã õýðõýí îíîãäóóëæ áàéãàà òóõàéä, гүìò õýðýã үéëäñýí өсвөр насны õүíä õүíä ýðүүãèéí õaðèóöëaãa õүëýýëãýõýä íañaíä õүðýã÷äýä òaâèãääàõ õýìæүүðýýñ èëүү îíöëîã áàéäàë øaaðдäaã. Ýíý íü òýäíèé íañíû íèéãýì-ñýòãýë çүéí өâөðìөö áaéäëûã үүäýëòýé þì. Íèéãýìøèëèéí òүâøèí õaíãaëòòaé өíäөð үçүүëýëòòýé áaéæ áîëîõ áîëîâ÷ èëì íañíû õүìүүñò ãýíýòèéí ýðñ øèéäýë, òүðãýí äýâðүүí çүí, öî÷ìîã óóð óíäóóöaë, ñýòãýëèéí òîãòâîðãүé, õөíãөí ãîîìîé áàéäàë, áүõèé ë íөõöөë áàéäëûã õaðãaëçaí òóõaéí íөõöөë áaéäëûã үíýëýõ ÷aäâað äóòaãäaax ÿâäàë õýâøèìýë áàéäàã. ×óõaìõүү èëì áàéäàë íü ýðүүãèéí õaðèóöëaãàà õүëýýëãýõ íèéòëýã æóðàìòaé õaðüöóóëaõaä өсвөр насны õүíä ýðүүãèéí õýðèóöëaãa õүëýýëãýõýä õүä õýäýí өâөðìөö áaéäëûã õóóëü÷ëaí òîãòîîæ õaðãaëçaí үçүүõ çàéëøãүé øààðäëaãaûã áóé áîëãîìîîã áaéía.

Ãýìò õýðýã үéëäñýí өсвөр насны õүíä çөөëөí õaíäaõäaa áóñ, õaðèí ãýìò õýðãèéí øaëòãaaì íөõööө ë, ãýìò õýðýãòíèé çaí áaéäëûã çөâ òîãòîîæ, òýäíèé íañíû îîöëîãûã õaðãaëçaí õүìүүæèë, íèéãýìøèëä íü íөëөөëөõ үð äүíòýé àðãûã ýðýëõèéëýõýä îðøèíî.

Õүүõäèéí ýðõèéí êoíâåíö áîëîí ÍҮÁ-ûí óäèðäàìæóóäaä õүүõäүүä õèéñýí үéëäëèéíõýý үð äaãaâaðûã óõaìñaðëaõ ÷aäaâõè íü õүçãààðëàãäìaë, õàðèí çàñàð÷ õүìүүæèõ áîëîìæ èëүү áàéäãèéã àíõaaðaí үçýæ ÿë øèéòãýë îîãäóóëaõûã ãîë÷ëîí aíõaàðàõûã òóíõàãëaæýý.

Õүүõäèéí ýðõèéí òóõàé Êîíâåíöèéí 37 äóãààð çүéëä: "... 18 íañaíä õүðýýãүé õүүõäèéí үéëäñýí ãýìò õýðýãò öaaçaað aâaõ áóþó ñóëëaõ áîëîìæãүéãýýð áүõ íañaað íü õîðèõ ÿë îîîãäóóлахãүé áaéõ", "... õîðèõ aðãa õýìæýýã õaìãèéí áîãèíî òîõèðîîæòîé õóãaöaaíä ýöñèéí àðãa õýìæýý áîëãîí õýðýãëýõ". Ýð-Ðиaäûн үнäñэí çàð÷ìûí 46 äóãààð çүéë: "Çàëóó õүìүүñèéã засан хүмүүжүүлэх áaéãóóëëàãààä áàéëãàõ ÿâäëûã òóéëûí ýöñèéí àðãà хэмжээ болгон, çaéëøãүé øàaðäëaãàòàé áîãèíî õóãàöaaãààð õэðэгжүүлж, өñвөр үåиéíõíèé àøèã ñîíèðõëûã òýðãүүí çýðýãò òàâèõ ¸ñòîé". Áýýæèíãèéí äүðìèéí 19.1-т "Íañaíä õүðýýãүé ýòãýýäèéã òөâëөðñөí õүìүүæүүëýõ áaéãóóëëaãýä õîðèõ ÿâäëûã çaéëøãүé øaaðäëaãaòýé òîõèîëäîëä õaìãèéí áîãèíî õóãaöaaíä ýöñèéí aðãa õýìæýý áîëãîí õýðýãëýâýë çîõèíî". Òүүí÷ëýí áóñäûí ýñðýã õү÷ õýðýãëýñýí îîöòîé үéëäýë õèéñýí áóþó îîöòîé ãýìò õýðãèéã óäaa äýðýý үéëäýæ áóéãaañ áóñaä òîõèîëäîëä íañaíä õүðýýãүé õүìүүñò õîðèõ ÿë îîîãäóóëæ áîëîõãүé. Õүүõäýä õîðèõ ÿë îîîãäóóëáaë ýðүүãèéí õaðèóöëaãûí õүìүүæëèéí çîðèëãî áүðýí áèåëýãäýõãүé, õaðèí ÷ òýäíèé óëaì ñөðөã ìóó íөëөө үçүүëýõ áөãөөä ãýìò õýðýã үéëäñýí õүүõäýä çөâõөí õүìүүæëèéí ÷aíaðòaé aëáaäëaãûí aðãa õýìæýý õýðýãëýõ íü үð äүíòýé áa õîðèõ ÿë îîîãäóóëaõ íü çөâõөí ýöñèéí aðãa õýìæýý áaéõ ¸ñòîé гэх зэргээр тусгаж өгсөн байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 48656 хүн шүүхээр ял шийтгүүлснээс өсвөр насны хүн 1869 буюу 3.84%-ийг эзэлж байна. Түүнчлэн нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлийн явцад ажилгүйдэл, ядуурал, түүнээс улбаатай архидалт, биеэ үнэлэх, мансуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд, эцэг, эх, асран хамгаалагчдаас үр хүүхэддээ тавих хараа хяналт дутсанаас хүүхэд сургууль завсардах, гэр орноосоо дайжих, элдэв сөрөг нөлөөнд автах, улмаар гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөх явдал сүүлийн жилүүдэд төдийлөн буурахгүй, ноцтой гэмт хэргүүд үйлдэгдэж олныг түгшээж байна.

Шүүхийн судалгаанаас харахад 2018, 2019 онд нийт 662 өсвөр насны хүн ял шийтгүүлснээс 494 хүн буюу 74.6 хувь нь хорих ял, 158 буюу 22.9

хувь нь хорихоос өөр төрлийн ял, 37.2 хувь буюу 246 нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан байна.

Монгол Улс 2017 он хүртэл насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа гэсэн агуулгаар хорих ялыг эдлүүлж байгаад 2017 оноос Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэсэн нэр томьёог Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгаж өгчээ.

Практикт "Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага"-ын үйл ажиллагааг нэг мөр ойлгоогүй, тусдаа эрх зүйн зохицуулалт байхгүйгээс насанд хүрэгчдийн нэгэн адил хорих нөхцөл, журам мөрдөж байгаагаас зарим нэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байгаа тул энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

**Судалгааны ажлын зорилго, зорилт:**

Судалгааны багийн зүгээс энэхүү судалгааны ажлын зорилгыг тодорхойлохдоо Монгол Улсад өсвөр насны хүнээс үйлдэж буй гэмт хэрэг, түүнд шүүхээс оногдуулж буй ял, шийтгэлд дүн шинжилгээ хийн, тухайлан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг судлан, холбогдох дүгнэлт-зөвлөмж боловсруулах явдал мөн гэж үзсэн.

Энэхүү зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг өмнөө тавилаа.Үүнд:

1.Өсвөр насны хүнээс үйлдэж буй гэмт хэрэг, түүнд шүүхээс оногдуулж буй ял шийтгэлд шинжилгээ хийх

2.Шүүхээс оногдуулсан хорих ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тухайлбал нийгэмшүүлэх болон сургалтын ажлын хэрэгжилтэд шинжилгээ хийх

3.Гадаадын зарим оронд өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хэрхэн эдлүүлж буй талаар харьцуулсан судалгаа хийх

4.Судалгааны материалд үндэслэн "Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журам"-ын төслийг боловсруулах зэрэг болно.

**Судалгааны ажлын арга зүй:**

Судалгааны ажилдаа түүхчлэх, бичиг баримт, бусад эх сурвалжид шинжилгээ хийх, харьцуулах болон ярилцлагын зэрэг нийгмийн шинжлэх ухааны аргуудыг ашиглана.

Түүнчлэн Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг судалгаандаа өргөнөөр ашигласан болно.

# НЭГ. МОНГОЛ УЛСАД ӨСВӨР НАСНЫ ХҮНЭЭС ҮЙЛДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНД ШҮҮХЭЭС ЯЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## 1.1.Өсвөр насны хүний үйлдэж буй гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцөлд хийсэн шинжилгээ

Цагдаагийн байгууллагын бүтцэд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгж 1949 онд байгуулагдаж, өдгөө 70 гаруй жилийн нүүр үзэж буй. Энэ нэгж байгуулагдсанаар олон мянган хүүхдийг гэмт хэргийн хохирогч болохоос, гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэн ажиллах болсон. Хэдийгээр хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргийг цагдаагийн байгууллага хүлээдэг ч төсөв мөнгө нь тийм ч хангалттай бус. Түүнчлэн цөөхөн байцаагчтай учраас хүүхэд бүрт хүрч ажиллах боломж хомс ч тэд гомдол хэлэхээсээ урьтаж, хийхийг эрмэлзэн ажилладаг. Улсын хэмжээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 53 алба хаагч ажиллаж байна. Гэтэл Монгол Улс ерөнхий боловсролын 800 орчим сургууль, 1.2 сая хүүхэдтэй. Өөрөөр хэлбэл, нэг хүүхдийн байцаагчид 12-15 сургууль, 20-25 мянган хүүхэд ногддог. Жилийн хугацаанд тухайн хүн 40 орчим хувьд нь л хүрч ажиллах боломжтой байдаг аж. Энэ нь хүн, хүчийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж буй юм. Гэхдээ хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь дан ганц цагдаагийн байгууллага, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаар хязгаарлагдахгүй. Холбогдох хууль, тогтоомжид зааснаар эцэг, эхчүүд эрсдэлт нөхцөл байдлаас хүүхдээ хамгаалах үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ биелүүлж чадаагүйн улмаас хүүхдэд хохирол учирсан бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээдэг.

Монгол улсад нийгэм соёлын өөрчлөлт, ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, гэрлэлт, хүүхэд өсгөх, хүүхэд хүмүүжүүлэх, гэр бүл төлөвлөх талаар шинэ үнэлэмж, итгэл үнэмшил нийгэмд бий болгосон байна.

Үүний зэрэгцээ гэр бүл хүүхдэд анхаарал халамж тавих чадвар муудаж, боловсролын тогтолцоо суларснаас хараа хяналтгүй хүүхэд нэмэгдэж, гудамжны гэгдэх хүүхдүүд бий болсноос хүүхдээс үйлдэх гэмт хэрэг огцом өссөн.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 48656 хүн шүүхээр ял шийтгүүлснээс өсвөр насны хүн 1869 буюу 3.84 хувийг эзэлж байна.

- 2019 оныг өмнөх онтой харьцуулбал ийм төрлийн гэмт хэргийн тоо 327 буюу 44.1 хувиар;
- Орон нутгийн хэмжээнд 83 буюу 20.5 хувиар;

➢Нийслэлд 244 буюу 60.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

*Зураг 1. Өсвөр насны хүн оролцсон гэмт хэргийн тоо, өсөлт бууралт:*




ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын статистикийн тоо мэдээллээс харахад Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгуудад өсвөр насны хүний үйлдсэн болон оролцоотой гэмт хэргийн тоо өсөлттэй, Дархан-Уул, Дорноговь аймагт өөрчлөлтгүй, бусад аймагт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

*Зураг 2. Гэмт хэргийн түвшин*




Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоонд өсвөр насны хүн үйлдсэн болон оролцсон гэмт хэргийн эзлэх хувь нь 2013 онд 5,4%, 2014 онд 3,8%, 2015 онд 4,1%, 2016 онд 4,2%, 2017 онд 2,9%, 2018 онд 5.83%, 2019 онд 6.24 хувийг тус тус эзэлж байна. 2013-2017 оны хооронд

өсвөр насны хүн хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл:

*Зураг 3. Нийт гэмт хэрэгт өсвөр насны хүний үйлдсэн болон оролцсон гэмт хэргийн эзлэх хувь*




*Зураг 4. Өсвөр насны хүнээс үйлдсэн гэмт хэргийн ангилал*




*Хүснэгт 1. Өсвөр насны хүний үйлдсэн нийт гэмт хэрэг*

| Гэмт хэргийн төрөл | Бүртгэгдсэн хэрэг | | Өсөлт, бууралтын хувь | Нийт гэмт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| | 2018 он | 2019 он | | |
| **Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, үүнээс: хүнийг алах** | 5 | 4 | -20.0 | 0.4 |
| | 1 | 4 | 4.0 дахин | 0.4 |
| **Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг** | 184 | 232 | 26.1 | 21.7 |
| **Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг,үүнээс: хүчиндэх** | 24 | 20 | -16.7 | 1.9 |
| | 22 | 16 | -27.3 | 1.5 |
| **Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг** | 2 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Өмчлөх эрхийн эсрэг** | | 476 | 756 | 58.8 | 70.7 |
| **Үүн** | Хулгайлах | 355 | 567 | 59.7 | 53.1 |
| | Залилах | 40 | 97 | 2.4 дахин | 9.1 |
| | Дээрэмдэх | 67 | 64 | -4.5 | 6.0 |
| | Мал хулгайлах | 14 | 28 | 2.0 дахин | 2.6 |
| **Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг** | | 16 | 21 | 31.3 | 2.0 |
| **Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг,** | | 6 | 7 | 16.7 | 0.7 |
| **үүнээс:Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих** | | 6 | 7 | 16.7 | 0.7 |
| **Бусад** | | 28 | 28 | | 2.6 |

**Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг:**

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 36 буюу 31.3, пүрэв гарагт 38 буюу 33.0, мягмар гарагт 43 буюу 43.4, баасан гарагт 51 буюу 46.4, бямба гарагт 49 буюу 49.5, даваа гарагт 54 буюу 49.1, ням гарагт 56 буюу 60.2 хувиар тус тус өссөн.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06.00-14.00 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 74 буюу 43.5, 14.00-19.00 цагийн хооронд 117 буюу 49,6, 19.00-22.00 цагийн хооронд 71 буюу 71.7, 22.00-06.00 цагийн хооронд 65 буюу 27.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

*Зураг 5. Өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн цаг*



*Зураг 6. Гэмт хэрэг үйлдсэн гараг*




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 4 буюу 25.0, нийтийн тээвэрт 1 буюу 50.0 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад үйлдсэн хэрэг 1 буюу 7.1, гэр, орон сууцанд 56 буюу 21.6, гудамж, талбайд 63 буюу 30.3, олон нийтийн газарт 64 буюу 58.2, авто зам дээр 3 буюу 75.0 хувиар, аж ахуйн нэгжид 57 буюу 2.1 дахин, бусад газарт 88 буюу 2.2 дахин өссөг үзүүлэлттэй байна.

*Зураг 7. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар*




Сүүлийн 5 жилийн судалгаагаар дийлэнх нь суурь боловсролтой этгээдүүд гэмт хэрэг үйлдсэн буюу оролцсон байна.

Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүмүүс (хууль зөрчсөн хүүхдүүд) -ийг:

1.Зөрчил гаргасан үндэслэлээр зөрчил гаргасан нь нотлогдож шийтгүүлсэн 16-18 хүртэлх насны хүүхдүүд;

2.Гэмт хэрэг үйлдсэн боловч хэрэг нь хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон хүүхдүүд /насанд хүрээгүй, хөнгөн хэрэгт хохирогчтой эвлэрсэн гэх мэт/;

3.Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруу нь нотлогдож шүүхээс ял шийтгэл оногдуулсан хүүхдүүд гэж ангилан авч үзэж болох юм.

*Зураг 8.Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн боловсролын судалгаа:*




**Өсвөр насны хүмүүсийн үйлдсэн гэмт явдлын шалтгаан, нөхцөл:**

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлийн явцад ажилгүйдэл, ядуурал, түүнээс улбаатай архидалт, биеэ үнэлэх, мансуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд, эцэг, эх, асран хамгаалагчдаас үр хүүхэддээ тавих хараа хяналт дутсанаас хүүхэд сургууль завсардах, гэр орноосоо дайжих, элдэв сөрөг нөлөөнд автах, улмаар гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөх явдал сүүлийн жилүүдэд төдийлөн буурахгүй, ноцтой гэмт хэргүүд үйлдэгдэж олныг түгшээж байна.

Өсвөр насны хүмүүсийн болон хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгааныг криминологийн онолын үүднээс:

1.Обьектив шалтгаан (нийгмийн харилцаа, эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй шалтгаан, насанд хүрээгүй хохирогчийн /виктим/ шинж;

2.Субьектив шалтгаан гэж ангилж болно.

**Обьектив шалтгаан:**

*Нийгмийн харилцаанаас үүдэлтэй шалтгаан:*

Монгол Улсын нийгмийн байдал харьцангүй тайван учир үндэстэн, ястнуудын хоорондын харилцаанд ямар нэг зөрчил мөргөлдөөн, шашин хоорондын үзэл суртал, зөрчил үлэмж бага байдаг тул үүнийг гэмт явдлын шалтгаанд тооцохгүй.

Харин гэмт явдлын микро түвшинд нийгмийн хамгийн анхдагч, үндсэн

нэгж гэр бүлийн байдал, нийгмийн хяналт, чөлөөт цаг зэрэг орно.

Ес суртахууны үнэт зүйлсийн мэдрэмжгүй байдал, ажилгүйдэл, нийгмийн гишүүдийн дийлэнх хэсгийн ядуурлын явцын хурдац зэрэг нь гэр бүлийн "уналт"-ыг илэрхийлж байна.

Мөн гэр бүлийн маргаан зөрчилдөөн, эд хөрөнгийн ба сэтгэлийн холбоос алдагдсанаар гэр бүл салалт (албан ёсны гэр бүл болoлтын тоо ихсэхэд насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг гэмт хэргийн тоо багасна), төрөлт багасах, гэр бүл нийгмээс тусгаарлагдах, гэр бүлийн нэр хүнд унах ноцтой шинж тэмдгүүд өсдөг байна. Эдгээр шинж тэмдэгт:

- Гэр бүлийн орлогын ялгарал;
- Залуучууд амьдралын зорилгогүй болох;
- Иргэдийн соёл, боловсрол, гэгээрлийн түвшин буурах;
- Ажилгүйдэл ихсэх;
- Гэр бүл үр хүүхдээ хүмүүжүүлэх чадваргүй болох;
- Архидалт зэрэг орно.

Төрийн болон олон нийтийн байгууллагын зүгээс гэр бүлийн үүрэг хариуцлага суларч байгаа байдалд тавих хяналт хангалтгүй байх нь нийгмийн хяналтыг сулруулна.

Нийгмийн хяналтын сулрал нь өсвөр насны хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн гаралтад дараах 2 чиглэлээр нөлөөлнө.

1-рт: гэр бүлийн дотоод харилцаа энэ хяналтаас алдагдаж, гэр бүлийн хүрээнд нийгмийн зүгээс аливаа зорилтот хүмүүжлийн ажил явуулах, хяналт тавих боломжгүй хаагдмал болдог. Ийм гэр бүлийн хяналтгүй байдал нь дарангуйлал, дураараа аашлах, гэр бүлийн бурангуй ёс жаяг, эцэг эхийн засаглалыг бий болгох, насанд хүрээгүй гишүүний эрхийг зөрчих, тэдний эсрэг гэмт хэрэг үйлдэх, хүүхэд гэр орноосоо дайжих, гэмт хэрэгт татагдан орох явдлыг бий болгоно.

2-рт: хүүхэд, өсвөр үеийнхний зан байдлын харилцаанд сөргөөр нөлөөлнө. Сургуулиас гадуурх хүмүүжлийн ажлын тогтолцоо, хүүхэд өсвөр үеийнхний олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын задрал, боловсролын байгууллагын дутагдал энэ бүхэн нийгмийн идэвхийг сулруулж, насанд хүрээгүй хүмүүс нийгмийн хяналтаас ангид болдог. Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, хүмүүжлийн ажлын салангид байдал (сургуулийн хүмүүжил нь сургууль дээрх хүмүүжлээр хязгаарлагдах, суралцагчдын сургуулиас гадуурх зан байдал нь сурган хүмүүжүүлэгчдийн анхаарлаас ангид, ихэнх тохиолдолд багш нар сурагчийнхаа амьдрал ахуй, сонирхол, хаагуур юу хийж явдаг талаар огт мэдээлэлгүй байх) нь гэр бүл, сургуулийн хоорондын холбоо алдагдах, хүүхэд өсвөр үеийнхэн сөрөг үзэл бодолтой болоход нөлөөлнө.

Хүүхэд гэмт хэргийн замд орох, хохирох эрсдэлтэй болох нь зохион байгуулалтгүй чөлөөт цагаас шалтгаална. Чөлөөт цагаа өнгөрөөх газар хомс байх нь архидалт, PC тоглоомонд донтох сөрөг зан үйлийг бий болгоно.

*Эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй обьектив шалтгаан:*

Хүүхдийн нэг онцлог шинж нь эдийн засгийн хувьд байнга бусдаас хараат байдалтай байдаг. Энэ эдийн засгийн хараат байдал буюу хоол хүнс, хувцас хунар, орон байрны хэрэгцээг түүний эцэг, эх болон харгалзан дэмжих үүрэгтэй этгээдүүд хангаж байдаг. Гэтэл эдийн засгийн ялгавартай байдлаас болж дээрх хэрэгцээг нь нийгмийн чинээлэг хэсэг нь сайн хангадгаас шалтгаалан гэмт халдлагад өртөх магадлал өсдөг бол нөгөө хэсэг нь үүргээ биелүүлэх боломжгүй өөрсдөө ядуу зүдүү, уг үүргээ биелүүлэхгүй, хүүхдээ хараа хяналтгүй орхих буюу гудамжинд гаргах, гуйланчлуулах, гудамжинд гаргаагүй ч тэдний хэрэгцээг хангаж чадахгүй үед хүүхдүүд өөрсдийн зайлшгүй хэрэгцээгээ хангахын тулд бусдын эд зүйлийг хулгайлах, дээрэмдэх, булаах, залилах мэхлэж авах гэх буруу гэмт хэргийн замыг сонгож гэмт хэрэг үйлдэхэд хүрдэг.

Боловсрол олж авах хүрээнд хүүхдүүд ихээхэн цаг зарцуулдаг бөгөөд тэдний гол үлгэр дууриалал болгодог хүн нь багш байдаг. Багш нь хичээл заахдаа ямар ч сэтгэл, зүтгэл гаргахгүй байх, хүүхдэд шударга бус хандах, баян хоосноор нь ялгаварлан гадуурхах, мөнгө бэлэг өгөхийг шаардах, хахууль авах, харгис хэрцгий хандах зэргээр муу үлгэр дууриал үзүүлэх нь тэднийг гэмт хэргийн замд түлхэн оруулах, мөн тухайн сургалтын хөтөлбөр, багшийн арга барил муугаас хүүхэд сурах сонирхолгүй болох; сурлагаар хоцорсон, сургууль завсардсан "болохгүй" гэгдэх хүүхдийг эргээд хамт олонд татан оруулах ажил хийгддэггүйгээс болж нэг талаас гэмт хэрэг үйлдэх, нөгөө талаас гэмт халдлагад өртөх боломжийг бүрдүүлж өгдөг.

Баян, ядуугийн хоорондын ялгаа нь хүүхэд гэмт халдлагад өртөх болон гэмт хэрэг үйлдэх эдийн засгийн шалтгааны нэг болно.

Иргэдийн ядуу байгаагийн хамгийн гол шалтгаан нь ажилгүйдэл, өрхийн орлогогүй байдал бөгөөд бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль төгсөгчид, цэргийн алба хаагчид, мэргэжилгүй иргэдийн тооноос хамаарч ажилгүйчүүдийн тоо өсдөг. Иргэдийн амьдралын түвшний үзүүлэлт нь гэмт хэрэг үйлдэгдэх шунахай сэдэлтийг бий болгох асар том эх үүсвэр болдог байна.

*Насанд хүрээгүй хүний виктим шинж:*

Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд гэмт явдлын виктим эрсдэл харьцангүй өндөр байх бөгөөд энэ утгаараа гэмт явдлын шалтгаан

нөхцлийг бүрдүүлэхэд өдөөгч хүчин зүйл болдог гэдгийг судлаачид нотолсон байна.

Хүүхэд нь сэтгэл зүйн хувьд бүрэн гүйцэд төлөвшөөгүй, ертөнцийг үзэх үзэл тогтоогүй байдаг учир түүнийг хүрээлж буй гэр бүл, эцэг, эх, найз нөхөд, ойр дотны хэн нэгний нөлөөнд автахад маш амархан. Энэ байдал нь орчны таагүй нөлөө (архи дарс хэрэглэх, мансуурах байдалд орох)-гөөр амархан өдөөгдөж элдэв сөрөг зан төлөвтэй болох, гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөхөд хүргэдэг.

Хүүхдийн бие, сэтгэл зүйн онцлог нь сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхигүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн хувьд сул дорой байх, танилын буруу сонголт, өөрийгөө дутуу үнэлэх зэрэг нь хохирох эрсдлийг бүрдүүлэх бөгөөд уруу татагч, гэмт этгээдийн боломжийг нэмэгдүүлдэг байна.

Судалгаагаар насанд хүрээгүй хүмүүс 14-17 насандаа согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, 14-15 насанд тэдэнтэй хатуу ширүүн харьцах, 13-14 насандаа бэлэгсийн гэмт хэрэгт өртөх магадлал тус тус өндөр байна.

Түүнчлэн хүүхдийн бие, сэтгэл зүйн дээрх онцлог байдал, хууль эрх зүйн мэдлэг, эцэг эхийн хяналт муу зэрэг байдал нь гэмт хэрэгт уруу татагдах, гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болж байна. Учир нь бараг бүх насанд хүрээгүй хүмүүс өөрийн амьдралын дүр төрх, нөхцөл, хүрээлэн буй орчны нөлөө зэргээс гэмт хэрэг үйлдэхэд уруу татагдахад "бэлэн байдал"-д байдаг бөгөөд уруу татагдан гэмт хэрэг үйлдсэнээр тэдний бие, сэтгэлийн хөгжилд ноцтой гэм хор (гэмт хэрэг үйлдэх дадал зуршилтай болгох) учруулдаг, тухайн гэмт хэргийнхээ (ЭХ-ийн 16.1, 16.2) давхар хохирогчид юм.

**Субьектив шалтгаан:**

Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт явдлын субьектив шалтгаан: Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гажуудалд орсон эрэлт хэрэгцээ, ашиг сонирхол, зорилго, зан суртахууны үнэт зүйлс ба эрх зүйн ухамсараар илэрдэг нийгмийн сэтгэл зүйн тодорхой шинж юм.

Амьдралын зөв зан төлөвтэй хүмүүс нь нийгмийн оюун санааны баялаг шинжүүдийг өөртөө агуулж, өөрсдийн ажиллаж, амьдарч байгаа орчин тойрны хүмүүс, өөрийгөө хүндэтгэх үзлээр хүмүүжин, сайн ба муу, шударга болон шударга бус, үүрэг, хариуцлага, чин эрмэлзэл зэргийг зөв үнэлэн ялгах чадвар бүхий нинжин энэрэнгүй сэтгэлтэй байдаг.

Гаж буруу зан үйлтэй хүмүүсийн ухамсар, зан төлөвт доголдол гарч, үүрэг, хариуцлага, ичих, гэмшихийг умартаж түүний үндсэн дээр гэмт

явдлын шалтгаан үүсдэг. Эдгээр гэмт зан үйлтэй хүмүүс нь гэмт хэрэг үйлдэхэд бэлэн байх бөгөөд тэдний ухамсрын доголдолтой байдал нь гэмт хэрэг үйлдэхэд саад болохгүйгээр барахгүй харин дөхөм үзүүлж байдаг. Гаж буруу зан төлөвтэй хүмүүс гэмт зан үйлээ хэрэгжүүлэхэд насанд хүрээгүй хүмүүсийн балчир оюун, бие бялдарын хөгжлийн дутуу байдал нь тэдний субьектив ухамсарт шууд нөлөөлөх бөгөөд энэхүү байдал гэмт зан үйлийг хэрэгжүүлэх шалтгаан болдог байна. Тухайлбал: сэтгэл зүйн гажуудал нь хүүхдийн эсрэг харгис хэрцгий байдлаар илрэх ба бэлэгсийн гэмт хэрэг үйлдэхэд онцгой нөлөөтэй.

Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг төдийлөн буурахгүй байгаагийн нийтлэг шалтгаанд нэг талаас хүн амын дунд насанд хүрээгүйчүүдийн эзлэх хувь тогтвортой нэмэгдсэн, хотжилтийн үйл явц ихсэхтэй холбоотойгоор насанд хүрээгүй этгээд танхай, булаалт дээрэм, хүчингийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл шууд нэмэгдсэн, хотын хүн амын өсөлт автомашины хэрэглээний тогтвортой огцом өсөлт нь энэ хүрээн дэх болгоомжгүй гэмт хэрэг өсөхөд нөлөөлж байгаа, өсвөр үеийнхний зан үйл (бие физиологи, сэтгэл зүйн онцлог шинж), нийгмийн амьдралд хандах хандлагад гарсан сөрөг шинж чанар бүхий өөрчлөлт, иргэдийн салан задгай байдал, цагдаагийн байгууллагын хөдөлгөөнт эргүүлийн тогтолцоог татан буулгасан зэрэгтэй холбоотой бол нөгөө талаас цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх арга ажиллагаанд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан /гэмт хэрэг зөрчлийг талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авах шийдвэрлэх журам шинэчлэгдсэн, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажилллагааг шуурхай болгох зорилгоор нийслэл болон хүн ам ихээр төвлөрсөн хот суурин газруудад камерийн хяналт, цагдаагийн нэгж байгууллагын бүтэц орон тоог өөрчлөн иргэдэд ойртуулсан, иргэдийн зүгээс цагдаагийн байгууллагад хандах хандлагад эерэг өөрчлөлт гарсан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс насанд хүрээгүй этгээдэд тавих анхаарал халамж харьцангүй сайжирсан зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас 2013 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Ариусахуйн ертөнц" сэтгэл зүйн төв, сэтгэл заслын эмнэлгээр (судлаач Д.Эрдэнэбаатар (АУ-ны докторант), Э.Адъяасүрэн (сэтгэл зүйч)) "Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг судлах" чанарын судалгааг захиалан гүйцэтгүүлсэн байна. Уг судалгаанд 2013 онд ял хойшилсон 40 хүүхэд, тэдний эцэг эх 40 хүнийг хамрагдсан, нийт 40 хүүхдийн 47% нь дээрэм, 20% нь танхай, 17% нь хулгайн гэмт хэрэг, 70% нь дээрэм, танхайн гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн. Тэднээс 14-өөс доош насныхан нь ихэвчлэн хулгайн гэмт хэрэг

үйлдсэн бол 15-18 насныхан нь танхай, дээрмийн гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн; 58% нь эхийн, 17% нь эцэг, асран хамгаалагчдын асрамж халамжинд амьдардаг хүүхдүүд ээлж байна. Хэрэгт холбогдсон шалтгаанаа "үгүй гэж хэлж чадаагүй" 37%, "өөрийн мэдэлгүй" гэж 32% нь тайлбарласан нь хүүхдүүд насанд хүрэгчдэд болон үеийнхэндээ уруу татагддаг, сэтгэлийн хөөрлөөр гэмт хэрэг үйлддэг, хүүхдүүдийн асран хамгаалагч нь ихэвчлэн өрх толгойлсон эх, эцэг, тэдний үүрэг, оролцоо маш сул болсныг харуулсан байна. Оролцогчдын дунд явуулсан анкетийн болон фокус бүлгийн ярилцлагаар хүүхдийг хууль зөрчих, гэмт хэрэгт холбогдох, хохирохын суурь шалтгаан:

- ✓ Эцэг эхийн хайр халамж дутагдсан;
- ✓ Гэр бүлийн салалт;
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл;
- ✓ Хүүхдийн сургууль завсардалт;
- ✓ Гэр бүлийн ядуурал, ажилгүйдэл;
- ✓ Найз нөхдийн сөрөг нөлөө гэсэн бол

Гэмт хэрэг үйлдсэн тэдгээр хүүхдэд учирч буй хор нөлөөний талаар:

- ✓ Эзэнгүй хэрэгт тохогдох /зодох, гүтгэх, үг хэлээр доромжлох/;
- ✓ Гадуурхагдах /бүхий л орчинд/;
- ✓ Зодуулах /гэр бүлдээ, мөрдөн байцаалтын явцад/;
- ✓ Өөртөө итгэх итгэлгүй болох /өөрийн үнэлэмж буурах/;
- ✓ Сэтгэлийн хямралд орох;
- ✓ Айдас түгшүүрт автах;
- ✓ Хохирогч талын дарамтад орох зэрэг хор хохирол амссан гэсэн судалгааны дүн гарчээ.

Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг зарим (дийлэнх) гэмт хэргийн тоон судалгаан дээр үндэслэн судлан авч үзлээ.

*1.Бусдын амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг*

Бусдыг санаатай алах гэмт хэрэг:

Насанд хүрээгүй хүмүүсээс 2013-2019 онд бусдыг санаатай алах гэмт хэрэг нийт 26 үйлдэгдсэн ба бүх гэмт хэргийн 90 орчим хувь нь шууд санаатай үйлдэгджээ.

Бусад гэмт хэрэгтэй харьцуулахад энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж ихтэйгээс тоо нь бага байгаа нь ойлгомжтой бөгөөд дийлэнх нь амьдрах орон гэрт, өдрийн цагаар, ахуйн хүрээнд, хулгай, дээрэм, булаалтын гэмт хэрэг, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх нь нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх болсон.

*Судалгааны дүнд насанд хүрээгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэх нийтлэг*

*шалтгаан нөхцлийг дараах байдлаар тодорхойлж байна:*

1.Гэр бүлийн таагүй байдал. Насанд хүрсэн хүмүүсийн хатуу ширүүн харьцаа, гэр бүлийн хүйтэн хөндий уур амьсгал, гэр бүл салалт, хагас, бүтэн өнчин (эцэг эх нь нас барсан, шоронд байгаа), эцэг эх нь сэтгэцийн, хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хойд эцэг эхтэй, эцэг эх нь удаан хугацаагаар тусдаа амьдардаг (гадаадад, эсхүл малчин айл өрхийн хүүхэд сургуулийн насанд хүрэхээр аав нь малаа маллаад үлдэх, эх нь хүүхдээ аваад суман дээр ирж амьдрах тохиолдол их) зэрэг бөгөөд энэ бүхнээс шалтгаалан гэр бүлийн харилцаа холбоо сулрах, хүүхэд хараа хяналтгүй болох, тааламжгүй харьцаа үүсэх, гэр бүл салах, хүүхэд гэмт хэрэг үйлдэх, өртөж хохирох шалтгаан болж байна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын багийн засаг дарга А, иргэн Ц., Э., Ц., Х. нартай 2018 оны 01-р сарын 06-нд уулзаж ярилцахад 4 тус багт 68 өрх айл байдгийн 30 хувь нь буюу 21 өрхийн нөхрүүд нь хөдөө гэртээ малаа маллаж харин эхнэрүүд нь сумын төв дээр хүүхдүүдээ цэцэрлэг, сургуульд суралцуулан 2 тусдаа амьдарч өвөлжиж байгаа талаар ярьж байв. Яагаад 2 тусдаа өвөлждөг юм бэ? Суман дээр ЕБС-ийн дотуур байр байдаггүй юм уу? Эсвэл 4-5 айл нэгдээд ээлжээр суман дээр хүүхдээ харж сургуульд хамруулж болдоггүй юм уу? гэсэн асуултад:

- Хүүхдийг 6 наснаас сургуульд хамруулж байгаа нь хэтэрхий эрт учир эцэг эхээсээ хол сурахад бие даах насанд хүрээгүй балчирдаж байна.
- Нийгэмд ажилгүйдэл, архидалт их байгаа учраас гэмт хэрэг зөрчил нэмэгдсэн өнөө үед хүүхдээ асрах хүнгүй явуулах нь түгшүүртэй.
- Садан төрлийн холбоотой айлууд хүүхдүүдээ нийлүүлээд нэг эхнэр нь харж болох боловч хүүхдүүдийн зөрчилдөөн эцэг эхэд нь нөлөөлдөг.
- Хүүхдүүдээ сумын төвд гэр барьж тусад нь гаргахаар эсвэл дотуур байранд оруулахаар хараа хяналт суларч гэмт хэрэг зөрчилд холбогдох, муу зан авир сурах, тэнэмэл хичээл сургуульдаа дургүй болох улмаар хичээл таслах, хоцрогдох эрт бэлгийн харьцаанд орж жирэмслэх магадлал өндөр байдгаас аргагүйн эрхэнд эцэг эх хоёрын аль нэг нь биечлэн хүүхдүүдтэйгээ сумын төвд амьдрахаас аргагүйд хүрдэг гэж хариулсан болно.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүс болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн ар гэр, хувийн зан байдлын тодорхойлолтоос ажилгүйдлын өсөлт нь уг гэмт хэргийн өсөлтийг дагуулахаар байна.

2.Эцэг эхийн хараа хяналт. Байнгын анхаарал халамж дутагдаж гадуур тэнэх, шөнийн цагаар хараа хяналтгүй явах, насанд хүрэгчдийн хууль бус үйл ажиллагаанд уруу татагдах, дарамт шахалтанд өртөх, зан

төрх нь өөрчлөгдөх, буруу зан үйл бүхий үе тэнгийнхний нөлөөнд автах, дээрэлхүүлэх, хууртах, сонирхох, сургуулиас хөндийрч сургууль завсардах, элдэв төрлийн хортой бодис хэрэглэдэг болох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болох, эцэстээ гэмт хэрэгтэн болох магадлал өндөр байна. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн дийлэнх нь бэршээлтэй асуудлууд тохиолдвол эцэг, эх, багш, нийгмийн ажилтнуудад хэлэхгүй, учир нь тэд ойлгохгүй, ганц нэг хүүхэд л "ээждээ хэлнэ" гэжээ.

Цагдаагийн нэгж байгууллагад шалгагдаж буй насанд хүрээгүй этгээдийн дунд явуулсан бидний судалгаагаар: нийт 57 оролцогчдын 85.5% нь эрэгтэй; 65% нь 14-18 насныхан; 14% нь орон гэргүй; 48% нь ажил сургуульгүй; 47.3% нь мөнгөний хэрэгцээгээ хангах зорилгоор гэмт хэрэг үйлдсэн; 65% нь согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн; 93.8% (давхардсан тоогоор) гэр бүл салалт г.м. таагүй амьдралтай гэр бүлд амьдарч байсан байна. ЦЕГ-ын МНБГ-ын тоон судалгаанд дүн шинжилгээ хийхэд 2013-2019 онд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн нийт гэмт хэргийн 7.3% нь хулгай, 4.3% дээрмийн хэрэг; гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдүүдийн талаас илүү хувь нь орлого багатай, эсхүл огт орлогогүй, боломж муутай гэр бүлд амьдардаг байна.

Гэмт хэрэгт өртөж хохирсон насанд хүрээгүй хохирогчдын дунд явуулсан судалгаагаар: "хохирогч согтууруулах ундаа, мансууруулах эм, бодис хэрэглэж үзсэн эсэх" гэсэн асуултад 6% нь "тийм"; "Эцэг эхийн зүгээс өөрт нь хангалттай анхаарал халамж тавидаг гэж үздэг эсэх" гэсэн асуултад 59% нь "үгүй" гэж хариулсан нь эцэг эхийн хяналт сулыг илтгэж байна.

Хүүхдэд тавих эцэг эхийн хараа хяналт сулаас насанд хүрээгүй хүүхдээ шөнийн цагаар хаана юу хийж байгааг болон ямар хүүхдүүдтэй найзалж байгааг анхаардаггүйгээс болж хүүхэд гэмт хэрэгт уруу татагдаж байна.

3.Архидан согтуурал, мансуурал, томчуудын зүй бус авирлал.

Судалгаанд хамрагдсан насанд хүрсэн ялтнуудын 59.1%; гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдүүдийн 42.8% нь согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн байна.

Хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлөх томчуудын сөрөг зан үйлийн нөлөөлөл буюу архидалт, сэтгэцийн гажуудал, гэмт зан үйл нь хүүхдийн бие хүн болж төлөвших явцад сөргөөр нөлөөлж, ёс суртахуунгүй байдал нь хүүхдэд "хэвийн" үзэгдэл мэт харагдах болж, тэдний гэмт зан үйлийг давтах эрсдэлийг дагуулдаг.

Судалгаанд оролцогчдын 58 хувь нь гэмт хэрэг үйлдэх үедээ согтууруулах ундааны зүйл, 1.1 хувь мансууруулах эм, бодис хэрэглэсэн

байсан гэж хариулсан; "хохирогчтой урьд өмнө нь танил байсан эсэх" гэсэн асуултад "Тийм" гэж 44 хувь нь хариулсан нь танил тал, найз нөхдийн хүрээнд архидан согтуурч гэмт хэрэг үйлдэгдэх нь их болохыг харуулж байна.

4.Гэр бүлийн хүчирхийлэл.

Манай нийгэмд оршсоор байгаа "олгой хагаравч тогоондоо", "эхнэр, ямаа хоёрыг сардаа нэг удаа номхруулж бай", "эр, эмийн хооронд илжиг бүү жороол", "алганы амт үзүүлэх нь хүмүүжлийн зөв арга мөн" г.м. уламжлалт буруу ойлголт хандлага нь гэр бүлийн хүчирхийллийг зөвтгөх, нийгмийн хяналтыг сулруулах; нөгөө талаас эцэг эх (асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн зүгээс хүүхдэдээ үндэсний сайхан зан заншил, уламжлал, хүмүүнлэг, хөдөлмөрч, шударга зан чанар, хүүхдийн дундах маргааныг дэвэргэх бус зөвөөр шийдвэрлэх асуудалд сургах, хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх нь учир дутагдалтай байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэхэд нөлөөлөх гол хүчин зүйлс нь "эвдэрсэн" гэр бүлийн харилцаа (байнгын хэрүүл маргаан, халамж анхаарал тавихгүй байх), хүүхэд хүсэхгүй байх, ажилгүйдэл, нийгмээс тусгаарлагдмал байдал, санхүүгийн бэрхшээл зэрэг байна.

Насанд хүрээгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэх, хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирч байгаагийн шалтгаан нөхцлийг тодруулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нийт 24 хорих ангид ял эдэлж буй ялтнууд болон нийслэлийн 6 дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд шалгагдаж байгаа гэмт этгээдүүдээс авсан социологийн судалгаагаар: нийт 556 оролцогчдоос "Таны ар гэрт дараах ямар нэгэн таагүй байдал тохиолдож байсан уу?" гэсэн асуултад гэр бүл салалт, байнгын маргаантай байдаг гэж 43 хувь, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэж 0.5 хувь, эцэг эхийн аль нэг нь архины мансууруулах эм бодисын) хамааралтай гэж 1.4 хувь буюу тал (44.9%) хувь нь таагүй уур амьсгалтай гэр бүлд амьдардаг гэж хариулсан байна. Хүүхдийн байгууллагын ажилтан эцэг, эх/-уудаас авсан санал асуулгаар: Таны бодлоор доор дурдсанаас аль ангиллын хүүхдүүд илүү их гэмт хэргийн хохирогч болж байна вэ? гэсэн асуултад хамгийн их хариултыг "гэр бүлийн хүчирхийлэл" гэж хариулсан байна.

2006 оноос өмнө дээрх байдлаас 5500 орчим хүүхэд гэр бүлээсээ дайжиж, гудамжинд амьдрах болсон, тэдгээрээс багагүй хэсэг нь хоорондоо гэр бүл болсон, одоог хүртэл амьдралын хүнд хэцүү амьдралаар амьдарч байгаа талаар хүүхдийн байгууллагын ажилтнууд, Нартхангай хүүхэд хөгжлийн сургалтын төвийн хүүхдүүд ярьж байна. ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын судалгаагаар улсын хэмжээнд нийт 81 (үүнээс: нийслэлд 40, эрэгтэй 64,

эмэгтэй 14) хүүхэд байдаг; хүүхдийн байгууллагын судалгаагаар 57 тэнэмэл хүүхэд байна гэсэн судалгаа нь гэр орноосоо дайжин амьдарч байгаа хүүхдийн бодит тоо зөрүүтэй байна.

...Өөрийн үлгэр жишээч зан төлөв, хөдөлмөр сургалтад үнэнчээр хандаж засарч хүмүүжсэнээ нотолж чадсан 18 насанд хүрээгүй этгээдийг хугацаанаас нь өмнө суллах, түүний ялын үлдсэн хугацааг өөр хөнгөн ялаар солих саналаа засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой зөвшөөрөлцөн шүүхэд тавина.

...Хүмүүжил-хөдөлмөрийн колониос суллагдсан 18 нас хүрээгүй хүмүүсийг тэдний эцэг, эх, ойрын садан төрөл, хууль ёсны асран хамгаалагчийн байгаа газар хүргэж хүлээлгэн өгнө хэмээн тусгасан байна.

ÍÀÕßàì, Àðäûí áîëîâñðîëûí ÿàìíû ñàйäûí 134\241 òîîò òóøààëààð 1968 îíä Õүìүүæèë õөäөëìөðèéí êîëîíèéí ñóðãààëòûí ñèñòåìä өөð÷лөëò îðóóëàõ øèéäâýð ãàðãààæ ñóðãààëòûí ñèñòåìèéã үéëäâýð ñóðãààëòûí ÷èãëýëýýð ìýðãýæèë ýçýìøóүëýõ æóðàì òîãòîîæ æèë áүðèéí õè÷ýýëèéã 11 äүãýýð ñàðûí 1-үэñ 4 äүãýýð ñàðûí 1 õүðòýë õè÷ýýëүүëæ õөäөө aæ aõóéí ìaøèí çàñâàðûí ñëåñàðèéí êóðñ, çàëóó ìàë÷äûí ñóðãóóëü, òðàêòîð êîìáàéíû æîëîî÷èéí êóðñ, õүíñíèé íîãîîíû aæ aõóé çýðýã ñýäâýýð òóñ áүð 480 öàãèéí õè÷ýë çàaõaað òîãòñîí áàéíà. Yүíýýñ ãààíà åðөíõèé áîëîâñðîëûí ñóðãàëòûã ÿâóóëæ õè÷ýýëèéí öàãèéã òîãòîîæýý.

1972 îíîîñ ýõëýí ìөí ñóðãàëòûí ïðîãðàììä äàõèí өөð÷ëөëò îðóóëæ 3 äaõèa өөð÷èëñөí áaéíà. 1970- 1976 îíû õè÷ýýëèéí æèëүүäýä 5 óäààãèéí êóðñ òөãñãөæ 128 õүүõäèéã ìýðãýæèë ýçýìøүүëñýí ãýõ áàðèò áàéäýã áàéíà. Àðäûí Èõ Õóðëûí Òýðãүүëýã÷äèéí 1981 îíû 11 äүãýýð ñàðûí 16-íû өäðèéí 403 òîîò

çàðëèãààð Çàñàí õүìүүæүүëýõ õөäөëìөðèéí õóóëèéã áàòëàæ óëìààð 1982 îíû 7 äóãààð ñàðûí 1-ýýñ ýõëýí ìөðäñөí áàéíà. Өìíөõ õóóëèéã øèíý÷ëýí ìөðäөõ áîëñîí øàëòãààí íü òóõàé үåèéí íàìûí øèéäâýðүүäèéã õóóëüä òóñãàõ, ÿë ýäëүүëýõ áàéãóóëëàãûí áүòýö çîõèîí áàéãóóëàëò үүðýã çîðèëòûã øèíý÷ëýí òóñãàõòàé õîëáîî àâ÷ үçñýí áàéíà.

Õóóëüä ìөí õîðèõ äýãëýìèéã òóñãàõûí çýðýãöýý íàñàíä õүðýýãүé ýòãýýäèéí õóâüä õүìүүæèë õөäөëìөðèéí êîëîíèéí æèðèéí äýãëýìä õүíä áèø ãýìò õýðýãò àíõ óäàà õîðèõ ÿë øèéòãүүëñýí, õүíä ãýìò õýðãýò 3 æèëýýñ äýýøãүé õóãàöààãààð àíõ óäàа õîðèõ ÿë øèéòãүүëñýí íàñàíä õүðýýãүé ýðýãòýé÷үүä, ÷àíãà äýãëýìä óðüä õîðèõ ÿë ýäýëæ áàéñàí, õүíä ãýìò õýðãýò 3 æèëýýñ äýýø õóãàöààãààð õîðèõ ÿë øèéòãүүëñýí íàñàíä õүðýýãүé ýðýãòýé÷үүäèéí õîðèõ ÿëûã òóñ òóñ ýäëүүëýõýýð çààæýý. Òүүí÷ëýí íàñàíä õүðýýãүé ýòãýýäèéí õóâüä åðөíõèé áîëîâñðîëûí ñóðãàëòаä áүðýí õàìðóóëàõ, ìýðãýæèë îëãîõ, õөäөëìөðèéí äàäëàãà îëãîõ ñóðãàëòàä õàìðóóëíà ãýæ çààñàí íü òүäíèé çàñðàë õүìүүæèëä òîäîðõîé àíõààðàë òàâüæ áàéñíû èëðýë ìөí.

ÀÈÕ-ûí Òýðãүүëýã÷äèéí 1986 îíû 12 äóãààð ñàðûí 5-íû өäðèéí 217 òîîò çàðëèãààð Эðүүãèéí õóóëèéã øèíý÷ëýí íàéðóóëæ 5 áүëýã 59 çүéëòýé, òóñãàé àíãè 13 áүëýã 301 çүéëòýéãýýð áàòëààä 1987 îíû 7 äóãààð ñàðûí 1-ýýñ ýõëýí äàãààæ ìөðäөõ áîëñîí áàéíà. Ýðүүãèéí õóóëèéí 9 äүãýýð çүéëä Íàñàíä õүðýýãүé ýòãýýäýä õүëýýëãýõ ýðүүãèéí õàðèóöëàãààóþó ñóáúåêòûí íàñíû õүçààðûã 16 íàñààð, 14-16 õүðòýëõ íàñíû ýòãýýä 22 òөðëèéí ãýìò õýðãèéí ñóáúåêò áîëîõîîð òîãòîîñîí. Ýíý íü өìíөõ õóóëüä çààñàí ãýìò õýðãèéí òîîíîîñ íýìýãäәæýý.

БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн **1981 оны 11 дүгээр сарын 16-ны** өдрийн 403 дугаар зарлигаар БНМАУ-ын **“Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”**[9] батлагдан гарч, 1982 оны 07 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын дотор ял эдлүүлэх ажиллагааг зохицуулах 3 дахь хууль байлаа.

Энэхүү хуулинд насанд хүрээгүй хүмүүсийн чүүдийн талаар тусгай нэг бүлэг /XIII бүлэг/ болгон тусгасан бөгөөд хүмүүжил-хөдөлмөрийн колонийн дэглэмийг ангилж өгсөн байна. Тус хуульд насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн байдлыг хангах чиглэлд дараах зохицуулалтуудыг тусгажээ. Үүнд:

Гуравдугаар бүлэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын төрөл, түүнд ялтныг шилжүүлэх, ял эдлүүлэх журам.

11 дүгээр зүйл. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын төрөл.

Хорих ял эдлүүлэх засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь

---

[9] Мөн бүтээл

засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гяндан, хүмүүжил хөдөлмөрийн колони гэсэн төрөлтэй байна.

...18 хүртлэх насны ялтны ялыг хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлнэ.

17 дугаар зүйл. Ялтныг тусгайд нь байлгах.

...насанд хүрээгүй хүмүүсийг насанд хүрэгчдээс тусгайд нь байлгана.

...хорих ял шийтгүүлсэн эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг энэ хуульд заасан журмын дагуу тусгайд нь байлгана.

Хорих ял эдлэж байх хугацаандаа гэмт хэрэг санаатай үйлдэж шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүс, түүнчлэн ял эдлэх дэглэмийг байнга буюу ноцтойгоор зөрчигчдийг чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа бусад ялтнуудаас... тусгайд нь байлгана.

18 дугаар зүйл. Ялтны ялыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн нэг байгууллагад эдлүүлэх.

Хорих ял шийтгүүлсэн ялтны ялын бүх хугацааг нэг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони буюу хүмүүжил хөдөлмөрийн колони буюу хүмүүжил-хөдөлмөрийн колони, гяндanд эдлүүлнэ.

20 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлсэн ялтны ял эдлэж байгаа нөхцөлийг өөрчлөх.

...хүмүүжил-хөдөлмөрийн жирийн дэглэмтэй колониос хүмүүжил-хөдөлмөрийн чанга дэглэмтэй колонид шилжүүлэх замаар ялтны ял эдлэж байгаа нөхцөлийг энэ хуулийн 49, 51 дүгээр зүйлд заасан үндэслэлийг баримтлан шүүх өөрчилнө.

Дөрөвдүгээр бүлэг. Хорих газрын дэглэм.

23 дугаар зүйл. Ялтан хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах.

...хөдөлмөрийн чадваргүй буюу насанд хүрээгүй, жирэмсэн эмэгтэй ялтан гуйвуулгаар авсан мөнгөөрөө хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахыг зөвшөөрнө.

27 дугаар зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтанд эргэлт, илгээлт оруулах.

Хүмүүжил хөдөлмөрийн колонид хорих ял эдлэж байгаа ялтанд жилд 6 удаа хүртэл эргэлт, илгээлт оруулахыг зөвшөөрнө.

33 дугаар зүйл. Аюулгүй байлгах арга хэмжээ авах, зэвсэг хэрэглэх үндэслэл.

...Эмэгтэй буюу насанд хүрээгүй ялтанд номхотгох цамц өмсгөж болохгүй.

...эмэгтэй буюу насанд хүрээгүй ялтныг оргон зугтаахад зэвсэг

хэрэглэж болохгүй.

Тавдугаар бүлэг. Хорих ял эдлэж байгаа ялтны хөдөлмөр.

36 дугаар зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтны хөдөлмөрийн нөхцөл.

...Хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтны ажлын өдрийн үргэлжлэл, түүнчлэн долоо хоног бүрийн амралтын өдрийг БНМАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоомжийг баримтлан тогтооно.

37 дугаар зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтны хөдөлмөрийн хөлс.

...Хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа, дэглэм зөрчөөгүй ялтны сарын хөлсний 25-аас доошгүй хувийг аливаа суутгал харгалзахгүйгээр түүний нэрийн дансанд хийнэ.

38 дугаар зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх.

...Насанд хүрээгүй болон тахир дутуугийн I, II группэд байгаа ялтанд хоол хүнс, хувцас, цагаан хэрэглэлийг үнэ төлбөргүй олгоно.

Долдугаар бүлэг. Хорих ял эдлэж байгаа ялтанд ерөнхий боловсрол, мэргэжил олгох.

47 дугаар зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтанд мэргэжил олгох сургалт.

... хүмүүжил-хөдөлмөрийн колонид мэргэжил олгох сургалтыг ажлын цагаар явуулна.

48 дугаар зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтныг шалгалтын үед ажлаас чөлөөлөх.

Ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтын шалгалтад бэлтгэх, шалгалт өгөхөд зориулан хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтныг колонийн дарга хууль тогтоомжид заасан хугацаагаар ажлаас чөлөөлнө.

Наймдугаар бүлэг. Хорих ял эдлэж байгаа ялтны урамшил, сахилгын арга хэмжээ.

49 дүгээр зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтныг урамшуулах.

...хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтанд сард 10 төгрөг нэмж зарцуулахыг зөвшөөрөх.

51 дүгээр зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтанд оногдуулах сахилгын арга хэмжээ.

...хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа ялтанд спорт тоглоомд оролцох, кино, концерт үзэхээс нэг удаа хасах.

... хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа ялтныг 10 хоног хүртэл сахилгын тусгаарласан байранд тус тус шилжүүлэх.

...хүмүүжил-хөдөлмөрийн колонийн жирийн дэглэмээс хүмүүжил-хөдөлмөрийн колонийн чанга дэглэмд шилжүүлэхээр тодорхойлж болно.

Есдүгээр бүлэг. Хорих ял эдлэж байгаа ялтны ахуй хангамж эмнэлгийн үйлчилгээ.

54 дүгээр зүйл. Хорих ял эдлэж байгаа ялтны ахуй хангамж.

...Жирэмсэн эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүс, түүнчлэн өвчтэй ялтны орон сууц ахуйн нөхцлийг сайжруулж, хоолыг нэмэгдүүлсэн нормоор өгнө.

Арвангуравдугаар бүлэг. Хүмүүжил-хөдөлмөрийн колони.

70 дугаар зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн төрөл.

Хүмүүжил хөдөлмөрийн колонийг жирийн, чанга дэглэмтэй гэж хуваана.

71 дүгээр зүйл. Жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колони.

Хүнд биш гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны ялыг жирийн дэглэмтэй колонид эдлүүлнэ.

Насанд хүрээгүй бусад ялтны ялыг БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлж болно.

Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтныг эмэгтэйчүүдийн жирийн дэглэмтэй колонийн тусгай хэсэгт хүмүүжил-хөдөлмөрийн колонийн жирийн дэглэмд ял эдлүүлнэ.

Жирийн дэглэмтэй хүмүүжил- хөдөлмөрийн колонийн ялтан

-Ердийн орон сууцанд байна.

-Хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахад сард 50 төгрөг зарцуулна.

-Жилд 4 удаа удаан хугацаагаар эцэг, эх ах, эгч дүү, өвөг эцэг, эмэг эхтэйгээ уулзана.

-Жилд 8 удаа түр хугацаагаар уулзалт хийнэ.

-Жилд 6 удаа эргэлт, илгээлт авна.

-Захидлын тоо хязгаарлахгүйгээр явуулна.

Зан төлвөөр сайн, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, ялын ¼ хувийг эдэлсэн, ялтны ял эдлэх нөхцлийг сайжруулж болно. Энэ тохиолдолд хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахад сард 20 төгрөг нэмж зарцуулах, жилд 4 удаа түр хугацааны нэмэлт уулзалт хийхийг зөвшөөрнө.

72 дугаар зүйл. Чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колони.

Урьд нь хорих ял эдэлж байсан анх удаа боловч хүнд гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн, түүнчлэн энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасныаар жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колониос шилжиж ирсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны ялыг чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлнэ.

Чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонийн ялтан:

-Ердийн орон сууцанд байна.

-Хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахад сард, жилд 3 удаа удаан хугацаагаар эцэг, эх ах, эгч дүү, өвөг эцэг, эмэг эхтэйгээ уулзана.

-Жилд 4 удаа түр хугацаагаар уулзалт хийнэ.

-Захидлын тоо хязгаарлахгүйгээр явуулна.

Зан төлвөөр сайн, хөдөлмөр, сургалтад үнэнч шударга ханддаг, ялын 1/3 хувийг эдэлсэн ялтны ял эдлэх нөхцлийг сайжруулж болно. Энэ тохиолдолд хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахад сард 15 төгрөг нэмж зарцуулах, жилд 2 удаа түр хугацааны нэмэгдэл уулзалт хийхийг ялтанд зөвшөөрнө.

73 дугаар зүйл. Ялтныг хүмүүжил-хөдөлмөрийн колониос Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх.

Хүмүүжил хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтныг 18 нас хүрмэгц үлдсэн ялыг эдлүүлэхээр жирийн дэглэмтэй хүмүүжил хөдөлмөрийн колонид, чанга дэглэмтэй хүмүүжил хөдөлмөрийн колонид байсан ялтныг түүний үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, хувийн байдал, зан төлөв засрал хүмүүжлийг харгалзан засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн жирийн буюу чанга дэглэмтэй колонид тус тус шилжүүлнэ.

18 насанд хүрсэн ялтныг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх асуудлыг БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 355 дугаар зүйлд заасан журмаар шүүх шийдвэрлэнэ.

74 дүгээр зүйл. Насанд хүрсэн ялтныг хүмүүжил-хөдөлмөрийн колонид үлдээх.

18 насанд хүрсэн ялтан засарч хүмүүжих замд баттай орсон бол засарч хүмүүжсэн үр дүнг бататгах, ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтыг дуусгах зорилгоор хүмүүжил-хөдөлмөрийн колонид ялын хугацааг дуустал үлдээж болох боловч 20 наснаас хэтрүүлж болохгүй.

18 насанд хүрсэн ялтныг хүмүүжил-хөдөлмөрийн колонид үлдээх асуудлыг насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой тохиролцон прокурорын зөвшөөрөлтэйгээр колонийн даргын тогтоолоор шийдвэрлэнэ.

Хүмүүжил-хөдөлмөрийн колонид үлдээсэн 18 насанд хүрсэн ялтанд насанд хүрээгүй ялтанд тогтоосон дэглэм, хөдөлмөрийн нөхцөл, хоолны норм, ахуй хангамжийг хэрэглүүлнэ.

Арваннаймдугаар бүлэг. Ял эдлэхээс чөлөөлөх үндэслэл.

103 дугаар зүйл. Хорих газраас ялтныг суллах журам.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь суллагдаж байгаа насанд хүрээгүй хүнийг эцэг, эх буюу тэднийг төлөөлөх хүмүүст нь

явуулна. Хэрэв ийнхүү явуулах боломжгүй байвал ял эдлэхийн өмнө оршин сууж байсан орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисст хүргүүлнэ. Уг комисс суллагдсан хүнийг хүлээж аваад засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн захиргааны санал, суллагдсан хүний эзэмшсэн мэргэжил, боловсролыг харгалзан ажилд буюу сургуульд оруулах, түүнчлэн шаардлагатай орон байр, ахуй нөхцлөөр хангах арга хэмжээ авна.

Насанд хүрээгүй хүнийг ял эдлэхийн өмнө оршин сууж байсан газарт явуулах нь түүний хүмүүжлийн хувьд зохимжгүй гэж үзсэн онцгой тохиолдолд засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн захиргааны саналаар уг колонийн оршин байгаа газрын дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс түүний ажил, сургууль, ахуй амьдралыг зохион байгуулна.

Хорих газраас суллагдсан бөгөөд бусдын асрамж шаардлагатай, түүнчлэн 16 нас хүрээгүй хүмүүсийн оршин суух газарт нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтан хүргэж өгнө.

Арванесдүгээр бүлэг. Ялаас чөлөөлөгдсөн хүмүүст үзүүлэх тусламж.

106 дугаар зүйл. Ялаас суллагдсан хүмүүсийг ажлаар хангах, тэдний ахуйн нөхцлийг зохион байгуулахад туслах.

Эцэг, эхгүй насанд хүрээгүй хүнийг насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс зайлшгүй тохиолдолд дотуур байртай сургууль буюу хүүхдийн бусад байгууллагад шилжүүлэх, эсвэл хуульд заасан журмаар асран хамгаалалт тогтооно.

Хоринхоёрдугаар бүлэг. Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцоо.

113 дугаар бүлэг. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс.

Хүмүүжил- хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэж байгаа насанд хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэхэд болон энэ хоёр төрлийн ял шийтгэсэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс шууд эрхлэн хэрэгжүүлнэ.

Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын зорилт, эрх, үүрэг, ажлын зохион байгуулалтыг энэ хууль болон БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс баталсан насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын дүрмээр тодорхойлно.

115 дугаар зүйл. Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн олон нийтийн зөвлөл.

Шефлэн авах ажлыг зохион байгуулах зорилгоор хүмүүжил-хөдөлмөрийн колонид төрийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, залуучуудын эвлэл болон бусад олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олны төлөөлөгчдөөс бүрдсэн олон нийтийн зөвлөл байгуулан ажиллуулна.

Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнд колонийн дарга эсвэл түүний орлогч оролцоно.

Олон нийтин зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс баталсан дүрмээр тодорхойлно.

116 дугаар зүйл. Ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийн олон нийтийн хүмүүжүүлэгч.

Насанд хүрээгүй хүмүүсийн засрал хүмүүжлийг бататгаж, дахин хууль зөрчихөөс урьдчидлан сэргийлэх зорилгоор ял эдлэж дууссан буюу ялын хугацаа дуусахаас өмнө сулллагдсан насанд хүрээгүй хүмүүст олон нийтийн хүмүүжүүлэгч томилж болно.

Олон нийтийн хүмүүжүүлэгчийг томилох журам, түүний үйл ажиллагааг БНМАУ-ын СнЗ-өөс баталсан дүрмээр тодорхойлно гэж тус тус заажээ.

Дээрх хуулиудын хорих ял эдлэгсдийн сургалтын талаарх заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр нилээд хэдэн эрхийн акт гарч хэрэгжиж байсны дотор Нийгмийг аюулаас хамгаалах яам, Ардын боловсролын яамны сайд нарын 1986 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн **"Ялтны дунд явуулж байгаа ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалтын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай"** А/78/360 тоот хамтарсан тушаал чухал суурийг эзэлдэг. Энэ тушаалд:

"Дарьт дарь хүмүүжил хөдөлмөрийн колонийн ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, хичээл тус бүрийн программыг шинэчлэн боловсруулж, 1987-1988 оны хичээлийн жилээс мөрдүүлэх, колонийн ерөнхий боловсролын сургалтыг удирдах ажилыг Зүүнхараа хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуульд харицуулах, колонид ажиллах ерөнхий эрдмийн хичээлийн багш нарыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын удирдах газрын захиалгаар Ардын боловсролын яамнаас шууд томилж байх" -аар заасан байна.

Мөн ял эдэлж байх хугацаандаа бүрэн бус ба бүрэн дунд сургуулийг ажилттай төгсөөд суллагдсан ялтныг Техник мэргэжлийн сургуульд элсүүлэх, их, дээд, тусгай дунд сургуулиудын уралдаанд шалгалтанд оруулж байхаас гадна, сургуулиудын уралдаант шалгалтанд оруулж байх, суллагдах үедээ 16 нас хүрээгүй хүүхдийг ерөнхий боловсролын сургуулийн зохих ангид нь шилжүүлэн сургаж байхыг холбогдох яам,

газруудад үүрэг болгон хэрэгжүүлж байжээ.

1990 оны 7 сарын 06-ны өдөр гарсан БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны сайд, Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий Газрын даргын **"Ялтны дунд явуулах мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтад өөрчлөлт оруулах тухай"** Б/434, 215 тоот тушаал болон 1990-ээд оны дундуур хорих байгуулагуудыг удирдах газраас Шинжлэх ухаан боловсролын байгууллагатай хамтран гаргасан **"Хоригдлын сургалтын хөтөлбөр"** /1994-1996/-д хүүхдийн хүмүүжил, хөдөлмөрийн ангийн суралтын тал дээр шинэлэг зүйл төдийлэн тусгагдаагүй байна.

1992 îíä Ìîíãîë óëñûí øèíý Yíäñýí õóóëü áàòëàãäàaí ãàðñàíòàé õîëáîîòîéãîîð Yíäñýí õóóëèéí үçýë áàðèìòëàëûã àãóóëãàòàé óÿëäóóëàí ýðүүãèéí õóóëèéã өөð÷ëөõ øaaðäëaãa çүé ¸ñîîð òóëãaðñaí þì. Òóõàéí үåä Ýðүүãèéí õóóëüä çàð÷ìóóäûã àíõ óäàà õóóëü÷ëàí òîãòîîñîí áà ãýìò õýðãèéí àíãèëàëûã õөíãөí, õүíäýâòýð, õүíä, îíö õүíä õýìýýí òîäîðõîéëñîí, ÿëûí çàðèì òөðөë õýëáýðүүä Yíäñýí õóóëèéí үçýë áàðèìòëaëòýé íèéöýõýý áîëüñîí òóë õýä õýäýí ÿëûí òөðëèéã õóóëèañ õaññaí, òóñãaé aíãèéí õóâüä çaðèì òөðëèéí ãýìò õýðãèéã õóóëèañ õañ÷, çaðèì үéëäýë ýñ үéëäýõүéã ãýìò õýðýãã òîîöîõ áîëîí çýðèì ãýìò õýðãèéí ñàíêöèä òóñ òóñ өөð÷ëөëòүүäèéã îðóóëñàí áàéía. Èéíõүү Ýðүүãèéí õóóëüä íýìýëò өөð÷ëөëò îðóóëaõ aæèëëaãaa 1994-2001 îíóóäýä òîãòîîë õèéãäýæ áaéñaí áөãөөä 2002 îíû Ýðүүãèéí õóóëü áýòëýãäýõ õүðòýë íèéòäýý 17 óäýý íýìýëò өөð÷ëөëò îðóóëæýý. Ýäãýýðýýñ íañaíä õүðýýãүé ýòãýýäýä õүëýýëãýõ ýðүүãèéí õaðèóöëaãa, ÿëûí òóõaéä þóíû өìíө 14-16 íañíû ýòãýýäýä ÿë îíîãäóóëaõ ãýìò õýðãèéã õañ÷ íèéò 14 ãýìò õýðýãò ÿë îîîõîîð, õîðèõ ÿëûí õóãaöaàã 6 ñàðaàñ 15 æèëýýð òîãòîîæ óëìaað 18 íañaíä õүðýõèéí өìө ãýìò õýðýã үéëäñýí áîë 15 æèëýýñ äýýø õóãaöaaãaað õîðèõ ÿë îíîãäóóëaõãүé, ìөí õөíãөí áóþó õүíäýâòýð ãýìò õýðýãò aíõ óäàà õîðèõ ÿë øèéòãүүëñýí áóþó õүíä, îíö õүíä ãýìò õýðýãò 3 æèëýýñ äýýøãүé õóãàöààãààð aíõ óäaa õîðèõ ÿë øèéòãүүëñýí íañaíä õүðýýãүé эðэãòэé÷үүä, õîðèõ ÿë øèéòãүүëñçí íàñàíä õүðýýãóé ýìýãòэé÷үүäиéí õoðиõ ÿëûã æèðèéí äýãëýìòýé õîðèõ àíãèä, óðüä õîðèõ ÿë ýäýëæ áàéñàí áóюу õүнд, îíö õүíä ãýìò õýðýãò 3 æèëýýñ äýýø õóãàöaaãaað õîðèõ ÿë øèéòòүүëñýí íàñàíä õүðýýãүé ýðýãòýé÷үүäèéí õîðèõ ÿëûã ÷àíãa äýãëýìòýé õîðèõ aíãèä òóñ òóñ ýäëүүëýõýýð өөð÷ëөëò îðóóëæýý. Õóóëèéí 42 äóãýýð çүéëä íañaíä õүðýýãүé ýòãýýäýä õîðèõ ÿë îíîãäóóëñýí òañëaí øèéäâýðëýõ òîãòîîë áèåëүүëýõèéã õîéøëóóëàõ àñóóäëûã òóñãàñàí áөãөөä òîäîðõîé òөðëèéí ãýìò õýðãүүä үéëäýæ õîðèõ ÿëàað øèéòãүүëñýí áîë õýðýãëýõãүéãýýð өөð÷ëөí íàéðóóëæýý.

Õóóëèéí 53 äóãààð çүéëä 18 íàñaíä õүðýõèéí өìө ãýìò õýðýã үéëäñýí ýòãýýäèéã ÿëaañ õóãaöaàíû өìө ñóëëàõ áóþó õөíãөí ÿëààð ñîëèõ añóóäëûã íàñàíä õүðýãñýäýýñ өөðөөð òîãòîîñîí áөãөөä ìөí òîäîðõîé òөðëèéí ãýìò õýðýã

үéëañýí òîõèîëãîëä õýðýãëýõãүéãýýð òîãòîîñîí áàéíý.

Íàñàíä õүðýýãүé ýòãýýäýä õýðýãëýõ õүìүүæëèéí ÷àíaðòaé àëáàäëaãûí àðãà õýìæýýã 1995 îíû íýìýëò өөð÷ëөëòөөð õóóëèàñ õàññaí áà ýíý íü íàñàíä õүðýýãүé ýòãýýäèéí ýðõ àøèãò õýðøèëñýí øèéäâýð áîëñîí þì.

Õîðèõ áàéãóóëëàãûí áîëîí õîðèõ ÿë ýäëүүëýõ òóõàé õóóëü 1993 îíû 12 äóãààð ñýðûí 6-íä áàòëàãäààí xîðèõ áàéãóóëëaãûí òîãòîëöîî, çîõèîí áaéãóóëàëò, õîðèõ áàéãóóëëàãûí àæèëòíû ýðõ çүéí áàéäaë çýðãèéã õóóëüä øèíýýð òóñãàæ өãñөí áàéíà. Íàñàíä õүðýýãүé ýòãýýäèéí õîðèõ ÿëûã ýäëүүëýõ òóõàéä þóíû өìíө Ýðүүãèéí õóóëèéí çààëòòàé óÿëäóóëàí òóõàéí äýãëýìä ÿë ýäëүүëýõ àñóóäëûã øèíý÷ëýí òîãòîîñîí áөãөөä òýäíèé ýðõèéã õýðõýí õàíãàõ ýðãýëò óóëçàëò, çaõèäaë èëãýýìæ aâàõ õóãàöààã òîãòîîãîí çààæýý. Áóñàä çààëòóóä өìíөõ õóóëüòàéãàà àäèë õýìæýýíä õóóëü÷èëàãäñaíûã òýìäýãëýõ íü çүéòýé.

1996 îíû 11 äүãýýð ñaðûí 15-íû өäөð Шүүõèéí øèéäâýð áèåëүүëýõ òóõàé õóóëèéã áaòaí ãaðãààñaí þì. Õóóëü áàòëaãäaaí ãàðàõ áîëñîí øàëòãààíûã äîêòîð Á.Äàøçýâýã áүõ òөðëèéí ÿë ýäëүүëýõ àæèëëaãaaã өìíө íü 1993, 1994, 1995 îíû 3 õóóëèàð çîõèöóóëæ áàéñíûã òөâëөðñөí áàйдëààð õэðэгжүүëýõэээð íýã õóóëèéí õүðýýíä õàìðóóëàõ íèéãìèéí çàйëøãүé øààðäëaãà áàéñàí þì. Ýíý õóóëèéí àãóóëãa íü óðüä өìíө áàòëàãäààí õýðэãæэæ áàéñàí 3 õóóëèóäààñ áóðàýõ áөãөөä òýäãýýðèéí àãóóëãà ÿìàð íýã çàð÷ìûí өөð÷ëөëòãүéãýýð óã õóóëüä áүðýí òóñãàãäñaí þì ãýæýý.

Монгол Улсын Их хурлаас **1993 оны 12 дугаар сарын 6-нд "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль"** [10]батлан гаргаж, 1994 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн мөрдөх болсон билээ. Энэ нь Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагагааг эрх зүйгээр зохицуулах 4 дэх хууль байв.

Өмнөх хуулийн адил тусгай бүлэг болгон оруулаагүй ч насанд хүрээгүйчүүдийн хорих ял эдлүүлэх талаар уг хуульд хуульчилсан байна. Үүнд:

9 дүгээр зүйл. Хорих анги, түүний эрх хэмжээ.

2.5. насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах.

19 дүгээр зүйл. Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх.

1. насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тус тусад нь ял эдлүүлнэ.

20 дугаар зүйл. Хоригдлын эрх, үүрэг.

2.1. тогтоосон журмын дагуу зохиож байгаа хөдөлмөрийн дадлга олгох болон ерөнхий боловсролын сургалтад биеэ дайчлан суралцаж,

---

[10] А.Лхагва. Дурьдсан бүтээл

соёл, хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцох.

22 дугаар зүйл. Хорих ял эдлүүлэх дэглэм.

2. Насанд хүрээгүй болон эмэгтэй хоригдлын ялыг жирийн, чанга, ... дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлнэ.

23 дугаар зүйл. Насанд хүрээгүй хоригдол.

1. Насанд хүрээгүй хоригдлын ялыг зөвхөн насанд хүрээгүйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.

2. Насанд хүрээгүй хоригдлыг ердийн байранд байлгана.

3. Насанд хүрээгүй хоригдлыг хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй нөхцлөөр ажиллуулж болно.

4. Насанд хүрээгүй хоригдлыг 18 нас хүрмэгц үлдсэн ялыг нь насанд хүрэгчдийн хорих ангид эдлүүлэхээр шилжүүлнэ. Хоригдлын ялын хугацаа, хувийн байдлыг харгалзан хорих ангийн даргын шийдвэрээр хорих ангид 2 жил хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн ял эдлүүлж болно. Хоригдлыг насанд хүрмэгц насанд хүрэгчдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг ангийн даргын тодорхойлсноор шүүх шийдвэрлэнэ.

5. Насанд хүрээгүй хоригдол жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол эргэлт илгээмж авах, түр уулзах тоог хязгаарлахгүй бөгөөд жилд 8 удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

6. Насанд хүрээгүй хоригдол чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол сард 1 удаа түр, 2 сард 1 удаа удаан хугацааны уулзалт хийж, сард 1 удаа эргэлт илгээмж авч болно.

30 дугаар зүйл. Хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл.

2. Сахилгын байранд ...насанд хүрээгүйчүүд болон эмэгтэйчүүдийг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд ... насанд хүрээгүйчүүд болон эмэгтэйчүүдийг 30 хүртэл хоног тус тус хорино.

34 дүгээр зүйл. Хоригдлын ажил, амралтын цаг.

1. Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн хоригдлын ажил, амралтын цагийг Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн Удирдах газар тогтооно.

38 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт.

1. Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ. Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион явуулна.

45 дугаар зүйл. Галт зэвсэг.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3 дахь заалтад заасан, түүнчлэн бүлэглэн довтолсон буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед дотор нь ялгах боломжгүй онцгой тохиолдлоос бусад үед

хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний эсрэг тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг хориглоно гэсэн заалтууд байна.

Монгол Улсын Их Хурлаас **1995 оны 12 дугаар сарын 11**-ний өдөр **"Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль"**[11] батлан гаргасан. Энэ хуулинд насанд хүрээгүй ялтантай холбоотой дараах заалтууд тусжээ. Үүнд:

5 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл.

3. Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял нь тэнсэгдсэн, түүнчлэн хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтанд тавих хяналтыг сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллага, цэргийн анги, байгууллага тус тус гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл. Ял эдлүүлэх байгууллагын нийтлэг үүрэг.

1.3. тэнсэгдсэн болон хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтанд хяналтын хувийн хэрэг хөтөлж ял эдлэлтийн талаар тэмдэглэл хийж байх.

23 дугаар зүйл. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтныг хянан харгалзах.

1. Шүүх насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан бол шийдвэрийн хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтандаа байлган хүмүүжүүлэхэд зөвшөөрсөн аж ахуй нэгж, байгууллага буюу иргэнд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

2. Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах талаар цагдаагийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ.

1/ шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан хяналтын хувийн хэрэг нээж ялтан, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтандаа байлгахаар зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч буюу иргэнийг дуудан уулзаж тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах.

2/ ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж

[11] А.Лхагва. Дурдсан бүтээл

биелэлтийг хангуулах.

3/ ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийх.

4/ шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

3. Засаг дарга ялтанд боловсрол, мэдлэг эзэмшихэд зохих туслалцаа үзүүлж, ялтны сахилга, шүүхээс даалгасан үүргийн биелэлт, засрал хүмүүжлийн байдлыг шалган танилцаж, шаардлагатай бол цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

4. Ялтны эцэг, эх, асран хамгаалагч, дэмжин харгалзагч хараа хяналтандаа байлган хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуй нэгж байгууллага буюу иргэн түүний засрал хүмүүжлийн байдлыг хариуцан эрх зүйн хүмүүжил олгох, иргэний үүргийг шударгаар биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх.

1. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд ялтан өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч шударга ханддагаараа харуулбал түүнийг ялаас чөлөөлөх тухай саналыг зохих шатны Засаг дарга, эсхүл цагдаагийн байгууллага шүүхэд гаргаж болно.

2. Ялтан шүүхээс даалгасан болон энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэний найдварыг хөсөрдүүлсэн, эсхүл нийгмийн хэв журам зөрчиж захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсан бол хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсаныг хүчингүй болгож хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай Засаг дарга, цагдаагийн байгууллага санал, аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн хүсэлтээ шүүхэд гаргана.

3. Хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэний хүсэлт, цагдаагийн байгууллага, Засаг даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх насанд хүрээгүй ялтныг ялаас чөлөөлөх, эсхүл хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсаныг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

Монгол Улсын Их Хурлаас **1996 оны 11 дүгээр сарын 15-ны** өдөр

**“Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль”**[12] батлан гаргасан. Энэхүү хуулинд тусгасан насанд хүрээгүй хоригдлын эрх зүйн байдлын талаарх зүйл заалт нь 1993 оны “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль”-нд тусгасан зүйл заалттай зарчмын хувьд адил юм. Мөн 1995 оны “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль” хуулийн хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтныг хянан харгалзах, хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай заалтууд энэ хуулинд тусгагдсан байна.

1998 оны 11 сарын 13-ны өдөр насанд хүрээгүйчүүдийн хорих анги 50 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн нь хагас зууны туршид төр засаг, төрийн төв байгууллагуудаас гаргаж байсан дээрх хууль тогтоомж, тушаал шийдвэрүүдийг бодит ажил болгон амьдралд хэрэгжүүлэн ажиллаж ирсний үр дүнг дүгнэн харуулсан ажил болсон. Өнгөрсөн хугацаанд тус хорих ангид хүмүүжээд гарсан хүүхдүүдээс Монгол Улсын аж үйлдвэрийн бүхий л салбарт амжилттай ажиллаж амьдарч байгааг онцлох нь зүйтэй. Сүүлийн 10 жилд ялтан хүүхдийг сургах, хөгжүүлэх, төлөвшүүлэх талаар зохиосон ажил, хүрсэн түвшин, олсон ололт их билээ.

2000 оноос Кристина Ноблийн Хүүхдийн сангийн “Боловсрол” төсөл тус ангид хэрэгжиж хоригдол хүүхдүүдэд ерөнхий эрдмийн хичээл заах ажил шинэ шатанд гарсан байна. Энэ үед сургалтын материаллаг, бааз, үйлдвэрлэлийн дадлага хийх газаргүй, зах зээлийн эхэн үеэр нийслэлд ундуй, сундуй нүүж ирсэн учир бүхнийг шинээр эхэлж байлаа. Харин хүүхдийн заяа түшиж, дотоодоос Н.Болормаа тэргүүнтэй “Хүүхдийн эрхийн төлөө төв”, гаднаас “Кристина Ноблийн Хүүхдийн Сан” зэрэг байгууллагууд халуун гараа сунгаж, хичээл хүмүүжлийн ажил дахин сэргэсэн түүхтэй.

2000 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 258 тоот захирамж гарч, Зайсан дахь Насанд хүрээгүйчүүдийн хорих ангид “Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай сургууль” байгуулагдсан.

Ийнхүү Хүүхдийн хорих анги анх удаа Нийслэлийн “Хан-Уул дүүргийн 110 дугаар сургууль гэсэн хаяг зүүснээр барахгүй, сургалтын таатай орчин бүрдэж, төрөл бүрийн мэргэжлийн орон тооны багш 10 гаруй, цагийн багш нар мөн төдий тооны болж, хоригдол хүүхдийг ерөнхий боловсролын болон хөдөлмөрийн дадлага мэргэжил олгох сургалтад бүрэн хамруулах болжээ. Үүний дотор 2000-2002 онуудад Кристина Ноблийн Хүүхдийн Сангийн туслалцаатайгаар компьютер, гадаад хэлний сургалтын

[12] А.Лхагва. Дурьдсан бүтээл

анги, кабинет нээж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ханнс Зайделийн Сангийн ивээлээр гар хивс урлалын анги, мөн "Урам" төрийн бус байгуулагын дэмжлэгтэйгээр "Жижиг Урлал"-ын хичээлийн танхимуудтай болсон.

Тус онд Японы "Энх тайвны салхи" байгууллагын төслөөр орчин үеийн техник хэрэгслээр тоноглож тохижуулсан ном уншлагын танхим, сэтгэлзүйн кабинет байгуулж ашигласан нь хорих ангийг сургуулийн өнгө төрхтэй болгоход чухал хувь нэмэр болсон. Мөн анх удаа орон тооны сэтгэл зүйч багштай болж, улмаар "Шри Шри" амьдрах ухааны болон "Впяшня" бясалгалын хичээлийг 2-3 жил дараалан эрх бүхий мэргэжлийн багш нарын удирлагаар явуулсан нь хүүхдийн сурлага, хүмүүжлийн төлөвшилд мэдэгдэхүйц үр нөлөө өгснөөр барахгүй Насанд хүрэгчдийн хорих ангиудад ч авмаар сайн туршлага гэгдэж байсан.

Монгол Улсын Их Хурлаас **2002 оны 01 дүгээр сарын 08**-нд **"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай"**[13] хуулийг батлан гаргаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж эхэлсэн. Уг хуульд тусгасан насанд хүрээгүй хоригдлын талаарх зүйл заалтууд 1996 оны хуулинд тусгасан зүйл заалтуудтай нэгэн утга бүхий байна.

2002 оны Эрүүгийн хуульд хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор заасан боловч хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүнд ямар үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох талаар тодорхой тусгаагүй, түүнчлэн хяналт тавих байгууллагын асуудлыг тодорхой зохицуулаагүйн улмаас практикт хэрэгжилт хангалтгүй байсан.

Тус хуульд насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар дараах зүйл заалтууд туссан байна.[14]

21 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар

21.2. Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд энэ хуулийн тусгай ангийн 91 /Хүнийг санаатай алах/, 96/ Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 126 /Хүчиндэх/, 145/ Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146/ Бусдын эд хөрөнгийг булаах/, 147/ Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 153/Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх/, 181.3 /Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

21.3.Арван найман насанд хүрэхийн өмнө анх удаа хөнгөн, хүндэвтэр

[13] А.Лхагва. Дурдсан бүтээл
[14] Legalinfo.mn

гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял шийтгэхгүй хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл түүнд энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

**52 дугаар зүйл. Хорих**

52.3.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй.

**53 дугаар зүйл. Цаазаар авах**

53.4.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.

**55 дугаар зүйл. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал**

55.1.7.арван найман насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн;

62 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

62.1.Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна.

62.2.Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно.

62.3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана.

62.4.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг

хойшлуулсан хугацаанд уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулсан бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шүүх түүнийг ялаас чөлөөлж болно.

62.5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

62[1] дүгээр зүйл.Насанд хүрээгүй этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах

62[1]. 1.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна.

69 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх

69.1.Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл түүнд дор дурдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно:

69.1.1.зургаан сараас нэг жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах;

69.1.2.арван зургаан насанд хүрсэн этгээд бие дааж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх;

69.1.3.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүний хяналтад өгөх;

69.1.4.хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгахаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох.

69.2.Насанд хүрээгүй этгээд энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээ авагдсаны дараа засарч хүмүүжихгүй байвал шүүх уг арга хэмжээг насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно.

69.3.Насанд хүрээгүй этгээдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах хугацааг уг этгээдийн зан төлөв, ахуй амьдралын байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг

харгалзан шүүхээс тухай бүр тогтоох эрхтэй боловч арван зургаан наснаас хэтрүүлж болохгүй.

69.4.Насанд хүрээгүй этгээдийг тогтоосон хугацааны өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас чөлөөлөх асуудлыг тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, **2017 оны 07 дугаар сарын 01**-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн **Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/**-д[15] 14-16 хүртэл насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар дараах зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

**6.2 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар**

2.Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Терроор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

7.6 дугаар зүйл.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

8.1 дүгээр зүйл.Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

1.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

---

[15] Legalinfo.mn

2.Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

3.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

4.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй.

5.Шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно.

6.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман насанд хүрсэн бол энэ хуулийн 8.6 дугаар зүйл хамаарахгүй.

8.2 дугаар зүйл.Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл

1.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд дараах ял оногдуулна:

1.1.нийтэд тустай ажил хийлгэх;

1.2.зорчих эрхийг хязгаарлах;

1.3.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих.

8.3 дугаар зүйл.Нийтэд тустай ажил хийлгэх

1.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна.

2.Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.

3.Шүүх нийтэд тустай ажил хийлгэх ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

8.4 дүгээр зүйл.Зорчих эрхийг хязгаарлах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн

5.5 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.

8.5 дугаар зүйл.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.

2.Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.

3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй.

4.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

2.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

8.7 дугаар зүйл.Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ

1.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм буруут нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээлгэнэ.

3.Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

4.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.

Хорих ял эдлэгсдийг сурган гэгээрүүлэх, тэдэнд мэргэжил олгох сургалтад хамруулах талаар Монгол улсын төр, салбарын яам, байгууллагуудаас ихээхэн анхаарч иржээ. Энэ байдал хорих ял эдлүүлэх чиглэлээр гарсан удаа дараагийн хууль тогтоомж, төрийн төв байгууллагаас гаргаж байсан тушаал, шийдвэрүүдэд тодорхой тусгалаа олсон байдаг. Нэн ялангуяа насанд хүрээгүй хоригдлыг сургах, хөдөлмөрлүүлэх явдал бол тэднийг хүмүүжүүлэн төлөвшүүлэх, хөгжүүлэх үндсэн арга хэрэгсэл хэмээн үзэж, бүр анхнаас нь онцгойлон анхаарч байсан баримт жишээ олон байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1-д: "Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ." гэж, 5.4.10-т: "Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон телекамерын хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ." гэж, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2012

оны 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан.

Дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан 2017 оны 7 сарын 1- ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял, шийтгэлийн төрөл, хэлбэрийг шинээр тодорхойлж, хорих ялыг нээлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад тус тус эдлүүлэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэл оногдуулахаар тусгаж, ял, шийтгэл, албадлагын арга хэмжээний төрлийг шинээр тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас **2017 оны 06 дугаар сарын 09**-ний өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/**-д хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд ял эдлүүлэх талаар дараах зүйл заалтууд тусгагдсан байна.[16]

[16] Legalinfo.mn. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он

## 2.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын чиг үүрэг, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль, Хорих ангийн дотоод журам, Хорих ангийн харуул хамгаалалтын журам, холбогдох бусад хууль тогтоомж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан даалгавар, тушаал шийдвэрийг мөрдлөг болгон ажиллаж иржээ.

2019 онд 18 хүртлэх насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 1356 бүртгэгдсэн бөгөөд үүнийг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 189 гэмт хэрэг буюу 16 хувиар өссөн, 2019 онд 360 хүүхэд шүүхээр ял шийтгүүлсэн бөгөөд өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 8,6 хувиар буурсан үзүүлэлт гарч байна. Мөн 2019 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 26,5 хувь нь шүүхээр ял шийтгүүлсэн байна[17].

Өнөөгийн дагаж мөрдөж буй ял эдлүүлэх талаарх хууль тогтоомжид өсвөр насны хүнийг хорихтой холбоотой дараах эрх зүйн зохицуулалт байна.

*Хүснэгт 4.Өсвөр насны хүнийг хорихтой холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулалт*

| Зүйл, заалт | Агуулга |
|---|---|
| **Нэг.Эрүүгийн хууль:** | |
| 5.6 дугаар зүйл.Хорих ял | 8.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй. |
| 6.2 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар | 1.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.<br>2.Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.<br>3.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. |

[17] 1212.mn

| | |
|---|---|
| | 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан өсвөр насны хүн сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно. |
| 8.1 дүгээр зүйл.Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл | 1.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.<br>2.Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.<br>3.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.<br>4.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй.<br>5.Шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно.<br>6.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман насанд хүрсэн бол энэ хуулийн 8.6 дугаар зүйл хамаарахгүй. |
| 8.2 дугаар зүйл.Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл | 1.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд дараах ял оногдуулна:<br>1.1.нийтэд тустай ажил хийлгэх;<br>1.2.зорчих эрхийг хязгаарлах;<br>1.3.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих. |
| 8.3 дугаар зүйл.Нийтэд тустай ажил хийлгэх | 1.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна.<br>2.Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.<br>3.Шүүх нийтэд тустай ажил хийлгэх ял дээр нэмж хүмүүжлийн |

| | |
|---|---|
| | чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. |
| 8.4 дүгээр зүйл.Зорчих эрхийг хязгаарлах | 1.Шүүх энэ хуулийн тусгай ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана. |
| 8.5 дугаар зүйл.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих | 1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.<br>2.Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.<br>3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй.<br>4.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. |
| 8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах | 1.Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.<br>2.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.<br>3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.<br>4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө. |

| | |
|---|---|
| 8.7 дугаар зүйл. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ | 1.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.<br>2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм буруугаа нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээлгэнэ.<br>3.Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.<br>4.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно. |
| **Хоёр.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:** | |
| 195 дугаар зүйл.Хорих байгууллага | 195.1.Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид "хорих анги" гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.<br>195.2.Хорих анги нь төвлөрсөн бүтэцтэй байна.<br>195.3.Хорих ангийг тусгаарлагдсан нэгээс илүү зэрэглэлд хуваах, өөр өөр зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол бие биетэйгээ харилцах боломжгүй байдлаар зохион байгуулж болно.<br>195.4.Хорих ангийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, хоригдлыг эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөрлүүлэх, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангах, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хоригдлыг анх хуваарилсан хорих ангиас өөр хорих ангид шилжүүлэхийг хориглоно.<br>195.5.Хорих ял эдэлж байгаа ялтанг хоригдол гэнэ.<br>195.6.Хорих ангийн дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. |
| 201 дүгээр зүйл.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд ял | 201.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.<br>201.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр |

| | |
|---|---|
| эдлүүлэх | насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна.<br>201.3.Өсвөр насны хоригдол арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хоригдлыг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.<br>201.4.Энэ хуулийн 201.3-т заасны дагуу шилжүүлсэн хоригдлын эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэх хорих ангийн дэглэмийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.<br>201.5.Шүүх энэ хуулийн 201.3-т заасан хоригдлын эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.<br>201.6.Өсвөр насны хоригдлын илгээмж авах, түр уулзалт хийх, утсаар ярих тоог хязгаарлахгүй бөгөөд 15 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болно. |
| 208 дугаар зүйл. Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх | 208.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.<br>208.2.Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ.<br>208.3.Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ. |
| 220 дугаар зүйл.Хорих анги дахь сургалт | 220.1.Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ.<br>220.2.Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна. |

Хорих ял эдлүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулж буй Хорих ангийн дотоод журам болон Хорих ангийн харуул хамгаалалтын журам, Нийгмийн ажлын аргачилсан зааварт Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны талаар зохицуулалт үгүй байна.

*Хүснэгт 5.Монгол Улсад өсвөр насны хүнээс үйлдсэн гэмт хэрэг, шийтгэгдсэн*

*судалгаа*

| Статистик үзүүлэлт | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|
| 18 хүртэлх насны хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо | 1,250 | 1,402 | 1,165 | 1,066 | 956 | 1,356 |
| 18 хүртлэх насны ял шийтгэгдсэн хүүхдийн тоо | 467 | 422 | 360 | 425 | 295 | 360 |

*Зураг 13. 18 хүртлэх насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг, шүүхээр ял шийтгүүлсэн хүүхдийн тоо /2014-2019/*




Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад сүүлийн 20 жилийн байдлаар 2133 өсвөр насны хоригдол ял эдлэсэн бөгөөд 2015-2019 он буюу сүүлийн 5 жилийн дунджийг 2000-2004 оны дундажтай харьцуулахад 2,3 дахин, 2005-2009 оны дундажтай харьцуулахад 2,4 дахин, 2010-2014 оны дундажтай харьцуулахад 9,1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Мөн сургуульд суралцсан хоригдлын тоог 5 жилээр үечилж авч үзвэл дунджаар 2000-2004 онд 85, 2005-2009 онд 69, 2010-2014 онд 32, 2015-2019 онд 30 хоригдол сургалтад хамрагдсан гэсэн тоон мэдээлэл байна[18].

*Хүснэгт 6.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны судалгаа*

| д/д | Огноо | Өсвөр насны нийт хоригдол | Үүнээс сургуульд сурсан хоригдлын тоо | | | | ББД боловсрол эзэмшсэн хоригдлын тоо | БД боловсол эзэмшсэн хоригдлын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бага анги | Дунд анги | Ахлах анги | Нийт | | |
| 1 | 2000 | 80 | 32 | 33 | - | 65 | - | - |
| 2 | 2001 | 143 | 44 | 6 | - | 50 | 6 | - |
| 3 | 2002 | 174 | 51 | 41 | 2 | 94 | - | 2 |
| 4 | 2003 | 168 | 55 | 50 | 3 | 108 | - | 3 |
| 5 | 2004 | 165 | 56 | 45 | 5 | 106 | 2 | 5 |
| 6 | 2005 | 193 | 63 | 12 | 3 | 78 | 10 | 3 |

[18] Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын тоо бүртгэлийн албаны тоон судалгаа

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 2006 | 198 | 58 | 44 | 5 | 107 | 8 | 6 |
| 8 | 2007 | 60 | - | 23 | - | 23 | - | - |
| 9 | 2008 | 152 | 67 | 38 | - | 105 | - | - |
| 10 | 2009 | 129 | - | 28 | 6 | 34 | 2 | 6 |
| 11 | 2010 | 48 | - | 2 | - | 2 | 2 | - |
| 12 | 2011 | 72 | 23 | 20 | - | 43 | 3 | - |
| 13 | 2012 | 81 | 34 | 28 | - | 62 | 4 | - |
| 14 | 2013 | 79 | 7 | 10 | 10 | 27 | 4 | 3 |
| 15 | 2014 | 53 | 6 | 7 | 15 | 28 | - | 3 |
| 16 | 2015 | 45 | 7 | 7 | 7 | 21 | 6 | 6 |
| 17 | 2016 | 36 | 8 | 9 | 10 | 27 | 7 | 6 |
| 18 | 2017 | 18 | 2 | 4 | 3 | 9 | 2 | - |
| 19 | 2018 | 155 | 8 | 6 | 25 | 39 | 6 | 6 |
| 20 | 2019 | 51 | 3 | 28 | 24 | 55 | 2 | 2 |
| 21 | 2020 | 32 | 1 | 18 | 6 | 25 | - | - |

*Зураг 14.Өсвөр насны хоригдлын тоо /сүүлийн 20 жил/*




*Зураг 15.Сургуульд суралцсан хоригдлын тоо /сүүлийн 20 жил/*



*Зураг 16.Бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн хоригдлын тоо /сүүлийн 20 жил/*




Нийслэлийн 110 дугаар сургуулийн багшлах бүрэлдэхүүний хувьд хоригдогч хүүхдийг нийгэмшүүлэх, сэтгэл зүй, зан чанар, засрал хүмүүжил төлөвшилд нь эерэг нөлөөлөл үзүүлэх, ерөнхий боловсрол олгох, хичээлийн хоцрогдол арилгах, мэргэжлийн болон хөдөлмөрийн дадал, мэдлэг чадварын түвшинг ахиулах, цаашид суралцах арга барилд сургах үндсэн зорилтын хүрээнд ажиллаж байна[19].

*Зураг 17.Багшлах бүрэлдэхүүний тоо*




[19] Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны тайлан. 2016-2019

Тус сургуульд суралцаж буй өсвөр насны хоригдолд мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд 2019 онд мэргэжлийн сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан хоригдлын тоо өмнөх 5 жилийн дунджаас 13,5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 7.Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан байдал*

| д/д | Үзүүлэлт | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжлийн чиг баримжаа олгож чадамжийн гэрчилгээ олгосон ялтны тоо | 46 | 7 | 6 | 17 | 24 |
| 2 | Мэргэжлийн үнэмлэх олгосон ялтны тоо | 0 | 7 | - | - | - |
| 3 | Ажлын байраар хангасан ялтны тоо | 27 | 20 | 16 | - | - |

*Зураг 18.Мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан хоригдлын тоо*




2015 онд Хан-Уул дүүргийн 110 дугаар бүрэн дунд сургуулийг төгссөн ялтан хүүхэд Б.Баатарсүх элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдаж 596 оноо авсан бөгөөд Монголын Үндэсний Их сургуулийн Нийгмийн ажилтны ангид элссэж, суралцах хугацааг 1 жил хойшлуулж байсан байна.

Мөн Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын сургалт, хүмүүжлийн ажлын нөлөөлөл, үр дүн өсөж байгааг өсвөр насны хоригдол хүүхэд ял эдлэж байх хугацаандаа гаргасан зөрчлийн тоо жил ирэх тусам буурч байгаа үзүүлэлтээс харж болох юм.

*Хүснэгт 8.Зөрчлийн мэдээ*

| Үзүүлэлт | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|
| Төлөвлөгөөт үзлэг | | 48 | 43 | 12 | 42 |
| Төлөвлөгөөт бус | | 312 | 325 | 90 | 308 |
| Хориотой эд зүйлс илрүүлсэн байдал | | 20 нэр төрлийн 159 | 19 нэр төрлийн 30 | 2 нэр төрлийн 7 | 23 нэр төрлийн 88 |
| Ялтан хүүхэд гаргасан зөрчлийн нийт тоо | 16 | 2 | 1 | 1 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үүнээс: Гар утас хэрэглэсэн зөрчил | 5 | 1 | - | - | - |
| Албан хаагчийн шаардлага эсэргүүцсэн | 3 | 1 | - | - | - |
| Хоорондоо маргалдсан | 3 | - | 1 | 1 | - |
| Архи уусан | 5 | - | - | - | - |

*Зураг 19.Илэрсэн зөрчлийн тоо*



# ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫГ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

## 3.1.Өсвөр насны хүнд ял оногдуулах, түүнийг эдлүүлэх талаарх олон улсын баримт бичиг

Монгол улс НҮБ-ын "Хүүхдийн эрхийн тухай" конвенцод 1990 онд нэгдэн орж хүн төрөлхтний ирээдүйн сайн сайхан байдлыг хангах энэхүү конвенцыг хангах үүрэг хүлээсэн дэлхийн 5 дахь орон болсон юм.

НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенц нь анхаарлын гадна үлдэж байсан хүүхдийн эрэлт хэрэгцээг хангах шинэ стандартыг тогтоож, төр нийгмийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалахад хүлээх үүргийг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой юм.

НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлж эхэлсэн он жилүүд нь Монгол улсад өрнөсөн улс төр, эдийн засаг, нийгэм эрх зүйн шинэчлэл өөрчлөлттэй давхцаж байна. 1992 оны 01 дүгээр сард Монгол улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдаж, Үндсэн хуулиар хууль дээдэлсэн зах зээлийн харилцаанд шилжих үйл явцыг хуульчилсан нь эрх зүйн иж бүрэн шинэтгэл хийх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Хүүхдийн эрхийн асуудал бол хүний эрхийн салшгүй хэсэг мөн. Иймд Монгол Улсын Их хурал хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч 1995 онд Монгол Улсын Их Хурлын шийдвэрээр "Хүүхэд хөгжил хамгаалал" үндэсний чуулган зохион байгуулж, 1996 оны 05-р сард "Хүүхдийн эрхийг хамгаалах" Монгол улсын хуулийг баталсан юм. Монгол улс хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн тухай анхны илтгэлээ 1996 оны 01 дүгээр сард НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооны 11-р чуулганаар амжилттай хэрэгжүүлсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага, ял шийтгэл оногдуулах, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах эрхийн тухай "Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт" "Хүүхдийн эрхийн конвенц", НҮБ-ын "хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм", "Яллагдагчдын /прокурор/ үүргийн удирдах зарчмууд" НҮБ-ын "насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм"[20], НҮБ-ын удирдах зарчмууд болон олон улсын баримт бичигт хууль бусаар дур мэдэн хүүхдийн эрх чөлөөг хасаж болохгүй. Түүнийг баривчлах, албадан саатуулах, хорих явдлыг гагцхүү хуулийн дагуу гүйцэтгэх, эцсийн арга

[20] Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх.УБ.,.1996 он

хэмжээ болгож аль болох богино хугацаатайгаар хэрэглэхийг заасан байна.[21]

Мөн эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүртэй хүнлэг ёсоор харьцаж нэр хүндийг нь хүндэтгэх, эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад шаардлагатай хусламжийг авах, бусдын нөлөөнд автагдаагүй хараат бус байхаар тусгагдсан байна. Тухайлбал: "хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийн 37-р зүйлийн "а хэсэгт":

18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн хэрэгт цаазаар авах буюу ямар ч үндэслэлгүйг бүх насаар нь гянданд хорих ял оногдуулахгүй байх гэжээ.

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-аас гаргасан үндсэн зарчим /Эр-Риадын үндсэн зарчим/ Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/112 дугаар тогтоолоор баталсан.

Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандарт /бээжингийн дүрэм/ 1985 оны 11 сарын 29-ний Ерөнхий Ассемблейн 40/33 тоот тогтоолоор батлав. НҮБ-ын зургаадугаар чуулганаас гаргасан наймдугаар тогтоолын дагуу 17.1 дүгээр зүйлийн /б/ заалт залуу хүмүүсийн онцлог эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс хорихоос бусад арга хэмжээг аль болох их сонгон хэрэглэхийг дэмжиж байгаа юм. Иймээс нийгмийн аюулгүй байдлыг хангах эрэлт хэрэгцээг харгалзан сонгох өөр төрлийн байгаа арга хэмжээнүүдийг бүрэн ашиглах, шинэ төрлийн сонгох арга хэмжээ боловсруулах нь зүйтэй.

Журмын 17.1-ийн /с/ зүйл нь нийгмийн аюулгүй байдлыг хангах холбогдох өөр арга хэмжээ байхгүй тохиолдлоос бусад үед насанд хүрээгүй хүнийг шоронд хорихоос зайлсхийхэд чиглэгдсэн зургаадугаар Конгрессын 4 дүгээр тогтоолын удирдамж болгосон зарчмын нэгтэй нийцэж байгаа юм. Үүнд:

**Нөлөөллийн олон янзын арга хэмжээ**

18.1. Эрх мэдэл бүхий эрх хэмжээтэй байгууллагаас авах арга хэмжээний төрөл олон янз байх нь хорихоос аль болох зайлсхийх боломжийг бүрдүүлэх юм. Зарим нэгийг нь давхардуулан хэрэглэж болох тийм арга хэмжээ байж болно.

а/ асран хамгаалах, удирдан чиглүүлэх, хяналтад өгөх,

б/ ял тэнсэх,

с/ нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх,

[21] Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл.УБ.,1992 он

д/ мөнгөн шийтгэл, нөхөн төлбөр, хохирлыг барагдуулах,

е/ завсрын болон бусад арга хэмжээ авахаар тогтоох,

f/ бүлэг хэсэгт нь сэтгэцийн эмчийн зөвлөгөө өгөх болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагаанд татан оролцуулах,

g/ хүмүүжүүлэх болон оршин амьдрах газрыг шилжүүлэх, хүмүүжлийн бусад арга хэмжээ тогтоох,

18.2. Хэргийн нөхцөл байдал шаардахгүй бол насанд хүрээгүй нэг ч хүнийг эцэг, эхийнх нь хараа хяналтаас бүрэн буюу зарим хэмжээгээр гаргаж болохгүй.

19. Засан хүмүүжүүлэх байгууллагад хорихоор заасан арга хэмжээг аль болох бага хэрэглэх.

19.1. Насанд хүрээгүй этгээдийг засан хүмүүжүүлэх байгууллагад хорих явдлыг зайлшгүй шаардлагатай хамгийн богино хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэвэл зохино.

Тайлбарлавал: Орчин үеийн криминилогийн шинжлэх ухаан засан хүмүүжүүлэх байгууллагад хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэглэхэд онцгой ач холбогдол өгдөг. Засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож буй хувь хүнд зайлшгүй тусах олон сөрөг нөлөөллийг засан хүмүүжүүлэх үйл ажиллагаатай зэрэгцүүлэн тавьж болохгүй юм. Энэ нь сөрөг нөлөөлөл их. Хорих ялаас гадна нийгмээс тусгаарлагдсанаас үүсэх сөрөг үр дагаврууд өсөлт, бойжилтынхоо эрт шатанд байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хувьд насанд хүрэгсдээс ч илүү хүнд тусдаг юм.

19 дүгээр зүйлийн зорилго нь засан хүмүүжүүлэх байгууллагад хориход хоёр үндсэн хязгаарлалтыг оруулж өгсөн. Үүнд: оны /эцсийн арга хэмжээ/ болон цаг хугацааны /хамгийн бага хугацаагаар/ тавихыг зорьж байна. 19 дүгээр зүйлд НҮБ-ын зургаадугаар чуулганы 4 дүгээр тогтоолд эрх зүй зөрчсөн насанд хүрээгүй этгээдийг өөр төрлийн тохирсон арга хэмжээ байгаа нөхцөлд хорьж болохгүй гэсэн үндсэн зарчмыг тусгажээ. Үүнд:

Шийтгэх ба хорихоос өөр төрлийн ялууд

Шийтгэл нь насанд хүрээгүйчүүдийн шүүхийг ердийн шүүхээс ялгах гол зүйлийн нэг юм. Хүүхдийн эрхийн конвенц насанд хүрээгүйчүүдэд шийтгэл оногдуулахдаа тэд хийсэн үйлдлийнхээ үр дагаврыг ойлгох чадвар мөхөс байдгаас гадна дахин засарч хүмүүжих их боломжтой гэдгийг заавал анхааралдаа авах хэрэгтэйг онцлон заасан юм.

Олон нийтэд нь түшиглэн дахин хүмүүжүүлэх асуудал нь зөвхөн хүүхдийн эрхийн асуудал төдийгүй бас хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон зуун жилийн сургамж дээр үндэслэгдсэн арга юм.

Хорих ял нь хүүхдийг дахин хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ба цаашид

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүн багатай арга болохыг одоо бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна. Хүүхдийг нийгмээс тусгаарласнаар тэдний нийгмээс хөндийрч байгаа мэдрэмжийг улам ихэсгэж, гэмт хэрэгтэн шиг биеэ авч явах байдлыг улам дэвэргэдэг.

Сануулга ба шүүхийн донго

Сануулга ба шүүхийн донгыг Польш, Румын, Нидерланд, Франц, Австрали, АНУ ба Канад зэрэг олон оронд анхны удаа гэмт хэрэг үйлдсэн ба хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдэд хэрэглэдэг.

Шүүгч, хүүхдэд ял оноохын оронд донго өгч, түүний биеэ авч явсан байдал нь буруу ба цаашид ямарваа гэмт хэрэг үйлдвэл нэлээд хатуу үр дагавартай болохыг хэлж өгдөг. Анх удаагаа гэмт хэрэгт холбогдсон олон хүүхдүүдэд шүүхийн сануулга нь биеэ зөв авч явахыг ойлгоход хангалттай нөлөөлдөг.

Нөхцөлтэйгөөр суллах

Нөхцөлтэйгөөр суллах үед шүүх насанд хүрээгүй хүүхдийн буруутайг тогтоох бөгөөд ял оногдуулахдаа тодорхой хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд тэд дахин гэмт хэрэг үйлдэхгүй эсвэл хүмүүжлийн хөтөлбөрт хамрагдана гэсэн тодорхой нөхцөлүүдийг биелүүлэхийг шаарддаг. Хэрэв үр дүн нь хангалттай бол ямар ч ял оногдуулдаггүй. Хэрэв нөхцөлүүдээ биелүүлэхгүй бол шүүхэд асуудлыг буцаадаг ба тохирох ял шийтгэлийг нь оногдуулдаг.

Шийтгэлийг хойшлуулах

Шийтгэлийг хойшлуулах нь дээрхтэй төстэй боловч энэ тохиолдолд шийтгэл оногдуулдаг ба хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэхгүй эсвэл тодорхой нөхцөлүүдийг мөрдөнө гэсэн тохиолдолд тоггоосон хугацаагаар шийтгэлийг хойшлуулдаг. Хэрэв нөхцөлүүдээ зөрчвөл хүүхэд анх оноосон шийтгэлээ хүлээдэг.

**Олон улсын эрх зүйн зохицуулалт:**

а/ Хүүхдийн эрхийн тухай конвенцын[22]

-Оролцогч улсууд конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоох, захиргааны болон бусад бүх арга хэмжээг авна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг нөөц бололцоондоо тулгуурлаж дээд зэргээр ашиглах, шаардлагатай бол олон улсын хамтын үйл ажиллагааны хүрээнд авна. /4 дүгээр зүйл/

---

[22] Монгол Улс энэ конвенцид 1990 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж 07 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан.
Төрийн мэдээлэл тусгай дугаар. I боть УИХ-ын тамгын газар, Гадаад хэргийн яам, УБ., 2004 он

-Хүүхэд эцэг, эхтэйгээ харилцаа холбоотой, тэдний талаар мэдээлэлтэй байх. /9-р зүйл 3,4 дэх хэсэг, 10-р зүйл/ Эцэг, эх тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийн хүмүүжил, хөгжилд гол хариуцлагыг хүлээнэ. /18-р зүйлийн 1 дэх хэсэг/

-Оролцогч улс таван жил тутамд конвенцоор хүлээн зөвшөөрсөн эрхийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшлийн талаарх тайланг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороонд ирүүлэх үүрэгтэй /44-р зүйл “b”/

-Оролцогч улс тайланг өөрийн улсын олон нийтэд өргөнөөр хүртэхүйц боломцоогоор хангана. /44-р зүйл 6 дахь хэсэг/[23]

б/ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн[24]

-Хоригдол эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хорих газраас гарч явах онцгой тохиолдолд түүнд өөрийнхөө хувцсыг эсвэл нүдэнд өртөхөөргүй бусад хувцсыг өмсөхийг зөвшөөрөх нь зүйтэй. /17.3 дахь хэсэг/

-Насанд хүрээгүй хоригдлуудад ... тоглох боломжийн дасгал хийх явдлыг хангавал зохино. /22.1 дэх хэсэг/ Үүний тулд талбай, тоноглол, төхөөрөмжтэй байвал зохино. /22.2 дахь хэсэг/

-Бүх хорих байгууллага өөрийн мэдэлд ядахдаа нэг сэтгэл судлалын зохих мэдлэгтэй эмнэлгийн мэргэжлийн ажилтантай байх ёстой. /22.1 дэх хэсэг/

-Хоригдол бүр мэргэжлийн шүдний эмчид үзүүлж эмлүүлэх боломжтой байх ёстой. /22.3 дахь хэсэг/

в/ НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмүүдийн[25] /Бээжингийн дүрмүүдийн/

-Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллагын гол зорилго нь халамж, хамгаалалтаар хангах, нийгэмд ашигтай, нийгэмд үр бүтээлтэй үүрэг биелүүлэхэд нь боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэнэ. /26.1 дэх хэсэг/

---

[23] Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял. УБ.,2015 он.121 дэх тал.

[24] 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудал” 1 дүгээр хурлаар батлав. “Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхтгэл” УБ.,2014 он.
Монгол Улсын ХЭҮК, Каритам Чех байгууллага. 78-88 дахь тал

[25] 1. Милан хот 1985 оны 08 дугаар сарын 25-аас 9 дүгээр сарын 06-ны өдрүүдэд болсон НҮБ-ын “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудал” 7 дугаар хурлаар дэмжигдэж Ерөнхий Ассемблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 40/33 тогтоолоор баталсан.
2. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл: эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Эрхлэн эмхтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо. УБ.,2012 он. 131-154 дэх тал.

-Засан хүмүүжүүлэх байгууллагаас хугацааны өмнө тэнссэн суллах явдлыг зохих байгууллагаар аль болох боломжийн өргөн хүрээнд ял эдлэлтийг аль болох боломжийн эхний хугацаанд хэрэглэх ёстой. /28-р зүйлийн 28.1 дэх хэсэг/

г/ Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмуудын[26]

-Хорих ял эдэлж буй хүмүүст ... нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцлийг бий болговол зохино. /10-р зүйл/

д/ Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан журмын:

-Засаг төрийн эрх хэмжээ бүхий байгууллага... насанд хүрээгүй хүмүүс болон орон нутгийн оршин суугчдын хооронд чөлөөтэй холбоо хэлхээг урамшуулсан идэвхитэй алхамыг хэрэгжүүлж байх ёстой. /хавсралт хэсгийн 8-р зүйл/

...Засан хүмүүжүүлэх байгууллагад насанд хүрээгүй хүний... эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нь нийгмийн гишүүн болгох боломжийг хөгжүүлэхэд туслахуйц тийм үзэл бодол, дадал зуршлыг төлөвшүүлэх явдлыг урамшуулах, тэднийг хариуцлагаа мэдэрдэг болгон хүмүүжүүлэхэд тус дөхөм болсон үр нөлөөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /хавсралт хэсгийн 12-р зүйл/

-Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд засан хүмүүжүүлэх байгууллагыг нээлттэй байгуулах ёстой. Нээлттэй засан хүмүүжүүлэх байгууллагад аюулгүй байдлын арга хэмжээ байхгүй буюу хязгаарлагдмал байна. Хаалттай засан хүмүүжүүжих байгууллагад байгаа насанд хүрээгүй хүмүүсийн тоо хүмүүжлийн ганцаарчилсан арга хэрэглэх боломжтой байлгах үүднээс цөөн байлгах ёстой. Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллага нь хоорондын хэлхээ холбоог тасалдуулахгүй байх хэмжээнд байна. /хавсралт хэсгийн 30-р зүйл/

-Насанд хүрээгүй хүнийг гадаад ертөнцтэй зохих ёсны холбоо хэлхээгээр хангах бүхий л хэрэгслийг ашиглах нь хүнтэй шударга, хүмүүнлэг харьцах эрхийн салшгүй хэсэг болдог бөгөөд тэднийг нийгэмд буцаан оруулахад бэлтгэхэд нэн чухал ач холбогдолтой. Насанд хүрээгүй хүмүүс гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүс, нэр хүндтэй, найдвартай байгууллагын төлөөлөгчидтэй харилцах, гэртээ очих, гэр бүлийнхэнтэй уулзахаар засан хүмүүжүүлэх байгууллагаас гаргах, боловсрол, мэргэжил эзэмших, бусад нэн чухал зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гарч явах боломжоор хангагдах ёстой. Ял эдэлж байгаа хүмүүсийн засан

[26] НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний 45/111 тогтоолоор баталсан.

хүмүүжүүлэх байгууллагаас гадуур байсан хугацааг ялын хугацаанд оруулан тооцно[27]. /хавсралт хэсгийн 59-р зүйл/

-”... Ямарч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүнтэйгээ уулзахыг хязгаарлах буюу хориглох явдал байж болохгүй...” /хавсралт хэсгийн 67-р зүйл/

-”...Бүх ажилтнууд ... засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод ба түүний гаднах амьдралын ялгааг аль болохоор бууруулахыг эрмэлзэх ёстой”[28] /хавсралт хэсгийн 87-р зүйл “f”/

Гадаадын зарим орон тухайлбал: ОХУ, ХБНГУ, Англи, АНУ, Франц зэрэг орны ял эдлүүлэх байгууллагын нийгмийн ажил нь НҮБ болон олон улсын байгууллагаас батлан гаргасан жишиг дүрэмд заасан тулгуур зарчмуудыг баримталдаг байна.

Эдгээр жишиг дүрмүүдэд НҮБ-аас 1955 онд батлагдаж, ... “Хэрэгтэн ялтантай харьцах наад захын жишиг дүрэм”, 1987 онд шинэчлэгдсэн “Ялтнуудтай харьцах наад захын Европын жишиг” болон Америк, Африкийн “Хоригдолтой харьцах үндсэн зарчим”, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм (1990)” багтах бөгөөд мөн олон улсын цөөнгүй бусад бичиг баримт байдаг. Тэдгээр нь хүмүүнлэгийн үнэт зүйлс, суурь зорилго хийгээд зарчимд тулгуурлан төрөл бүрийн ялтай ялтнуудтай харьцах, тэднийг хэрхэн засан хүмүүжүүлэх, сургах, хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх талаар тусгасан байдаг[29].

Дэлхийн улс орнуудад эрүүгийн ял эдлүүлэх ял эдлүүлэх нөхцөл, журам өөр өөр байдаг ч зайлшгүй баримталбал зохих жишиг байх шаардлагатай болдог байна. Энэ байдлыг харгалзан НҮБ-аас 5 жил тутамд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргагчидтай хүний эрхийг хамгаалах үүднээс хэрхэн харьцвал зохих талаар хэлэлцэн зохих дүрэм гаргаж хэвшсэн юм.

Ийм хэлбэрийн хурлыг НҮБ-аас зохион байгуулан 1955 онд Женев, 1960 онд Лондон, 1965 онд Стокольм, 1970 онд Киото, 1975 онд Женев, 1980 онд Каракас, 1985 онд Милан, 1990 онд Гавана хот, 1995 онд Кипр улсад, 2000 онд Лондон хотод тус тус хуралдсан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас баталсан “Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм”-ийн 2.2-т зааснаар “Насанд хүрээгүй хүн гэж үйлдсэн хэрэгт нь

---

[27] Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял. УБ.,2015 он. 123 дахь тал

[28] Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял. УБ.,2015 он. 124 дэх тал

[29] А.Лхагва. хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.УБ.,2015 он

тухайн улсын эрх зүйн тогтолцоо насанд хүрсэн хүнээс ялгаатай хэлбэрээр хариуцлага хүлээлгэхээр заасан хүүхэд буюу залуу хүнийг хэлнэ... "Насанд хүрээгүй хүн гэдэг ойлголтыг 7-18 буюу түүнээс доош насны хүмүүсийг хамаарч байгаа юм" гэж тайлбарлажээ[30]. Уг жишиг дүрэмд хүүхдийг эрүүгийн хариуцлагад татах насны ойлголтыг аливаа эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрөхдөө насны доод хязгаар нь сэтгэх, оюун ухаан, оюуны хөгжлийн байдлыг харгалзан дэндүү бага насаар тогтоож болохгүйг заажээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 24 дүгээр зүйлд "Аливаа хүүхэд үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хоронго чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй[31].

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай Олон улсын пактын 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Бүх хүүхэд, өсвөр насныхныг эдийн засаг, нийгмийн дарлал мөлжлөгөөс хамгаалж байх ёстой. Тэднийг ёс суртахуун, эрүүл мэндэд нь харш, амь насанд нь аюултай буюу хэвийн өсөлт хөгжилтөд нь хор болохуйц салбарт ажиллуулсан бол хуулийн дагуу шийтгэнэ[32] гэж заасан нь хүүхдийн эрхийг гэмт халдлагаас үндэсний хууль тогтоомжоор хамгаалах эрх зүйн гол үндэс юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1989 онд Хүүхдийн эрхийн конвенц баталсан. Хүүхдийн эрхийн конвенцын 2 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт "Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг үндэс угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй энэхүү конвенцод заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр хайхрамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүх шаардлагатай арга хэмжээ авна[33]. гэж тус тус заасан.

---

[30] "Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх НҮБ-ын баримт" эмхтгэл. УБ.,2003 он.93 дахь тал
[31] Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. Могнол Улсын Олон улсын гэрээ. I боть.УБ.,2004 он.19 дэх тал
[32] Монгол Улс 1968 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр гарын үсэг зурж, 1974 оны 11 сарын 18-нд соёрхон баталсан.
[33] Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. Монгол Улсын Олон улсын гэрээ. I боть.УБ.,2004 он.35,63,67 дахь тал

Түүнд хүүхэд нэг бүрийг онцгойлж асрамжлан хамгаалах хууль эрхийн үндсийг тавьсан. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүүхдийн насны доод болон бусад онцлогийг харгалзан хэрэгжүүлэх арга замыг заасан. Конвенцид хүүхдийн эдэлбэл зохих эрхийг дэлгэрэнгүй дурджээ.

Конвенцын биелэлтэд хяналт тавьж байх зорилгоор Хүүхдийн Эрхийн асуудал Эрхэлсэн Хороо байгуулсан. Оролцогч улс хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний тухай илтгэлээ НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргаар уламжлан 5 жил тутамд Хороонд илтгэнэ. Хороо илтгэлийг хэлэлцээд нийтлэг шинжтэй зөвлөмж гаргаж болно. Хэрэв илтгэлд техникийн зөвлөгөөн буюу тусламж хүссэн байвал хороо уг хүсэлтийг өөрийн саналын хамт НҮБ-ын холбогдох төрөлжсөн байгууллага. Хүүхдийн сан зэрэг эрх бүхий бусад байгууллагад шилжүүлнэ[34].

Насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрлүүднйг гадаадын зарим улсуудын Эрүүгийн хууль, тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар харьцуулан судалбал:

НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц болон дүрэм журмуудад нийгэм нь аливаа гэмт үйлдлийн эсрэг хамгаалагдсан байх ёстой ба хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой бөгөөд гэмт хэрэгт хамгаалах арга хэмжээ авах ёстой талаар тодорхой тусгагдсан байна.

Энэ нь насанд хүрээгүй этгээдэд хөндлөнгийн оролцоо, ялангуяа хийсэн үйлдэлд нь тохирсон арга хэмжээ авах бус харин засрал хүмүүжил олгох, нийгэмд эргэн орох нөхцлийг нь бүрдүүлэхэд ач холбогдол өгч байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд тусгайлан жичид нь тогтоосон хуулийн хүрээнд ял хариуцлагыг тодорхойлж, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангах үүднээс эрүүгийн хариуцлагыг өвөрмөц төрлүүдийг хэрэглэдэг байна[35].

---

[34] М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын Эрх зүй.УБ.,1999 он.109 дэх тал.

[35] Бадам,Д.(2012).“Насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ял, эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал”.УБ

## 3.2.Гадаадын зарим орны өсвөр насны хүний хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог

**Оросын Холбооны Улс:**

Шинээр батлагдан гарсан ОХУ-ын Эрүүгийн хууль нь 1993 оны ОХУ-ын Үндсэн хуулиар тогтоосон эдийн засгийн олон хэвшил бүхий зах зээлийн харилцаа, олон ургальч улс төрийн бодлого, хүний эрхийг хасах явдлыг хамгаалах зорилготой батлагдсан бөгөөд энэ хуулиар орсон томоохон өөрчлөлтүүдийн нэг нь "насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлага" гэсэн V бүлгийг шинэчлэн оруулж, гэмт хэргийн субьектын насыг 16 наснаас эхлэн тогтоохоор заажээ. Социалист эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хамрагдах 1979 онд батлан гаргаж 1980 оны 01 сарын 1-ээс хүчин төгөлдөр болж үйлчилсэн.

ЗСБНХУ-ын Ардын Комиссериатын төвийн Гүйцэтгэх Хороо 1934-1936 онд ял эдлүүлэх чиглэлээр хэд хэдэн тогтоол гаргаж, гянданд ял эдлүүлэх ажиллагааг дахин сэргээх, хорих ялын хугацааг 10-25 жил болгох, насанд хүрээгүй хүмүүст оногдуулах эрүүгийн хариуцлагын хүрээг өргөжүүлэх зэрэг арга хэмжээ авснаар эрүүгийн ялын бодлого, хэрэгжилт нэлээд чангарсан байна.

1996 онд ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хууль батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд зааснаар засан хүмүүжүүлэх колонид ял эдлэгсдийн орон байрны талбайг ялгавартайгаар тогтоож хуульчилсан. Тухайлбал: Засан хүмүүжүүлэх колонид 2, гянданд 2.5, эмэгтэйчүүдийн колонид 3, хүүхдийн колонид 3.5 талбай нэг хоригдолд оногдуулахаар тогтоожээ.

ОХУ-ын хуулиар насанд хүрээгүй хүүхэд гэдэгт 14-18 насны хүнийг хэлнэ. Тус улсын Эрүүгийн хуулиар, дараах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, насанд хүрээгүй буюу өсвөр насны хүүхдэд 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгээр заажээ. Үүнд:

- Хүнийг алах (105);
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (111),;
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (112);
- Хүн хулгайлах (126);
- Хүчиндэх (131);
- Бэлгийн шинжтэй хүчирхэлсэн үйлдэл (132);
- Хулгайлах (158);
- Дээрэмдэх (161);
- Уулгалан довтлох (162);
- Залилан мэхлэх (163);

- Автомашин болон тээврийн хэрэгслийг хулгайлах зорилгогүйгээр хууль бусаар эзэмших (166);
- Хүндрүүлэх нөхцөлтэйгээр бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх (167 дугаар зүйлийн 2 дахь хэсэг),
- Террорист ажиллагаа явуулах (205);
- Хүн барьцаалах (206);
- Террорист ажиллагааны талаар санаатай худал мэдээлэх (207);
- Хүндрүүлэх нөхцөлтэйгэээр танхайрах (213);
- Түүх соёлын хөшөө, дурсгалт зүйлийг санаатайгаар устгах (214);
- Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл болон бууны сум хулгайлах (статья 226);
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хулгайлах (229);
- Тээврийн хэрэгсэл, эсвэл төмөр замыг ажиллагаагүй болгох (267).

зэрэг болно.

Эдгээрээс бусад төрлийн хүнд гэмт хэрэгт 16 наснаас эрүүгийн хаиуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Дээрх гэмт хэрэг нь онц хүнд төрөлд тооцогдох бөгөөд эдгээрийг 16 насанд хүрээгүй хүүхдэд оноох хорих ялын хугацааг тодорхой зааглаж өгнө. Хорих ялын дээд хугацаа 10 жил байх бөгөөд ялыг насанд хүртлээ хүмүүжлийн колонид эдэлнэ. Хүмүүжлийн колони нь хүмүүжлийн байгууллагын нэг төрөл бөгөөд тус байгууллагын бүтэц, тогтолцоо болон үйл ажиллагааны чиг үүрэг тус улсын Эрүүгийн ял шийтгэл хэрэгжүүлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт тусгалаа олсон байна. Насанд хүрээгүй хүүхдийн хорих ялыг энгийн, хөнгөлттэй, хялбаршуулсан болон хөнгөн гэсэн дэглэмтэйгээр эдлүүлнэ.

Анх удаа хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй хүний ялыг, энгийн дэглэмтэй хорих байгууллагад эдлүүлнэ. Хэрэв, тухайн ялтан 3 сарын хугацаанд ямар нэгэн зөрчил гаргаагүй бол, түүнийг хялбаршуулсан дэглэмтэй нөхцөлд шилжүүлнэ. Харин, тухайн этгээдийн зүгээс ямар нэгэн зөрчил гаргасан бол, энэ нь түүнд хорих нөхцлийн дэглэмийг хүндрүүлэх шалтгаан болно. Хорих ялын хугацаа дуусахын өмнө, насанд хүрээгүй хоригдлыг хөнгөвчилсөн дэглэмтэй нөхцөлд шилжүүлнэ. Тус улсад, өнөөдөр,охидын 2, хөвгүүдийн 60, нийт 62 хүмүүжлийн колони 54 байршилд үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Москвагийн тойрогт 2, Алтайн мужид 2, Краснодар, Красноярск, Примори, Белгород, Ростов, Самарск, Рязань, Воронеж и Волгоград, Орлов Новосибирск, Омской, Оренбург, Нижегородск мужид тус бүр 1 байна. Эдгээрээс насанд хүрээгүй охидын колони Томск болон Белгород мужид байрлах бөгөөд 2017 оны байдлаар тус колониудад нийт 1700 орчим насанд хүрээгүй хүүхэд

хоригдож байна.

Эдгээр муж, тойргийн хот болон дүүрэг бүрт, насанд хүрээгүй хүүхдийн асуудал хариуцсан комисс ажиллана.

Эдгээр колонид хүмүүжлийн ажлыг дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- биеийн хүчний;
- ёс зүйн төлөвшлийн;
- хөдөлмөрийн;
- гоо зүйн.

Хорих ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- хулгайлах гэмт хэрэгт 16 хувь;
- дээрэм 15 хувь;
- бусдыг биед санаатай гэмтэл учруулах 11 хувь;
- хүнийг алах – 10 хувь;
- хүчиндэх 8 хувь;
- бусад төрлийн гэмт хэрэг 40 хувтйг тус тус эзэлж байна.

Эдгээр гэмт хэргийг ангилж үзвэл:

1. Хувь хүний эрх, эрэх чөлөөний эсрэг гэмт хэрэг: хүнийг алах, хүчиндэх, бусдын биед хүнд гэмтэл учруулах;
2. Өмчийн эсрэг гэмт хэрэг: хулгай, залилан, дээрэм, бусдын эд хөрөнгийг устгаж, гэмтээх.
3. Олон нийт болон нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг: хууль бус аргаар мансууруулах бодис эргэлдүүлэх, галт зэвсэг болон тэсэрч дэлбэрэх бодис биедээ авч явах, хадгалах гэмт хэргийг насанд хүрээгүй хүүхдийн зүгээс, гол төлөв, үйлддэг байна.

Тус улсын шүүхийн практикаас харахад, 2019 онд насанд хүрээгүй хүүхдэд оноох хорих ялын тоог, өмнөх оныхтой харьцуулахад даруй буурсан үзүүлэлттэй байна.

Тус улсын хүмүүжлийн колони нь эрэгтэй болон эмэгтэй гэсэн хоёр тусдаа байгууллага байна. Эдгээр байгууллагын дараах онцлогтой. Тухайлбал: насанд хүрээгүй ялтан заавал ажил эрхлэх ёстой бөгөөд ажлын үргэлжлэх хугацааг тухайн хүүхдийн насыг харгалзаж тогтооно. Гол ажлын төрөлд: модон эдлэл боловсруулах, оёдол хийх, хоол хүнс бэлтгэх г.м. Түүнчлэн, ажлын бус цагаар, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу заавал хичээлд сууна. Насанд хүрээгүй ялтанг шөний болон амралтын өдрүүдэд ажил хийлгэхийг хориглоно. Ажлын хөлсний 50 хувьтай тэнцэх орлогыг тухайн ялтны дансанд шилжүүлнэ. Цагийн хувиарын хувьд өглөө 06 цаг 30 минутанд босно, орой 22.00 цагт амарна. Насанд хүрээгүй хоригдлын хувьд, эчнээ хэлбэрээр боловсрол эзэмших

эрхтэй.

Сахилга бат сайтай байсан тохиолдолд, насанд хүрээгүй хоригдолд дараах урамшуулал олгоно. Үүнд:

- хөнгөн дэглэмтэй хорих ангид шилжүүлэх;
- колоний харгалзагчийн хамт спорт болон соёл, урлагийн арга хэмжэнд оролцох;
- хугацаанаас өмнө суллагдах;
- тодорхой хугацаагаар эх, эцэг, төрөл садны харгалзаатай колоний байршлаас гарах.

Сахилга батын зөрчил гаргасан тохиолдолд, дараах арга хэмжээг авна. Үүнд:

- сануулах;
- сахилгад хийх;
- сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр торгох;
- чөлөөт цагт хориг тавих.

ОХУ-д, хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн ялыг "хүмүүжлийн колони" (англ correctional colony)-д эдлүүлнэ. Тус улсын хуулиар "Хүмүүжлийн колони" гэдэгт насанд хүрээгүй хоригдлыг засан хүмүүжүүлэх тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон байна. 1997 оныг хүртэл уг байгууллагыг "хөдөлмөр, хүмүүжлийн колони" гэж нэрлэж байсан бөгөөд

Хүмүүжлийн колони дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- насанд хүрээгүй этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- нийгмийн тодорхой бүлгийн зүгээс тэдэнд үзүүлж болох сөрөг нөлөөлөөс тусгаарлах;
- тэдгээрийг засарч хүмүүжүүлэх, эргэн нийгэмшүүлэх;
- нийтэд тустай хөдөлмөр эрхлүүлэх замаар, тэдэнд мэргэжлийн болон ерөнхий боловсрол олгох зэрэг болно.

Дээрх байдлаас үзэхэд, тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй хоригдлыг хүмүүжүүлэхэд чиглэсэн болох нь харагдаж байна. Эдгээр хүмүүжүүлэхэд чиглэсэн ажил хэд хэдэн өвөрмөц онцлогтой. Тухайлбал:

- хүмүүжлийн нөлөө үзүүлэх объект нь насанд хүрээгүй этгээд байна.
- сурган хүмүүжүүлэх ажлыг хорих байгууллагын нөхцөлд хэрэгжүүлнэ.
- насанд хүрээгүй хүрээгүй этгээдэд үзүүлэх хүмүүжлийн нөлөө үзүүлэх үйл ажиллагааг, тэдэнд зохих түвшинд мэргэжил, мэдлэг

боловсрол олгоход чиглэсэн сургалт-хүмүүжлийн үйл явцтай нягт уялдуулан зохион байгуулна.

Дээрх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх журмыг тус улсын Эрүүгийн ял шийтгэл хэрэгжүүлэх тухай хуулиар тогтоож өгсөн байна (141 дүгээр зүйл). Уг хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулах ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй хоригдлыг засаж хүмүүжүүлэх, бие даасан, зөв хэвшилтэй амьдралын замд залж оруулах, зохих мэдлэг, мэргэжилтэй, зөв төлөвшилтэй иргэнийг сургаж, бэлтгэх зорилгоор, хүмүүжлийн колонид, нэгдмэл хөтөлбөрөөр сургалт-хүмүүжлийн ажлыг зохион байгуулна.

Насанд хүрээгүй хоригдлыг засаж хүмүүжүүлэхэд, ерөнхий боловсролын мэдлэг олгоход чиглэсэн арга хэмжээ чухал нөлөө үзүүлнэ. Хуулийн дагуу, насанд хүрээгүй хоригдолд ерөнхий боловсролын мэдлэг болон мэргэжлийн зэрэг олгох сургалтыг, хүмүүжүүлэх колонийг түшиглэсэн оройн хэлбэртэй боловсролын дунд болон техник мэргэжлийн сургууль, сургалт-үйлдвэрийн газарт зохион байгуулна. Түүнчлэн, уг хуулиар, хүмүүжлийн байгууллагын зүгээс насанд хүрээгүй хоригдлын боловсролын болон мэргэжлийн түвшинг дээшлүүлэх бүх боломж, нөхцлөөр хангах үүрэгтэй. Энэ үүднээс, насанд хүрээгүй хоригдолд, тус улсын дунд болон дээд боловсролын тогтолцоотой байгууллагад эчнээ хэлбэрээр сурч боловсрохыг зөвшөөрдөг байна. Хүмүүжлийн колонид зохион байгуулж буй сургал, хүмүүжлийн арга хэмжээг нэгдсэн хөтөлбөрөөр явуулах бөгөөд тэрээр цогц болоод харилцан нягт уялдаатай байх зарчимд тулгуурлана.

Хүмүүжлийн колонид зохион байгуулж буй сургалт-хүмүүжлийн бүх арга хэмжээг тус байгууллагын дарга болон сургалт-хүмүүжлийн ажил эрхэлсэн орлогч дарга хариуцан зохион байгуулахын зэрэгцээ уг ажилд: сургалт-хүмүүжлийн ажил хариуцсан байцаагч; ахлах сургагч (харгалзагч); сургагч (харгалзагч); биеийн тамирын бэлтгэл, сургалт хариуцсан ахлах байцаагч; хөдөлмөр хамгаалал, аж ахуйн хангамж, үйлчилгээ хариуцсан ахлах байцаагч; ерөнхий боловсролын болон техник мэргэжлийн сургуулийн сургагч-багш; арга зүйч; клуб, дугуйлан болон номын сангийн эрхлэгч зэрэг субъектыг татан оролцуулна. Сургалт-хүмүүжлийн ажлын арга зүйн зөвлөгөөг тодорхой сургалтын чиглэл хариуцсан танхим хариуцах бөгөөд эдгээр танхимийг түшиглэн хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлыг зохион байгуулна. Уг ажлыг тус байгууллагын нэгж болох сургалт-хүмүүжлийн зөвлөл удирдан зохион байгуулна.

Хүмүүжлийн колонид зохион байгуулах сургалт-хүмүүжлийн ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулна. Үүнд:

- эрх зүйн мэдлэг олгох;
- эх оронч үзэл суулгах;
- ёс суртахууны төлөвшил олгох;
- хөдөлмөрийн хүмүүжил олгох;
- гоо сайхны боловсрол олгох;
- бие бялдрын боловсрол олгох
- гүн ухааны буюу шашны сургаал, номлолоор хүмүүжил суулгах зэрэг болно.

Сургалт-хүмүүжлийн ажлыг бүлгээр болон ганцаарчилсан хэлбэрээр, тодорхой үе шаттайгаар зохион байгуулна (элсэлт, амралт, нэгж, сургууль, техник мэргэжлийн сургууль, үйлдвэрийн газар г.м.). Сургагч-багшийн зүгээс хагас жил тутамд, насанд хүрээгүй хоригдол тус бүрийн нэр дээр сэтгэл зүйн болон сургалт-хүмүүжлийн тодорхойлолтыг гаргаж, тэдний хувийн хэрэгт хавсаргах бөгөөд тухайн хоригдлын дэглэмийг өөрчлөх эсэх асуудлыг авч хэлэлцэхэд уг тодорхойлолтыг харгалзана.

Судлаачдын үзэж байгаагаар, насанд хүрээгүй хоригдолд мэдлэг боловсрол, мэргэжил олгох замаар хүмүүжүүлэх уг сургалт-хүмүүжлийн тогтолцоо, өнөөдөр, төдийлөн үр дүнгүй байгаа тул, тус улсын төр засгийн зүгээс шоронгийн үйл ажиллагаанд тавигдаж буй европын стандартыг харгалзан, тус байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж, өөрчлөх чиглэлд онцгой анхаарч эхэлсэн байна. Тодруулбал, уг бодлогоор, тус байгууллагын үндсэн зорилт нь насанд хүрээгүй хоригдлыг эргэн нийгэмшүүлэх чиглэсэн иж бүрэн, төгс тогтолцоог бүрдүүлэхэд орших ёстой гэж үзжээ. Энэ хүрээнд эхлүүлээд байгаа томоохон ажлын нэг бол боловсруулсан насанд хүрээгүй хоригдолд зориулсан засан хүмүүжүүлэх байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, тогтолцоог шинэ хэлбэрээр зохион байгуулах үлгэрчилсэн загвар боловсруулах талаар тус улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх холбооны албаны захирал А.А.Реймерын гаргасан шийдвэр юм. Уг шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тус албаны орлогч дарга А.М.Величкогийн удирдлага дор "Насанд хүрээгүй хоригдолд зориулсан хүмүүжлийн төв байгуулах үйлгэрчилсэн загвар" сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, үр дүнг танилцуулсан байна. Уг үлгэрчилсэн загварыг, "ОХУ-ын Эрүүгийн ял хэрэгжүүлэх тогтолцоог 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал"-ыг харгалзахын зэрэгцээ шоронгийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй олон улсын стандарт болон энэ чиглэлд хуримтлуулсан арга, туршлагад хийсэн судалгааны үр дүнд тулгуурлаж боловсруулсан бөгөөд төсөл

санаачлагчдын зүгээс насанд хүрээгүй хоригдлыг сургаж, хүмүүжүүлэх байгууллагыг "Насанд хүрээгүй хоригдлыг хүмүжүүлэх төв" гэж нэрлэхийг санал болгож, тэдгээрийн ялгаатай болон давуу талыг тодорхойлсон байна.

1.Чанга дэглэмтэй насанд хүрээгүй хоригдол дараах эрхтэй. Үүнд:

- хоол хүнс болон бусад хэрэглээнд зориулж, сар бүр 9600 рубль зарцуулах;
- ар гэрийнхэнтэйгээ жилд, богиносгосон хугацаагаар 6, уртасгасан хугацаагаар 4 удаа уулзалт хийх

2. Ердийн буюу жирийн дэглэмд шилжсэн хоригдол дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- хоол хүнс болон бусад хэрэглээнд зориулж, сар бүр 10.800 рубль зарцуулах;
- ар гэрийнхэнтэйгээ жилд, богиносгосон хугацаагаар 8, уртасгасан хугацаагаар 4 удаа уулзалт хийх.

3. Хялбаршуулсан дэглэмд шилжсэн хоригдлын хувьд, дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- хоол хүнс болон бусад хэрэглээнд зориулж, сар бүр 11.400 рубль зарцуулах;
- ар гэрийнхэнтэйгээ жилд, богиносгосон хугацаагаар 12, уртасгасан хугацаагаар 4 удаа уулзалт хийх.

4. Хөнгөлттэй дэглэмд шилжсэн насанд хүрэээгүй хоригдлын хувьд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- хоол хүнс болон бусад хэрэглээнд зориулж зарцуулах мөнгөн дүн ямар нэгэн хязгааргүй;
- ар гэрийнхэнтэйгээ жилд, уртасгасан хугацаагаар 6 удаа уулзалт хийх бол богиносгосон хугацаагаар уулзахад, ямар нэгэн хязгааргүй байна.

Эдгээрээс, чанга дэглэмтэй нөхцөлд хоригдож буй насанд хүрээгүй ялтныг бусдаас тусгаарлаж буюу ганцаарчилж хорино. Харин бусад дэглэмтэй хоригдлыг нийтийн байранд байлгана.

Түүнчлэн, дээрх байгууллагад ял эдэлж байх хугацаанд, тухайн этгээд насанд хүрсэн тохиолдолд, түүнийг жирийн дэглэмтэй хорих ангид шилжүүлнэ (ОХУ-ын ЭХ-ийн 88 дугаар зүйлийн 5 дахь хэсэг). Харин онц хүнд гэмт хэргээс бусад ангилалд, насанд хүрээгүй хүүхдэд оноох хорих ялын дээд хэмжээ 6 жил байх бөгөөд хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн тохиолдолд хорих ял оноохгүй.

Тус улсын эрүүгийн хуулиар, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт ялын дээд хэмжээ болох цаазаар авах болон бүх насаар нь хорих

ялыг оноохгүй.

Эрх чөлөөг хязгаарлах төрлийн ялыг, зөвхөн үндсэн ял байдлаар 2 сараас 2 жил хүртлэх хугацаагаар оноono (ОХУ-ын ЭХ-ийн 88 дугаар зүйлийн 5 дахь хэсэг).

Түүнчлэн, тус улсын хуулиар 14 нас хүрээгүй хүүхэд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, хүмүүжлийн шинжтэй ял шийтгэл оноож болохоор заасан байгаа нь өвөрмөц юм. Шүүхийн шийдвэрээр, тухайн хүүхдийг, тодорхой дэглэмтэй тусгай сургуульд өгөх бөгөөд, энэ тохиолдолд, ял шийтгэлийн хугацааг 2 дахин бууруулж оноохоор хуульчилсан зэрэг нь онцлог юм (ОХУ-ын ЭХ-ийн 88 дугаар зүйлийн 6[1]).

Тус улсын ялын бодлогоор, ял хөнгөрүүлэх гол нөхцөлд, гэм буруутай этгээдийн насанд хүрээгүй байдлыг тооцдог (ЭХ-ийн 61-ийн "б").

Хөөн хэлэлцэх хугацааны хувьд, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн хөнгөн гэмт хэрэгт 12 сар, хүндэвтэр гэмт хэрэгт 3 жил, хүнд гэмт хэрэгт 5 жил, онц хүнд гэмт хэрэгт 7,5 жилийн хугацаатай тогтооно.

2018 онд тус улсын Ял эдлүүлэх холбооны албаны явуулсан судалгаагаар, тус улсын засан хүмүүжүүлэх газарт нийт 1500 орчим насанд хүрээгүй хоригдол хорих ял эдэлж байна. Уг үзүүлэлтийг сүүлийн 15 жилтэй харьцуулахад, даруй 10 дахин буурчээ. Тухайлбал, 2002 оны 1 дүгээр сард, тус улсын хэмжээнд, нийт 18,6 хүүхэд ял эдэлж байжээ. Гэхдээ, өнөөдөр, тус улсын ялын бодлогын чиг хандлага өөрчлөгдөж, улмаар зөвхөн хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийг засан хүмүүжүүлэх газарт байрлуулахаар хуульчилсан байна.

Дээрх эерэг чиг хандлагаас гадна, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийг хорих болон засан хүмүүжүүлэх чиг үүрэгтэй байгууллагын тогтолцоонд багагүй дутагдал оршисоор байгааг Дэлхийн хүний эрхийг хамгаалах байгууллагаас тогтоожээ.

**Англи улс:**

Английн эрүүгийн эрх зүйн субъект: Аливаа бие хүн Английн харьяат, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлагад татаж болно. Өөрийн статусын дагуу зарим хүмүүс эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгддөг журамтай. Нэгдүгээрт: Уламжлал ёсоор хаан, хатан гэмт хэрэг үйлдэж болохгүй учир хариуцлагад татагдахгүй. Хоёрдугаарт: Дипломат эрх ямбийн тухай 1964 оны хуулийн дагуу элчин болон гадаадын элчин сайдын яамны албаны бусад хүмүүс эрүүтийн мөрдөлтөд халдашгүй байх эрх эдэлнэ.

Дипломат төлөөлөгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд дээрх эрхээ эдэлнэ. Гэмт хэргийн субъект бие хүний талаар ярихад гол асуудал бол түүний хэрэг хариуцах чадваргүй байдал юм. Английн эрх

зүйд хэрэг хариуцах чадваргүй байдлыг нас, сэтгэцийн өвчин, согтууралтай холбон үздэг.

Английн эрх зүйд насанд хүрээгүй байдал-ыг хүсэл зориг байхгүйтэй холбогддог бөгөөд энэ нь эрүүгийн хариуцлага үгүйсгэгдэх шалтгаан болж болно. Английн Эрүүгийн хууль тогтоомжид насанд хүрээгүй хүмүүсийг 3 бүлэгт хуваасан байдаг.

-10 хүртэлх насны хүүхдүүд

-10-14 насны хүүхдүүд

-14-17 насны өсвөр насныхан /ял оногдуулахад 17-21 насны хүмүүсийг тэдгээртэй адилтган үздэг/.[36] Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1933 оны хууль гарахаас өмнө нийтийн эрх зүйн дагуу 7 нас хүрээгүй хүүхдийг эрүүгийн хариуцлагад татаж болдоггүй байсан.

Уг хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 7, Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1969 оны хуулиар 10 байхаар тогтоосон.

10-14 насны хүүхдийн үйлдэлд гэмт хэргийн элементийн аль аль нь Actus reus ба ments rea байгааг ямар ч эргэлзээгүй нотлохоос гадна уг хүүхэд ноцтой хохирол учруулж байгаагаа мэдэж байсныг тогтоосон нөхцөлд л түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.

Англи улсын шоронгийн тухай хууль анх 1952 онд батлагдсан байна. Эрүү, эрүүгийн байдаан шийтгэх болон ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил тасралтгүй хийгдсэний дунд 1967, 1977, 1981, 1988, 1991, 1993 онуудад тодорхой шинэчлэл хийгджээ. Англи улсын хорих болон хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт одооч олны анхаарлыг татсаар байна.

Англи улсын ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ.[37]

Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Мөн түүнчлэн: а/ богино хугацаагаар хорих ял эдлэгсэд, б/ торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгсэд, в/ 21 хүртэлх насны хүүхэд залуучууд хоригддог байна. Эдгээр төрлүүдэд ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн байдал, засрал хүмүүжлийн түвшнийг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам үйлчилдэг.

[36] Б.Ганчулуун. Английн Эрүүгийн эрх зүй. УБ.,2005 он.21-р тал
[37] а/ Лхагва.А.Дурдсан бүтээл.УБ.,2008, 2012 он
б/ “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл.УБ.,1998 он. №3, 4. 50-52 дахь тал
в/ Мөн сэтгүүл. 2003 он. №3, 189-197 дахь тал

Дэлхийн улс орнуудын хорих байгууллагад нийгмийн ажил анх нэвтрүүлсэн улсуудын нэг бол Их Британи юм. Европын хорих байгууллагын дүрмийг удиртгал болгон Их Британийн хорих байгууллага нийгмийн ажлын дараах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Хорих байгууллага бүр нийгэм-боловсролын төлөвлөгөөтэй байх бөгөөд ялтан бүр авьяас чадвар, хэрэгцээ шаардлагаа хангах бололцоотой байх;

2. Боловсрол нь засан хүмүүжүүлэх үйл явцын салшгүй хэсэг, хөдөлмөрлөхийн адил чөлөөт цагаа өнгөрүүлэх үндсэн зүйлийн нэг байх;

3. Залуучууд, гадаадын иргэд, үндэстний цөөнхөд боловсрол олгоход чухалчлан анхаарах;

4. Онцлох бэрхшээлтэй ялтнуудад тусгайлсан хөтөлбөр зохиох;

5. Хорихын боловсролын хөтөлбөр нь улс орны боловсролын тогтолцоотой адил түвшинд байж, ялтныг суллагдсаны дараа шууд үргэлжлүүлэн суралцахад саадгүй байх;

6. Ялтан мөн хорихоос гадуур суралцах эрхтэй;

Ялтныг суллахтай холбогдуулан тусгай хөтөлбөрөөр ажилладаг ба шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулга тараадаг бөгөөд түүнд ажил, сургууль, орон сууц хэрхэн олгох зэрэг мэдээлэл агуулагдсан байна.

-Насанд хүрээгүй хүмүүст зориулсан ял

Насанд хүрээгүй хүмүүст оногдуулах ял нь Английн хууль тогтоомжийн дагуу 17 нас хүрээгүй хүмүүс насанд хүрээгүйд тооцогдоно. Ял оногдуулахад 21 нас хүрээгүй залуусыг тэдэнтэй адилтган авч үзнэ. Хүүхэд болон өсвөр насныхан тухай 1969 оны хуульд зааснаар насанд хүрээгүй хүмүүсийг:

1. Хүүхэд /14 нас хүрээгүй/

2. Өсвөр насны /14-17 нас/ гэж хуваагддаг.[38]

- 10-14 насны гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хянаптын байгууллагын хяналтад өгөх. Хяналтын байгууллага нь орон нутгийн гүйцэтгэх, албадах байгууллага байх бөгөөд уг байгууллагын түшмэл буюу бусад ажилтнуудад насанд хүрээгүй этгээдийг даалган өгч тэдгээр нь насанд хүрээгүй этгээдүүдэд зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх үүрэгтэй байдаг.

- Гэмт хэрэг үйлдсэн 14-17 насны этгээдэд шүүх гэр бүл, асран хамгаалагчийн хяналтад байлгах шийдвэр гаргах эрхтэй. Энэхүү шийдвэрт гэмт хэрэг үйлдсэн этгээд хянагчийн шаардлагыг биелүүлэх, тусгай тогтоосон хугацаанд тодорхой газар оршин суух, тодорхой өдөр

[38] Б.Ганчулуун. Английн Эрүүгийн эрх зүй.УБ.,2005 он. 51 дэх тал

хүмүүжлийн төвд ирэх, 6 цагаас өглөөний 6 цагийн хооронд гэрээс гадагш гарахгүй байх /шөнийн хязгаарлалт/ мөн тодорхой өдрүүдэд ямар нэг үйл ажиллагаанд оролцохыг хориглохыг заасан байдаг байна.

- Шүүх 12-15 насны хүмүүсийг хүмүүжлийн хаалттай төвд илгээх, төвд байлгах хугацаа нь 4, 6, 8, 10, 12, 18, 24 сар байна. Тэнд байх хугацаанд нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн дадлага, боловсрол олгох бөгөөд суллагдахад бэлтгэдэг.

- Залуу хэрэгтнүүдэд зориулсан байгууллагад байлгах ялын доод хутацаа 15-18 насны хүмүүсийн хувьд 2 сар юм. Уг байгууллагаас суллагдсан хүмүүст 22 нас хүртэл нь хяналт тогтооно.

- 1982 оны хуулийн дагуу 21 нас хүрээгүй хүнд албадан саатуулах төв юм уу залуусыг хорих газарт байлгах ял оногдуулдаг байна.

- Онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан этгээд 21 насанд хүрээгүй бол түүнийг тодорхой хугацаагаар насанд хүрээгүй этгээдэд зориулсан “Засан хүмүүжүүлэх хаалттай хорих байгууллага”-д ял эдлүүлэхээр шийдвэр гаргаж болох бөгөөд 15-аас доош насны хөвүүдийг 4 сар, түүнээс бага хугацаагаар хорих ёстой.

Урьд нь хорих ялтай гэмт хэрэг 3 ба түүнээс дээш удаа үйлдсэн бөгөөд хүүхэд ба өсвөр насныхан тухай 1969 оны хуулийн дагуу тогтоосон хяналтыг зөрчсөн 12 нас хүрээгүй хүүхдийг дээрх төвд явуулах тушаал гаргах эрхийг щүүхэд олгосон.

Дотоод хэргийн сайд ялтныг хугацаанаас өмнө суллах эрхтэй. Хэрэв ялын хугацаа 8-18 сар бол ялтныг ялын хугацааны хагас өнгөрөхөөс нэг сарын өмнө уг хугацаа 18 сараас дээш бол ялын хагас өнгөрөхөөс хоёр сарын өмнө суллаж болно.

Эдлээгүй үлдсэн ялын хугацааны турш хүмүүжлийн хаалттай төвөөс суллагдсан этгээдэд хяналт тогтоох тухай тушаалд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд насанд хүрээгүй хүнийг хүмүүжлийн хаалттай төвд буцаах буюу торгох арга хэмжээ авна.

Онц хүнд гэмт хэрэг ял шийтгэгдэж байсан этгээд 21 насанд хүрээгүй бол түүнийг тодорхой хугацаагаар насанд хүрээгүй этгээдэд зориулсан засан хүмүүжүүлэх хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэхээр шийдвэр гаргаж болох бөгөөд ингэж тэдний эрхийг хязгаарлахын зэрэгцээ хяналтад байлгах, өдөр бүр хүмүүжлийн төвд явуулах, торгох, хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг арга хэмжээ авдаг.

Хяналтад байлгах шийдвэрийг шүүх гаргах бөгөөд уг шийдвэрт хянагчийн шаардлагыг биелүүлэх тусгай тогтоосон хугацаанд тодорхой газар оршин суух, тодорхой өдөр хүмүүжлийн төвд ирэх, оройн 6 цагаас өглөөний 6 цагийн хооронд гэрээс гадагш гарахгүй байх /шөнийн

хязгаарлалт/ мөн тодорхой өдрүүдэд ямар нэг үйл ажиллагаанд оролцохыг хориглодог байна.

Энэ бүхнээс үзэхэд Англи улсад 21-ээс доош насны гэмт хэрэг үйлдсэн хүүхэд, залуучууд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилго нь аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, тусгаарласан ч хамгийн богино хугацаагаар хэрэглэдэг нь харагдаж байна. Мөн Английн эрүүгийн ялын тогтолцоонд насанд хүрээгүй хүмүүст зориулсан ял гэсэн тусгай ялын төрөл байгаа нь анхаарал ихээр татаж байсан болно.

Англи улсын ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ. Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Мөн

- Богино хугацаагаар хорих ял эдлэгсэд
- Торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгсэд
- 21 хүртэлх насны хүүхэд залуучууд хоригдцог байна.

Эдгээр төрлүүдэд ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн байдал засрал хүмүүжлийн түвшнийг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам.

**Франц улс:**

Франц бол эх газрын эрх зүйн системтэй орон болох Франц Англиас ялгагдах нэг онцлог бол Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх болон пенитенциарын хууль тогтоомжийн хэм хэмжээний түүхэн эх сурвалж нь шүүхийнхээр бус, бие даасан тусгай хууль эрхийн акт байсаар ирсэнд оршино.

1992 оны 6-р сарын 22-нд дөрвөн хууль батлагдсанаар Эрүүгийн эрх зүйн бүхэл бүтэн орчин бүрдсэн гэж үздэг. Уг хуулиудын гол үзэл санаа нь хүний эрхийг дээдлэх эрх зүйт төрийн зарчмыг амьдралд хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн шаардлагыг хангаж, ялын бодлогод энэрэнгүй хандахад чиглэгджээ. Франц улсын эрх зүйн гол бааз нь шинэ Эрүүгийн хууль, 1958 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Пенитенциарын хууль зэргээс бүрдэнэ.

Насанд хүрээгүй хоригдлыг тусгайлан байгуулсан хүмүүжлийн байгууллага болон сургуульд байлгаж ялыг нь эдлүүлдэг.

Францын ял эдлүүлэх ажиллагааны нэг онцлог бол насанд хүрээгүй хоригдлын шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг явдал юм. Нөгөө нэг онцлог нь Франц улсын шүүх хоригдлын эдлэх ялын хугацааг хасаж багасгах, тэднийг хугацаанаас өмнө тэнсэн суллахад их өргөн эрх эдэлдэг

байдал юм.

Францын шинэ Эрүүгийн хуулийн 125-132 дугаар зүйлүүдэд хагас эрх чөлөөтэй байдлаар ял эдлүүлэх нөхцөлийг тодорхойлон заажээ. Энэ нөхцөлд харгалзан үзэх гол хүчин зүйлүүд нь: а/ Мэргэжлийн онцлог, шаардлага, б/ мэргэжлийн болон ерөнхий оловсролын сургалтад хамрагддаг бол, в/ курс эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс хамрагдана. Хагас эрх чөлөөтэй байдлаар шийтгэгдэн гадуур байгаа хоригдлууд ял эдлүүлэх байгууллагадаа эргэн ирж бүртгүүлж байх үүрэг хүлээдэг байна.

Францад насанд хүрээгүй этгээдийг 3 бүлэг болгож эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг ба 13 насанд хүрээгүй хүмүүс эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөх ба 13-16 насны хүмүүст хүмүүжлийн арга хэмжээг хэрэглэж болдог. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг насанд хүрээгүй хүнийг шийтгэх трибунел шийдвэрлэх ба дараах арга хэмжээнүүдийн аль нэгийг оногдуулах шийдвэр гаргаж болно.

- Эцэг, эх, асран хамгаалагч, тэднийгхарж хамгаалах үүрэг бүхий этгээдэд эсвэл итгэл хүлээх хүмүүст даалгах

- Хүмүүжил, мэргэжлийн сургалтын улсын болон хувийн байгууллагад шилжүүлэх

- Эмнэлгийн болон эмнэлэг-сурган хүмүүжүүлэх байгууллагад байлгах

- 13-16 насны хүүхдүүдэд хорих ялыг оногдуулахдаа тухайн зүйлийн санкцад заасан ялын хэмжээний талаас давсан ялыг хэрэглэхгүй мөн торгох ял оногдуулдаггүй ажээ.

16-18 насны өсвөр үеийнхэнд ял хариуцлага хүлээлгэх авч насанд хүрээгүй гэдэг утгаар хөнгөрүүлэн үздэг. Гэхдээ 13-16 насны хүмүүст хүлээлгэх ялаас арай хүнд ялыг хэрэглэдэг байна. Ер нь Францад насанд хүрээгүй этгээдэд тэдгээрийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, хяналт тавих, хүмүүжүүлэх арга хэмжээний 3 төрлийг хэрэглэдэг. Энэ нь тэдэнд ял оногдуулахдаа гол бус, ялын бус аргаар чөлөөлж, хүмүүжүүлэх, ойлгуулж ухамсарлуулахад чиглэгддэг байна.

Мөн Францад 13-16 насны хүүхдүүдэд хорих ялыг оногдуулахдаа тухайн зүйлийн санкцад заасан ялын хэмжээний талаас давсан ялыг хэрэглэхгүй мөн торгох ял оногдуулахад ч мөн торгуулийн хэмжээний хагасаас давсан торгуулийг оногдуулдаггүй нь анхаарал татаж байсан болно.

Францын эрүүгийн хуульд нийгэмд аюултай хэрэг үйлсэн 13 насанд хүрээгүй хүмүүст тэдгээрийг “хамгаалах, туслалцаа үзүүлэх, хяналт тавих, хүмүүжүүлэх арга хэмжээ”-ний 3 төрлийг заажээ.

Франц улсын ял эдлүүлэх байгууллагын бүтэц нь насанд хүргэгчдийн

төвлөрсөн болон орон нутгийн хорих байгууллага, насанд хүрээгүйчүүдийн тусгайлсан сургалт, хүмүүжлийн байгууллагаас бүрдэнэ. Насанд хүрээгүй хоригдлын тусгайлан байгуулсан хүмүүжлийн байгууллага болон сургуульд байлгаж ялыг нь эдлүүлдэг.

Францын ял эдлүүлэх ажиллагааны нэг гол онцлог бол насанд хүрээгүй хоригдлыг шашин буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг онцлог юм.

Нөгөө онцлог нь Франц улсын шүүх хоригдлын эдлэх ялын хугацааг хасч багасгах, тэднийг хугацаанаас өмнө тэнсэн суллахад их өргөн эрх эдэлдэг байдал юм.[39]

**Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:**

Герман улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад 1975 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, 1976 онд батлагдсан "Хорих ял эдлүүлэх болон хүмүүжил, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай хууль" тус тус хамрагдана.

Торгууль, хорих ял оногдуулах, түүнчлэн хүмүүжил аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зэрэг нь тус тусдаа өөрийн онцлогтой.

Торгууль бол Герман улсын эрүүгийн ял оногдуулалтад хамгийн өргөн хэрэглэгддэг. Торгуулийн ял нь 5-360 өдөр байх ба торгуульд хамруулах цалингийн хэмжээг шүүх тогтоодог байна. Ингэхдээ өдөрт ногдох цэвэр орлогоос тооцдог бөгөөд торгуулийн нийт хэмжээ нь 2-10 мянган марк байдаг.

Хорих ял нь нэг сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорих хугацаатай. Бүх насаар нь хорих гэдэг нь харьцангуй ойлголт юм. Хоригдол 15-аас доошгүй жил ял эдэлсний дараа хууний үлдсэн ялыг зохих нөхцөлтэйгөөр хойшлуулж болдог байна.

Герман улсад хорих ял эдлүүлэх ажиллагааг нээлттэй ба хаалттай хэлбэрээр эдлүүлдэг байна.[40]

Нээлтгэй хорих байгууллагад 6 сар хүртэл богино хугацаагаар хорих ял шийтгүүлэгчид, эсвэл үйлдсэн гэмт хэргийн хор аюул нь бага хоригдлын ялыг эдлүүлнэ. Харин нээлттэй хорих байгууллагыга тоо нь харьцангуй цөөн байдаг.

Хаалттай хорих байгууллага нь Герман улсын ял эдлүүлэх

---

[39] Д.Бадам, Б.Цэрэнчимэд "Монгол Улсын Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй" /схемчилсэн тайлбар/ УБ.,2003 он.179 дэх тал

[40] а/ "Эрх зүй, албаны мэдээлэл" сэтгүүл. УБ.,1997 он. №3. 17-20 дахь тал
б/ Мөн сэтгүүл. 2003 он., №2. 168-173 дахь тал, 2009 он. №2, 2009 он. №2, 67-68 дахь тал

байгууллагын үндсэн төрөл бөгөөд тооны хувьд ч олон байдаг ажээ.

Зургаан сараас дээших хугацааны ял шийтгүүлсэн насанд хүрсэн бүх хоригдол эхлээд ганцаарчилсан тасалгаанд байж шоронгийн амьдралтай танилцдаг байна. Энэ хугацаанд ял эдлэгсдийн дэглэм, хөдөлмөр зохион байгуулалт, сургалт, хүмүүжлийн ажлыг цаашид хэрхэн зохион байгуулахтай холбогдсон судалгаа хийгдэнэ.

Ялтнуудтай харьцах, тэдний дунд нийгмийн ажил зохиох талаар ХБНГУ-ын туршлага Европт нэлээд нэр хүндтэйд ордог. ХБНГУ-д хууль зөрчигчийг хорих хугацааг түүнийг хэвийн амьдралд эргүүлэн оруулахад зориулагддаг. Ялтныг хуульд захирагдах, өөрийнхөө амьдралын аливаа буруу алхмын хариуцлагыг хүлээх, өөрийнхөө оршин тогтнох нөхцөлийг хангаж ажиллахад сургадаг. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар хорихын болон чөлөөт амьдралын ялгааг аль болох багасгах нь тухайн хүний унаж уруудах хийгээд давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх үндсэн арга юм.

Германы шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомж нь ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц нийгэмшүүлэхээр засан хүмүүжүүлэх зорилго агуулдаг бөгөөд хариуцан явуулдаг энэ зорилтыг хэрэгжүүлэх ажлыг хорих байгууллагын нийгмийн алба хариуцан явуулдаг байна. Үүний улмаас тус улсын Хууль зүйн яамнаас хорих байгууллагуудад нийгмийн ажилтан, лам, сэтгэл зүйч ажиллахыг зөвшөөрдөг байна.

Нийгмийн ажилтан бол хорих байгууллага болон нийгмийн хооронд орших амьд гүүр нь болдог байна.

Нийгмийн ажилтны тоо нь багш, эмч, сэтгэл зүйчийн тооноос 2,5 дахин, санваартнуудын тооноос 4 дахин илүү байхаар эрх зүйгээр зохицуулагдсан байдаг. Эдгээр мэргэжилтнүүд нийгмийн штаб буюу албанд багтдаг бөгөөд аюулгүй байдал болон Дэглэмийн гэсэн албадтай зэрэгцэн ажилладаг.

Германы хорих байгууллагын нийгмийн ажлын зохион байгуулалтад хэд хэдэн онцлог байдаг. Тухайлбал, шашны үүрэг мэдэгдэхүйц их бөгөөд хорих байгууллага бүрт католик юм уу протестант шашны санваартнууд ялтнуудтай ажилладаг ба суллагдсаных нь дараа ч тэдэнтэй холбоотой байдаг байна.

Насанд хүрээгүйчүүдийг засан хүмүүжүүлэхэд нийгмийн ажилтны онцлон анхаарах зүйл бол өсвөр үеийнхэнтэй явуулах хүмүүжлийн ажлыг ирээдүйд амьдралын хууль сахих хэв маягийг амьдралдаа шингээж нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарлаж сургахад оршдог. Насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага нь дэвшилтэт тогтолцооны зарчмаар ажилладаг.

Шинээр ирсэн ялтныг ганцааранг нь нэг камерт сар орчим

байрлуулж судалсны дараа нийтийн өрөөнд шилжүүлнэ. Насанд хүрээгүйчүүдийг хорих ангиуд хэмжээний хувьд ч төдийлөн нүсэр биш байдаг нь тэднийг сайтар судалж, нэг бүрчлэн үр ашигтай үйл ажиллагаа явуулахад дөхөмтэй байдаг.

Ял эдлэгсдийг хорихоос суллах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг тул бэлтгэл ажлыг хэрхэн хангах талаар хуульчилсан байдаг. Чөлөөт амьдралд аажмаар орох бэлтгэл хангахын тулд дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас гурван сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн сар бүр 6 хоногийн чөлөө олгож, хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрх эдлүүлдэг.

Суллагдсан хүмүүсийн 40 хувь нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь Германы шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын бодит үр дүн гэж үздэг.

Хуулийн дагуу суллагдсан хүнд ажил, орон байр олгодог. Суллагдсаны дараа очих газар хүртэлх замын зардал, мөн ажлын хөлснийх нь хуримтлал, шаардлагатай бол хувцас олгодог. Гэр бүлийнхэнтэй нь холбож өгөх, ажил, орон сууцын зэрэг асуудал шийдвэрлэхийг нийгмийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

ХБНГУ-д Эрүүгийн хариуцлага хүлээх нас нь Германы эрүүгийн эрх зүйд 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай бие хүн гэмт хэргийн үйлийн субъект болно.[41]

Эрүүгийн хариуцлага хүлээх насыг ХБНГУ-ын Эрүүгийн хуульд бус, насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг байцаан шийтгэх тухай 1953 оны 08-р сарын 04-ны өдрийн хуульд заасан байдаг.

ХБНГУ-ын эрүүгийн хуулийн 19-р зүйлд “Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрээгүй хүнийг хэрэг хариуцах чадваргүй” гэж үзнэ гэсэн заалт байдаг.

Насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг Эрүүгийн хуулиар бус 1953 онд батлагдсан “Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх шүүхийн тухай хууль”-иар зохицуулдаг. Уг хуулиар зайлшгүй тохиолдолд л насанд хүрээгүй этгээдэд хорих ялыг оногдуулах бөгөөд дээд хугацаа нь 5 жил, доод хугацаа нь 6 сар байна. Хэрвээ гэмт хэргийг шилжилтийн насны охид, хөвгүүд үйлдсэн бол дээд хугацаа нь 10 жилээс хэтэрч болохгүй.

Мөн насанд хүрээгүй этгээдэд баривчлах арга хэмжээг хэрэглэдэг бөгөөд энэ нь 2 хэлбэртэй байдаг.

1. Урт хугацааны 1-4 долоо хоног байх ба ажил, хичээлийн бус

[41] Б.Ганчулуун. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүй. УБ.,2005 он. 19 дэх тал

цагаар хэрэглэнэ.

2. Богино хугацааны ажил, сургуульд нь саад болохгүйгээр 6 хоногоос илүүгүйгээр тус тус хэрэглэдэг ажээ.

Олон улсад, насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хатуу бөгөөд тэргүүлэх байр суурьтай орны нэг бол ХБНГУ юм. Өсвөр насны хоригдол (тус улсын хуулиар 14-21 настай хүнийг хэлнэ)-ыг хорих шоронгийн нөхцлийг дээд зэргийн түвшинд бүрдүүлсэн байна. Тухайлбал, тухайн шоронд, мөргөл хийх ариун сүмийн газар, бие бялдрын танхим, спорт заал, сургалтын өрөө, теннисын талбай, номын сан, эмчилгээний өрөө, гал тогоо, талх болон нарийн боовны цех үйл ажиллагаа явуулна. Түүнчлэн, тус улсын шоронгууд, мэс засал, оношилгоо, эмчилгээ хийхэд зориулагдсан өндөр хүчин чадал бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж болон нарийн мэргэжлийн эмч нараар хангадсан байхын зэрэгцээ насанд хүрээгүй ялтантай ажиллах сэтгэл зүйч заавал ажиллана.

ХБНГУ-д Насанд хүрээгүйчүүдийг засан хүмүүжүүлэхэд нийгмийн ажилтны онцлон анхаарах зүйл бол өсвөр үеийнхэнтэй явуулах хүмүүжлийн ажлыг ирээдүйд амьдралын хууль сахих хэв маягийг амьдралдаа шингээж, нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарлаж сургахад чиглэдэг. Насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага нь дэвшилтэд тогтолцооны зарчмаар ажилладаг.

Шинээр ирсэн ялтныг ганцааранг нь нэг камерт сар орчим байрлуулж судалсны дараа нийтийн өрөөнд шилжүүлнэ. Насанд хүрээгүйчүүдийг хорих ангиуд хэмжээний хувьд төдийлөн нүсэр биш байдаг нь тэднийг сайтар судалж, нэг бүрчлэн үр ашигтай үйл ажиллагаа явуулахад дөхөмтэй байдаг.

Герман болон баруун европын улсуудад туршилтын гэгдэх аргыг өргөн хэрэглэдэг. Энэ нь шүүхээс тогтоох нэг төрлийн дэглэм бөгөөд тухайн насанд хүрээгүй ялтны ял эдлэх хугацаанд биелүүлэх "ажлын төлөвлөгөө" гаргаж биелэлтийг нь нийгмийн ажилтан хянаж ажиллана гэсэн үг юм  Мөн хүмүүжигчдийг чөлөөт амьдралд зугуухан орох бэлтгэл хангахын тулд дэглэмийг зөөлрүүлж болох ба суллагдахаас 3 сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн сар бүр 6 хоногийн чөлөө олгож, хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрх эдлүүлдэг.  Суллагдсан хүмүүсийн 40% нь эхний 5 жилд ямар нэгэн хэмжээгээр хууль давтан зөрчдөггүй гэсэн тооцоо гарсан нь Германы Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын бодит үр дүн гэж үздэг.

*Герман улсын Реймшайдын хүүхдийн баривчлах хаалттай хорих анги:*

Хүүхдийн хорих ангийн дарга хүүхдийн шүүгч байх ёстой гэж

хуулинд заасан байна. Учир нь ял эдэлж байгаа хүүхдүүдэд хуулийн зүгээс тусгах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоох, дүгнэлт хийх чадвартай байдаг. Нийт 25 албан хаагчтай.

Хүүхдийн хорих ял нь 6 сараас эхлэн 10 жил хүртэлх хугацаатай байдаг. Учир нь хоригдол хүүхдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд доод тал нь 6 сар байх ёстой гэж үздэг байна. Харин 1930 онд хүүхдийн баривчлах ялыг хуулиар баталсан бөгөөд энэ нь 2-28 хоногийн хугацаатай байдаг байна. Энэ ял нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг богино хугацаанд хатуу шийтгэж цочрол өгөх, биеэ зөв авч явахад нь нөлөөлөх, туслах зорилготой.

Хүүхдийн баривчлах ял нь албан ёсоор гэмт хэргийн бүртгэлд ордоггүй, намтар болон цагдаагийн тодорхойлолтонд бичигдэхгүйгээрээ хорих ялаас ялгаатай. Хүүхдийн баривчлах хорих ангид нийт 70 хүүхэд хоригдож байна.

- 14-17 насны
- 18-21 насны гэсэн 2 хэсэгт хуваагддаг. Нийт хүүхдүүдийн 1/3 нь хулгай, 1/3 танхай, 1/3 нь хар тамхи, авто ослын хэрэгтэй байна.

Баривчлах хорих ангийн гол үйл ажиллагаа нь хоригдож байгаа хүүхдүүдийг хүмүүжүүлэхэд чиглэгдсэн. Хүүхэд хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд зөвхөн нийгмийн ажилтан сэтгэл зүйчийн орон тоо хангалтгүй гэж үздэг учраас ангийн албан хаагчдыг хос мэргэжилтэй байхыг шаарддаг. Тухайлбал, мужааны мэргэжилтэй албан хаагч нь хүүхдүүдэд мужааны сургалт явуулах, худалдааны мэргэжилтэй албан хаагч нь өрхийн орлого зарлагыг хэрхэн төлөвлөх зэргийг заах, цаашлаад өргөдөл, захиаг хэрхэн бичих зэрэг сургалтуудыг зохион байгуулдаг байна. Үүний тулд тухайн чиглэлийг сонирхдог хүүхдийн бүлэг бүрдүүлэх ёстой бөгөөд албан хаагч нь сургалтын хугацаанд амралт, чөлөө авахгүй байх шаардлагатай.

Тус ангийн бас нэг гол үйл ажиллагаа нь хүүхдүүдийг өдрийн дэглэмд сургах, ажил хийж сургахад чиглэгддэг. Хоригдож буй хүүхдүүдийг нийгмийн сайн сайхны төлөө цэцэрлэгт хүрээлэнд модны ажил хийлгэх, гудамж цэвэрлэх, амьтан арчлах, асрамжийн газар зэрэгт цалингүй ажиллуулдаг. Ингэхдээ хүүхдүүдэд ажлын үр дүнг нь мэдрүүлж тайлагнаж байх ёстой байдаг.

Анх хүүхдүүдийг хүлээж авахдаа:

1. Бичиг баримттай нь танилцан үзлэг хийнэ;
2. Өрөөнд нь хуваарилан ахуйн хэрэгсэл олгоно;
3. Дотоод дүрэмтэй танилцуулан, ямар ямар сургалт, эмчилгээнд хамрагдахыг тодорхойлдог;

Нийтдээ 8 душны өрөөтэй, 7 хоногт 2 удаа ордог, ажил хийдэг бол 2-оос илүү орж болно. Хүүхдүүд өрөөндөө ганцаараа байх зориулалттай 3 өрөө байдаг. Энд хорлож болзошгүй хүүхдийг өөр нэг хүүхэдтэй хамт оруулдаг. Хорих өрөө нь камергүй, харин дотроо дохиоллын системтэй. Хүүхдүүдийг өдөрт 1 цаг салхилуулдаг.

Өдөр тутмын ажлыг чанаржуулах, хүмүүжлийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний системийг ашигласан байна. Хүүхдүүд өдөр бүр, өдөрт 2 удаа харуул хамгаалалтын ажилтнаас үнэлгээ авдаг. Үнэлгээ нь -1, -2, 0, +1, +2 гэсэн онооноос бүрдэх ба ямар нэг зөрчил гаргаагүй тохиолдолд /+/ оноог тухайн албан хаагч өөрийн үнэлэмжээр өгдөг. Тухайн хүүхдийн цуглуулсан оноо /-1/ -ээс дээш гарсан тохиолдолд улаан хуудас, /0/-оос /+22/ хооронд шар хуудас, нэмэх оноо цуглуулан /+23 / онооноос эхлэн ногоон хуудас авдаг. Улаан хуудас авсан хүүхэд гадагш гарах эрхгүй, өрөөндөө ганцаараа хооллож, тоглох, салхилах эрхгүй болох ба энэ байдлаас эргэн гарах, алдаагаа засах боломж олгох зорилгоор /-10/ оноогоор хязгаарладаг.

Харин ногоон хуудас авсан хүүхэд нь нэмэлт янз бүрийн сонирхолтой зүйл хийх эрхээр шагнуулдаг. Тухайлбал тодорхой цагаар компьютер тоглох, утсаар ярих, зурагт үзэх гэх мэт. Харин шар тэмдэг нь анхааруулах агуулгатай байдаг. Ногоон тэмдэг авсан хүүхдийн оноог /+24/-өөр хязгаарладаг. Ногоон хуудас авах нэмэх оноо нь их байгаа нь тухайн хүүхдийн сахилга бат, эмх цэгцийг удаан хугацаанд сахиулж, өөрт нь хэвшүүлэх зорилготой юм[42].

**Вьетнам улс:**

Вьетнамд насанд хүрээгүй этгээд болгоомжгүй болон санаатай боловч хүнд биш гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй. Тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын агуулга нь хүмүүжүүлэх, нийгэмд хэрэгтэй хүн болгохын тулд тэднийг зөв хөгжихөд нь туслалцаа үзүүлэх нь гол зорилгыг агуулдаг бөгөөд үүндээ чиглэсэн тусгай сургуулиудыг олноор байгуулжээ. Энэхүү засан хүмүүжүүлэх сургуульд 1-3 жил хүртэл байх бөгөөд хүмүүжил сайтай хүүхдүүдийг тогтоосон хугацаанаас өмнө сулладаг.

**Америкийн Нэгдсэн Улс:**

XIX дүгээр зууны хоёрдугаар хагас бол Дэлхийн улс орнуудын ял эдлүүлэх ажиллагааг дэвшилттэй хэлбэрээр зохион байгуулах эрэл хайгуул идэвхтэй хийгдсэн үе байлаа. АНУ-ын шоронгийн өөрчлөлтийн эрэл хайгуул нь шинэ хэлбэрийн хүмүүжлийн байгууллага буюу хоригдол

---

[42] Пүрэвсүрэн,О.(2014).”Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа”.УБ:.х.60.

залуучуудыг сургалтад хамруулах байгууллага бий болсноор дуусгавар болсон байна. Анх тус байгууллагыг 1876 онд Эльмайр хотод байгуулж, Энэ хорих байгууллагад 16-30 хүртэлх насны залуучуудыг ял эдлүүлэхээр ангилан хувиарладаг.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулж тусгайлан байгуулсан газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндэхийн дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг. Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хоножболдог байна. Энэ байдал хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг болох нь практикаар нотлогджээ.

Насанд хүрээгүйчүүдийг засан хүмүүжүүлэхэд тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн асрамжийн газар зэрэгт тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг туршлага байдаг. Эдгээрийг улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд мөн нийгмийн ажилтан голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Өсвөр үеийнхэнд зориулсан явуулах нийгмийн ажилтны үйл ажиллагааны үндсэн зорилго нь чухам энэхүү шийдвэрлэх насан дээр яваа хүүхдүүдэд бүх талаар тусалж, урьдчилан сэргийлэхэд чиглэгдцэг онцлогтой.

АНУ-ын хувьд нийгмийн ажилтан шүүхэд ч, хорих байгууллагад ч, мөн туршилтын хугацаанд ч байнга оролцоотой байгаа нь тухайн ялтны засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон ялан эдлэх түүнчлэн суллагдсаны дараа ч гэсэн хараа хяналттай байлгадгаараа сайн талтай.

АНУ-ын олон мужид цагдаагийн байгууллага нь эрүүгийн хавтаст хэрэг нээхийн оронд хохирогч хүүхэд хоёрын хооронд зуучлах замаар асуудлыг нь зохицуулах арга хэлбэрийг сонгох эрхтэй хэмээн заасан байна. Энэ нь хохирогчид тухайн хүүхдийн үйлдсэн гэмт үйлдлийн талаар өөрийн бодол санаа, төрсөн мэдрэмжийн талаар болон тухайн хүүхдийн үйлдсэн гэмт үйлдэл нь өөрт нь хэрхэн нөлөөснийг хэлж ярих боломж олгодог байна.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулж тусгайлан байгуулсан газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндэхийн дэглэм, харуул хамгаалалтын нөхцөлд насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй уян байдаг.

Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хоножболдог байна. Энэ байдал нь хоригдлуудын хүмүүжилд нөлөө үзүүлдэг болох нь практикаар нотлогджээ. АНУ-ын хувьд, хэдийгээр хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд, мөн тэргүүлэх барй суурьтай орны нэг боловч, сүүлийн судалгаанаас

үзэхэд, тус улс нь шоронд хоригдож байгаа насанд хүрээгүй хүүхдийн тоогоор 90.000 хол давсан үзүүлэлттэйгээр дэлхийн тэргүүлэгч орны нэгд тооцогдож байна. Түүнчлэн, тус улсын хуулиар, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн 13-14 насны хүүхдэд ялын дээд хэмжээ болох цаазаар авах ялыг оноохоор зохицуулжээ. Үүнтэй ижил зохицуулалтыг, мөн Танзани, ӨАНУ, Израиль зэрэг орны хуульд тусгасан байдаг.

АНУ-ын хуулиар, ялын дээд хэмжээ авсан ялтны шийтгэлийг хугацаанаас өмнө суллах эрхгүйгээр, уг ялыг бүх насаар нь хорих ялаар сольж оноохоор заажээ. Гэхдээ, тус улсын муж бүр өөр өөрийн өвөрмөц хуультай. Тухайлбал, 26 мужийн хуулиар, насанд хүрээгүй хүүхдийн зүгээс, харгалзан үзэх тодорхой шалтгаангүйгээр төрсөн гэрээсээ оргон зугтсан, эсвэл сургуулиа орхисон тохиолдолд, түүнийг шоронд хорих ялаар шийтгэж болохоор заасан байна. АНУ-ын ихэнхи шорон эмэгтэй болон эрэгтэй гэсэн ангилалтай бөгөөд, харин хүүхдийн хувьд насанд хүрсэн хоригдлоос тусдаа ял эдэлнэ.

**Шинэ зелланд:**

Шинэ Зеландын насанд хүрээгүйчүүдтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу онц ноцтойгоос бусад бүх хэргийг хохирогч хүүхэд болон нийгмийн гишүүдийн дунд асуудлыг зуучлан зохицуулдаг байна. Ингэхдээ гэр бүлийн зөвлөлөөс дамжуулан шийдвэрлэхийг шаарддаг. Энэ нь гэр бүлийн зөвлөлд тусгай хүүхдийн эрх зүйн зохицуулагч нарыг бэлтгэн ажиллуулж, хүүхэд болон тэдний ар гэрийнхэнд тустай үйлчилгээ үзүүлж байхаар томилдог байна.

Насанд хүрээгүй этгээд болон хохирогч тэдгээрийн ар гэрийнхэн болон тухайн оршин сууж буй газрын нийгмийн гипгүүд тухайн үйлдсэн хэргийн талаар хэлэлцүүлэгт оролцож, учруулсан хохирлыг нөхөн барагдуулах болоод хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх явдлыг баталгаажуулахын тулд юу хийгдэх ёстой талаар санал бодлоо солилцдог байна.

Ар гэрийнхэн болон нийгмийн гишүүд нь хүүхдийг харж хандах, түүнд шаардлагатай туслалцаа дэмжлэг үзүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагаа тодорхойлдог байна. Мөн хүүхэд учруулсан хохирлоо нөхөн барагдуулахын тулд юу хийх ёстойг шийдвэрлэн гэрээнд гарын үсэг зурцгаадаг байна. Энэхүү гэрээнд голчлон уучлал гуйх, сэргээн тогтоох арга хэмжээ авах, нийгэмд тустай хөдөлмөр эрхлэх болоод хүүхэд гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тодорхойлох зэрэг арга хэмжээг тусгасан байдаг.

Хэрэв тухайн хүүхэд өөрийн үйлдсэн гэмт хэрэгт гэмшин, зөвшилцөн тохирсон зүйлээ биелүүлж чадвал тухайн хэргийг бүртгэлд оруулдаггүй

байна.

Ерөнхий Эрүүгийн хуулиасаа салбарласан салбар Эрүүгийн хуульд насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тусгайлан хуульчилсан АНУ, Герман, Испани, Япон зэрэг улсууд байдаг.

Тухайлбал: ХБНГУ-д 1871 оны /1978 оны 3-р сарьга 10-ны өдрийн найруулга/ холбооны Эрүүгийн хуулиас салбарласан 1953 онд баталж, 1974 онд шинэчлэн найруулсан "Хүүхэд, залуучуудын Эрүүгийн хууль" үйлчилдэг ба энэ тусгай /нэмэлт/ эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн 14-18 насанд хүрээгүй хүмүүс /хүүхдүүд/ болон 18- 21 насны залуучуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Гэхдээ "Хүүхэд, залуучуудын Эрүүгийн хууль" нь зөвхөн насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилсан эрүүгийн эрх зүйн төдийгүй тэдний үйлдсэн хэргийг мөрдөн шалгах, пгүүн таслах болон ял эдлүүлэх эрх зүй хэм хэмжээг тусгасан байдаг.

**Япон улс:**

Япон улсад мөн Эрүүгийн хуулиас гадна салбарласан тусгай Эрүүгийн хууль болох "Залуучуудын Эрүүгийн хууль" үйлчилдэг бөгөөд "Залуучуудын Эрүүгийн хууль"-ын 20-р зүйлд "...гэмт хэрэг үйлдсэн 14-16 насны этгээдэд эрүүгийн ял хэрэглэхгүй бөгөөд 16-20 насны этгээдэд цаазаар авах, албадан хөдөлмөр хийлгэх, хорих ял шийтгэхээр зааснаас бусад гэмт хэрэгт эрүүгийн ял хэрэглэж болохгүй..." гэж заасан байдаг.

Японд 14-20 насны гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хэргийг зөвхөн гэр бүлийн шүүх л хянан шийдвэрлэдэг.

Ихэнх тохиолдолд уг шүүхээс насанд хүрээгүй этгээдэд хүмүүжил, хамгааллын шинжтэй, хяналтын арга хэмжээг хэрэглэдэг ба зайлшгүй тохиолдолд л ял оногдуулдаг байна.

Япон улсын шоронгийн тухай хууль 1908 онд батлагдан зохих нэмэлт өөрчлөлт орсоор шинэ зуунтай золгож байгаа юм. 1950 онд "Суллагдагсдад тусламж үзүүлэх тухай" 1958 онд "Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай хууль"-ууд батлагдан гарч үйлчлэх болов.

Япон улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих, баривчлах байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага багтана.

Японы ял эдлүүлэх байгууллага нилээд төвлөрсөн байдалтай боловч нарийвчилсан ангилалтай байдаг. Хорих ял шийтгэгдсэн бүх хоригдол эхлээд ангилан хуваарилах төвд ирдэг.

Дараа нь тэднийг дараах байдлаар хуваарилж ялыг нь эдлүүлдэг. Үүнд:

1. Бага, багавтар хэмжээний гэмт хэрэг үйлдэгсэд;

2. Гадаадын иргэд;

3. 8-аас дээш жил ял эдлэх хүмүүс;

4. 20 хүртлэх насны залуучууд;

5. Сэтгэл мэдрэлийн болон бусад өвчтэй, биеийн эрүүл мэндээр сул дорой хүмүүсийг тус тусад нь байлгаж ял эдлүүлдэг.

Японд хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах эрх зүйн үндэс нь хөдөлмөрийн хууль тогтоомж юм.

Хоригдлууд өдөрт 8, долоо хоногт 44 цаг ажилладаг байна. Хоригдлын дунд хүмүүжлийн ажил зохиохдоо аль болохоор олныг хамарч хавтгайруулахгүй байхыг хичээдэг онцлогтой.

**Казахстан улс:**

Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд Хорих ял шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдийн харьцаанд тогтоосон журам нь ерөнхийдөө ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн холбогдох зохицуулалттай адил[43] боловч дараах онцлогийг тодотгож болно.

а. Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ялыг эдлэх байгууллагыг "Насанд насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын түвшний байгууллага" гэж нэрлэдэг ба тэрээр бие даасан хорих байгууллагыи торол мөн.[44]

б. Хэрэв ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн дагуу энэ улсад хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүид тоон хязгаарлалтгүйгээр илгээмж, гуйвуулга авахыг зөвшөөрдөг бол Казахстан улсын хувьд ердийн нөхцөлд ял эдэлж буй насанд хүрээгүй ялтан жилд 10, хөнгөвчилсөн нөхцөлд тус бүр 6 илгээмж гуйвуулга авах, мөн хөнгөн нөхцөлд тоон хязгаарлалтгүй удаан хугацааны уулзалт, хатуу нөхцөлд жилд 2 удаагийн уулзалт, тус бүр 6 илгээмж гуйвуулга авахыг зөвшөөрдөг.[45]

Мөн хуулийн 154-р зүйлийн 2 хэсэгт ял эдлэх тогтоосон журмын ноцтой зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны үйлдэл, эс үйлдэхүйг журамлаж өгсөн. Энэ нь:

1. Байгууллагыг тохижуулах, амьдрах нөхцөлийг сайжруулах ажил хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзах,

2. Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх,

---

[43] Тус улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 150 дугаар зүйл

[44] Тус улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 89 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт

[45] Тус улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 151 дүгээр зүйл

3. Байгууллагын захиргааны төлөөлөгчдийг заналхийлэх, доромжлох, тэдэнд захирагдахгүй байх болон ял эдлэх дэглэм зөрчих зорилгоор санаатайгаар биедээ ямар нэгэн гэмтэл учруулах,

4. Байгууллагын дотоод журамд тусгагдаагүй эд зүйлс, баримт бичиг, хэрэгсэл, бодис, хүнсний зүйлийг олж авах, дамжуулах, бэлтгэх, хадгалах,

5. Материаллаг болон бусад ашиг олох зорилгоор хөзөр, мөрийтэй бусад тоглоом тоглох,

6. Шүүхээс тогтоосон зайлшгүй болон албадлагын эмчилгээнээс зайлсхийх

7. Сексийн шинжтэй үйлдэл хийх,

8 Энэ хэсгийн 1-7 дэд хэсэгт заасан зөрчил гаргахад чиглэсэн ялтны бүлэглэлийг зохион байгуулах эсвэл түүнд оролцох,

в/ Насанд хүрээгүйчүүдийг хорих байдлын дунд түвшний байгууллагад 18 нас хүрсэн ялтныг тэдний саналыг авч 21 нас хүртэл нь байлгаж болох ба үүнийг байгууллагын даргын тодорхойлолтын үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

**Турк Улс:**

Диярбакыр нэртэй шоронд өнөөг хүртэл, хүүхдийг насанд хүрсэн ялтантай хамт ял эдлүүлсээр байна. Энэ нь, тус улсын хууль тогтоомжтой холбоотой бөгөөд тус улсын Эрүүгийн хуульд, насанд хүрээгүй хүүхдийн хорих ялын хугацааг тодорхой зааглаж өгөөгүйтэй холбоотой. Үүнээс гадна, тус улсын шорон, хамгийн хүнд нөхцөлтэйд тооцогдохын зэрэгцээ хоригдлын хувьд эмнэлгийн наад захын тусламж авах, ариун цэвэр сахих боломжгүй, шоронгийн өрөөний ачаалал туйлын их зэрэг хорих газарт тавигдах стандарт, шаардлагыг хангаагүй байдаг байна.

**Эстони Улс:**

Турк Улсын адил, тус улсын шоронд, насанд хүрээгүй хүүхдийг томчуудын хамт хорьдог байна. Гэхдээ, тус улсад шоронг эрэгтэй, эмэгтэй гэсэн хэлбэрээр ялгадаг. Өнөөдөр, Эстони Улсад, насанд хүрээгүй хүүхдийг хорих хоёр төрлийн шорон бий. Эхнийх нь, Харку хэмээх эмэгтэй хоригдлын хаалттай хэлбэрийн шорон, нөгөөх нь, Вильянд хэмээх эрэгтэй хоригдлын хаалттай хэлбэрийн шорон бөгөөд эмэгтэй шоронд өнөөдрийн байдлаар нийт 5 хүүхэд хоригдож байгаа бол, эрэгтэйчүүдийн шоронд 13-21 насны 100 гаруй хүүхэд ял эдэлж байна. Эдгээр шоронгийн гол онцлог нь, хоригдлыг нас болон хүйсийн ялгаагүйгээр сургалтад хамруулж, тэдэнд бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон мэргэжил олгохын зэрэгцээ, ял эдлэх хугацаанд болон ялын хугацаа дууссаны дараа ажлын байраар хангахад бүх талаар дэмждэг байна.

Харку шоронгийн хувьд, 3 нас хүртлэх бага насны хүүхэдтэй эмэгтэй хоригдолд, хүүхдийг эхтэй нь хамт байлгах боломж олгосноос гадна уг шоронд ял эдлэх хугацааны дээд хязгаарыг 4 жилээр тогтоож өгсөн байна.

Мөн зохион байгуулалтын хувьд, эдгээр шоронг, ажлын болон амьдрах байрнаас гадна үс засах газар, эмнэлгийн тусламж үзүүлэх өрөө зэргийг тусгайлан засаж тохижуулжээ.

**Беларусь Улс:**

Тус улсын хувьд хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрээгүй ялтныг засан хүмүүжүүлэх арга барилаас татгалзаж, тэдгээрийг тусгай мэргэжлээр сургаж, бэлтгэх чиглэлд түлхүү анхаарах болжээ. Энэ үүднээс, насанд хүрээгүй хүүхдийн хорих байгууллагын "Засан хүмүүжлийн колони" гэсэн нэрийг "Хүмүүжлийн төв" гэж сольсон байна. Ингэснээр, тус төвд хоригдож байгаа насанд хүрээгүй ялтан, энгийн хувцас өмсөх, бэлэн мөнгө хэрэглэх, боловсролын байгууллагад суралцах (захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн), ажлын байр эрж хайхад зориулж, богино хугацаагаар гадагш явах зэрэг хөнгөлтийг эдлэх болжээ.

**Босния Герцеговин:**

Босния Герцеговинд Чука сурган хүмүүжүүлэх төв ажилладаг. Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт, хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг.

Уг төвд хүүхэд 6 -12 сарын хугацаанд байх ба 7 хоногийн 4 өдрийг тухайн төвд, 3 өдрийг эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтанд өнгөрүүлдэг. Орон нутгийн ял хойшлуулахыг хариуцах байгууллага нь өөрийн нэгжид дээрх төвийг байгуулдаг ба 2 ажилтан нь хөтөлбөрт хяналт тавьдаг. 8 сайн дурын ажилтан /сургуулийн оюутан/ ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг. Хүүхдийн шүүх нь Чукагийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад шүүхийн шийдвэрийг явуулдаг болсон.[46]

[46] Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан.,УБ.2006., 482 дахь тал

## “Олон Улсад насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан хорих ял эдлүүлэх жишиг хөтөлбөр”

### Үр нөлөөтэй хөтөлбөр болон үйлчилгээ

Нийгмийн аюулгүй байдлыг хангахын тулд насанд хүрээгүйчүүдийн ял эдлүүлэх тогтолцоо нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийг засан хүмүүжүүлэхэд чиглэгдэж ирсэн. Гэвч нэг маргаантай асуудал нь тэднийг засан хүмүүжүүлэхээс илүү амьдралд бэлтгэн гаргах гэдэг дээр яригддаг. Маш олон газар залуучуудад чиглэсэн хууль, шүүхийн тогтолцоо нь тэднийг хүмүүжүүлэх, хэрэгцээ шаардлагад нь тулгуурласан байж чаддаггүй ч тэдний зорилго нь залуучуудад нийгмийн эерэг сайн туршлагыг олгох болон шинэ зүйл суралцах боломжыг олгоход чиглэгдэж байдаг.

Насанд хүрээгүй хүүхдийг шүүх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн чухал ач холбогдол бүхий зорилт нь тэднийг засан хүмүүжүүлэх болон нийгэмд бэлтгэн гаргахад чиглэгддэг бөгөөд төрийн байгууллагууд хохирогч болсон эсвэл эрсдэлт байгаа залуусын эерэг хөгжилд чиглэсэн дараах зүйлсийг олж авч болох хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхийг уриалдаг. Үүнд:

1. аюулгүй байдлаа хангах тогтолцоог ойлгох
2. холбоо харилцаа, гишүүнчлэлийн талаарх ойлголт
3. өөрийгөө үнэлэх болон нийгэмд хувь нэмэрээ оруулж болох талаар ойлголт
4. бусдаас хамааралгүй өөрийн амьдарлаа авч явж болох талаарх ойлголт, (v) бусадтай ойр дотно харилцаа холбоо үүсгэх талаарх ойлголт зэрэг багтна.

Залуучуудын шударга ёсны төлөө эвслийн тайланд Эерэг залуусын шудрага ёс хэсэгт: Эерэг залуучуудын хөгжлийн үзэл баримтлалыг ашиглан шударга ёсны оролцоог бий болгох” гэж Жеффри Баттс, Гордон Баземор, Аундра Мерое нар санал нэгдсэн байна.

Тэд хэлэхдээ эерэг залуусын хөгжил (ЭЗХ) бол гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх нэг төрлийн арга бөгөөд энэ аргаар дамжуулан тэдний хэрэгцээг таниж мэдсэнээр тэдэнд тохирсон тусламж дэмжлэгээр дамжуулан нийгмийн эерэг бүтээлч гишүүн болох мэдлэг ур чадвар олгох мөн түүнчлэн тэдэнд үйлчилгээ үзүүлэх чухал гарын авлагын загварыг гаргах боломжтой гэжээ. “the concepts and principles of positive youth development (PYD) [articulated in the Title II of the JJDPA

Нэмж хэлэхэд (ЭЗХ)-ийг дэмжсэн хөтөлбөр болон хөтөлбөрийн үйл ажиллагаанууд хорих байрны орчин нөхцөлийг сайжруулах, ачаалал ихтэй

хэсгүүдэд гарах асуудлуудыг бууруулах, ажилчдын аюулгүй байдлыг хангах, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэдэг.[3]

Хөтөлбөрийн үндэслэл

Хоригдож байгаа насанд хүрээгүйчүүдийн хувьд ихээхэн сэтгэлийн түгшүүртэй, мөн өс санасан дайсганасан мэдрэмжтэй байдаг. Зарим хүүхдүүд зожигдуу, өөрийгөө тусгаарласан байдаг бол зарим нь хэт түрэмгийн байдаг. Мөн зарим түгшүүрт автсан хүүхдүүд өөрийн жинхэн мэдрэмжээ ил гаргаж чаддаггүй. Тэд ихэвчлэн бухимдалтай самуурсан байдаг бол хорих газар тэдний энэ мэдрэмжийн илүү дэврээдэг. Тэдний ихэнх нь насанд хүрэгчид, эрх мэдэлтнүүд болон нийгмийг үзэн ядсан мэдрэмжтэй байдаг. Бусад хэсэг нь бага насандаа ямар нэг сэтгэлзүйн гэмтэл авсан, хүүхэд насанд нь таагүй зүйл тохиолдож байсан зэрэг нь тэдний зан авирт ихээхэй нөлөөлдөг. Зарим нь маш хүчтэй гэмт хэрэгт татагдах болон нийгмийн эсрэг мэдрэмжтэй байдаг. Айдас түгшүүр, уур хилэн нь хөдөлсөн залуусыг тэдэнтэй ижил мэдрэмжтэй залуус эсвэл насан хүрэгчидтэй хамт байлгаснаар адилхан ял үүрэх эрсдэлтэй тул зохих арга хэмжээг авахгүй бол асуудал үүсгэх болно

Хорих байгууламжууд нь залуусыг албадан хорьж, түрэмгий цочмон авирыг нь хязгаарлан, нийгэмшүүлэхийн тулд ажилж байдаг. Энэхүү үйл ажиллагааны тодорхой хэсэг нь тэдний зан үйлийг хянахад чиглэгдэж байдаг бөгөөд ингэснээр тэд өөрсдийгөө болон бусдад ямар нэг аюултай зүйл хийдэггүй. Мөн түүнчлэн тэднийг өөрсдийгөө буруутгаж, одоо байгаа нөхцөл байдалдаа сөрөгөөр харах өнцөгийг өөрчилж амьдралдаа илүү үр дүнтэй зорилго тавихад нь тусалдаг.

Залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх нь хорих байгууллагын маш олон зорилгуудыг хэрэгжүүлэх илүү үр нөлөөтэй, үр дүнтэй арга юм. Тэр ч байтугай маш хязгаарлагдмал үйл ажиллагаатай хөтөлбөрүүд байсан хорих ангид засуусын нүүр тулах асуудлуудыг хөнгөвчилж байдаг.

Хүмүүжигчид хаана, ямар газар хоригдож байгаагаас үл хамааран (Насанд хүрээгүй хүүхдүүдийн хорих анги дахь сайн туршлагын талаархи анхны ширээний гарын авлагад тусгасан хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд өнөөдөр ч үр дүнгээ өгсөөр л байна.

- Сайн боловсруулсан хөтөлбөрүүд нь хоригдож буй хүүхдүүдийг илүү завгүй байлгаснаар тэдэнд ямар нэг сөрөг зүйлс бодох цаг зав өгдөггүй. Хүүхдүүд өөрийгөө болон бусдыг гэмтээх, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сүйтгэх талаар бодохоос илүү хөтөлбөрөөс гарах эерэг үр дүнд төвлөрдөг.
- Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээр дамжуулан хүүхдүүд олон төрлийн нийгмийн дүрд ордог бөгөөд энэ нь тэдний өөрсдийгөө буруутгаж харах

өнцөгийг өөрчилж өгдөг. Мөн өөрийгөө хянахдаа асуудалтай хүүхдүүдийг түрүүлж илрүүлэх хэрэгтэй байдаг. Илүү цочмог, түрэмгий хүүхдүүд нь хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагаа, дүрэм журмаар дамжуулан хянаж болох ба эсвэл багш ажилчдын илүү ойрын удирдлага зохион байгуулалт хэрэгтэй байдаг. Харин хорих байранд байх үед тэдэнтэй хамт хүмүүжигчийн санаа бодол тэдэнд ихэвчлэн нөлөөлдөг.

- Нилээд олон төрлийн нөхцөл байдлууд нь хүмүүжигч хүүхдүүдийн давуу болон сул талуудыг үнэлэх боломж олгодог. Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь ажилчид болон хүүхдүүдийн хооронд харилцаа холбоо үүсгэж өгдөг. Энэ харилцаа холбоогүйгээр өөрийгөө тусгаарласан хүүхдэд хүрч ажиллахад хүндрэлтэй байдаг. Хөтөлбөрийн тодорхой үйл ажиллагаанууд нь хүүхдүүдийн томчуудын эсрэг босгосон дайсагналын ханыг хэд хэдэн удаа нэвтрэх боломж олгодог. Хөтөлбөрийн аль ч үйл ажиллагаа нь өөрийгөө тусгаарласан хүүхдийг засан хүмүүжүүлэх үйл явцын эхлэл болж өгдөг. Гэсэн хэдий ч өсвөр насныханд хориг тавих бүх байгууламжууд (ялангуяа насанд хүрээгүй хүүхдүүдийн хорих анги, насанд хүрэгчдийн хорих анги) залуучуудыг засан хүмүүжүүлэхэд зориулагдаагүй ч засан хүмүүжүүлэх үйл явц эхэлдэг газар байдаг.
- Хүссэн зүйлээ хийж чадахгүй, өөрийн хүрээлэн буй орчин, харилцаж буй хүмүүсээсээ таагүй, айдастай байдлыг мэдэрч, ирээдүйдээ итгэлгүй байх нь хүмүүжиж буй залуусыг илүү түгшүүрт автуулдаг. Харин сайн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд тэд өөрт мэдрэгдэж буй бие болоод сэтгэлийн түгшүүрийг ил гаргахад тусалдаг.
- Хоригдож буй залуус өөрийн ур чадварыг дутуу үнэлэх, өөртөө итгэлгүй байх явдал их ажиглагддаг. Харин сайн хөтөлбөрийн үр дүнд тэд шинэ ур чадвараа олж мэдэх, шинэ зүйлд суралцах болон өөрсдийн ур чадвар, нөөц бололцоог илүү бодитоор мэдэрч, өөрийгөө харах өнцөг нь илүү эерэг болдог.
- Хорих байгууллагын ажилчид хүмүүчигч нартай хэрхэн амжилттай ажиллах нь тэдний мэргэжлийн ур чадвар, хүүхдүүдтэй үүсгэсэн чин сэтгэлийн харилцаа холбооноос хамаардаг. Энэхүү харилцааг үүсгэхэд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь төдийлөн чухал нөлөө байдаггүй.
- Ажилчдын зүгээс хэт шулуун, нээлттэй илэн далангүй харилцах нь хүүхдүүдийг өөрөөсөө үргээж, үл итгэх байдлыг үүсгэдэгь ингэснээр цаашид харилцаа үүсгэхэд саад учирдаг. Тиймээс ажилчид нь хөтөлбөрийн үйл ажиллагаанд багийн гишүүний дүрээр оролцож тэдэнд зорилгодоо хүрэхэд нь тусалсанаар итгэлийг нь олж авах, мөн төрж буй эерэг мэдрэмжүүдээ хуваалцах боломжтой. Үүнээс өмнө юун дээр хамтран

ажиллах нь тохиромжтой эсэхийг аль аль тал нь олж мэдсэн байх хэрэгтэй. Үр нөлөөтэй эерэг харилцааг үүсгэх нь төдийлөн амар зүйл биш юм.

- Чанартай хэрэгжүүлж чадсан хөтөлбөрийн хамгийн чухал үр дүн нь, хорих байгууллагын ажилчид хүмүүжигч хүүхдийг ямар хэрэг үйлдсэнээр шүүх бус хэн болохыг нь таниж мэдэхэд илүү тусалдаг.

Нийтэд нь дүгнэвэл, ёс суртахуун талаасаа ч тэр, практик талаасаа ч тэр хоригдож буй хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байдаг. Тэдэнд чиглэсэн ямар нэг арга хэмжээ хэрэгжүүлэлгүй нэг дор байлгах нь асуудлуудын эх үүсвэр болох төдийгүй. Гэмт хэрэгт холбогдсон залуусыг засан хүмүүжүүлэх, нийгэмд бэлтгэн гаргах шүүх тогтолцооны үндсэн зорилгоо хэрэгжүүлэх боломжийг алдаж байгаа хэрэг юм.

Хөтөлбөрийн зорилго:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан "Өсвөр насныхны тархины хөгжлийн талаар гаргасан судалгаанд Хүний тархины хөгжил хорь гарталаа хөгжсөөр байдаг талаар дурджээ. Тиймээс өвсвөр насныханд (ЭЗХ)-ийн зарчимд тулгуурлан хөтөлбөр хэрэгжүүлэх тархины хөгжлийн хувьд тохиромжтой үе юм.

Эрүүл эерэг залуусыг хөгжүүлэх бодидтой үр дүнд хүрэхийн тулд хөтөлбөрийн үйл ажиллагаа нь үндсэн зорилгодоо чиглэсэн байхыг заавал анхаарах хэрэгтэй. Хөтөлбөрийн биеэр оролцох эсвэл оюуны төрлийн ямар ч үйл ажиллагаа, түүний зорилго нь хөтөлбөрт оролцож буй залуус хэрэгжүүлж чадахуйц байх хэрэгтэй. Хөтөлбөрийн бүх төрлийн үйл ажиллагаа нь ажилтан болон хүүхдүүдийг хамтад нь оролцуулах, харилцаа холбоо тогтооход чиглэсэн байх ёстой. Үгүй бол тухайн үйл ажиллагаа хэрэгцээтэй эсэхийг дахин үнэлж үзэх хэрэгтэй. Хөтөлбөрийн үндсэн зорилгууд нь дараах зүйлд чиглэнэ. Үүнд

- Өөрийн сэтгэлийн зовнилоо илэрхийлэх, ил гаргах
- Биеийн энергиэ бүтээмжтэй зүйл зарцуулах
- Зугаатай болон хөгжөөнт үйл ажиллагаануудын үндсэн зорилгыг зааж өгөх
- Тэдэнд өөртөө итгэх итгэл, эрүүл өрсөлдөөний зарчмыг ойлгуулах
- Багийн ажиллагаа, шудрага өрсөлдөөн, дүрэм журамд захирагдах талаар зааж сургах
- Дургүйцлээ нийгэмд зөвөөр илэрхийлэх боломжийг ойлгуулах
- Өөрийгөө илүү ойлгоход нь туслах
- Суллагдсаны дараа цааш илүү хөгжүүлэх шинэ сонирхол, ур чадварыг нээж өгөх

- Тэднийг өдөр бүрийг завгүй, бүтээлчээр өнгөрүүлэх боломжоор хангах
- Эрүүл мэндийн зөв зан үйл, эрүүл чийрэг бие махбодийг нь хөгжүүлэх
- Насанд хүрэгчдийн талаарх буруу ойлголтыг засаж залруулах
- Залуучуудыг зан үйлийг ажиглах боломж олгох, нийгмийн ерөнхий чиг хандлагыг ойлгох

Доор дурдсан үйлчилгээнүүд нь хорих байгууллагад байгаа хүүхдүүдтэй ажиллах өдөр тутмын зорилго болон утга учрын талаар илүү дэлгэрэнгүй тайлбарласан байна. Хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилго бүрээ эргэн харж, хөгжөөнт, сургалтын болон ур чадвар бий болгох аль ч төрлийн үйл ажиллагаанууд нь дараах асуултуудад эерэг байдлаар хариулагдаж байгаа эсэхийг харна уу.

- Хүмүүжигч залуус нь үйл ажиллагаан биеийн болон сэтгэлзүйн аль ч талаараа оролцож чадан байна уу? Үйл ажиллагаанууд нь үнэхээр тэдэнд сонирхолтой байж чадаж байна уу? Үйл ажиллагааны үеээр тэд түр зуур ч гэсэн өөрийн сэтгэлийн түгшүүр болон асуудлаа мартаж чадаж байна уу?
- Ажилчид тэдний бие физиологийн биелүүлэхэд хэцүү даалгавар өгж байна уу? Үйл ажиллагааны үеээр тэд эцэж цуцаж, ядарч байна уу?
- Залуучуудын бие даасан чадварыг үнэлж байна уу? Тэд хөгжөөнт тоглоом болон үйл ажиллагааны талаар үндэн ур чадварт суралцаж байна уу? Тэдэнд тоглоомын үндсэн арга барилын талаар зааж, дасгалжуулж чадаж байна уу? Ажилтнууд нь тухайн хүний мэдлэг, ур чадвар дутмаг байгааг харгалзан залуучуудын бэрхшээлийг тодорхойлж чаддаг уу
- Ажилчид нь хүүхдүүдийг өөртөө итгэлтэй болоход нь дэмжлэг болж чадаж байна уу? Өөрийн ур чадвар, сурсан зүйлдээ илүү итгэлтэй байх талаар тэдний зоригжуулж чадаж байна уу? Өсвөр насныхан сэтгэл хангалуун байх мэдрэмжийг мэдэрч байна уу? Ажилтнууд залуучуудыг хичээл зүтгэл, амжилтаар нь сайшааж байна уу?
- Тоглоом бүрийн дүрмийн зааж өгч байна уу? Тоглоомын дүрмийг дагавал тэд илүү сайн тоглож болохыг харж ойлгож байна уу? Тэд багаар ажиллах нь илүү чухал болохыг мөн ганцаараа бол ямар алдаа гаргаж болохыг харж байна уу? Ажилчид нь тэдэнд жишээ гарган өгч шудрагаар тоглоход нь тусалж байна уу? Залуучууд нь ажилчидтай хамтран ажиллаж байна уу?
- Үйл ажиллагаа нь түрэмгий мэдрэмжээс ангижрах боломжийг олгодог уу? Ажилчид нь өсвөр насныхны дургүйцлийг төрүүлэхүйц, ичгэвтэр нөхцөл байдалд оруулахаас сэргийлж байна уу?

- Залуус өөрсдийгөө хөтөлбөрийн үйл ажиллагаанд амжилттай оролцож байгаагаар харж байна уу? Ажилчид нь тэднийг илүү өөртөө итгэлтэй болгох, аюулгүй мэдрэмж авч болохуйц тохиромжтой төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж байна уу?
- Залуус шинэ төрлийн хөгжилтэй, зугаатай хийж болох зүйлсийн талаар мэдэж авч байна уу? Залууст аливаа зүйлд хандах эерэг хандлага төлөвшиж байна уу?
- Ажилчид нь залууст суллагдсаны дараа ч гэсэн нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох сонирхол ур чадварыг суулгаж байна уу?
- Ажилчид тэднийг бие биедээ эсвэл байгууламжийн ажилчдад дайсагнасан байдал гаргах, тоног төхөөрөмжийг сүйтгэх зэрэг бодлоос ангид завгүй байлгаж чадаж байна уу? Ажилчид өдрийн турш залуучуудын оюуны болон биеийн идэвхтэй болон идэвхгүй үйл ажиллагааны тэнцвэрийг хадгалж байна уу?
- Залуучууд сайн сайхан мэдрэмжийг мэдэрч байна уу, тэд үүнийг хөтөлбөрийн хүрээнд олж авсан фитнес, чадварын үр дүн гэж ойлгож байна уу?
- Ажилтнууд өсвөр үеийнхэнд бие махбодийн хор хөнөөл учруулахаас зайлсхийхийн тулд бодит стандартад нийцсэн үүрэг даалгавар өгдөг үү?
- Ажилчид үг болон үйлдлээрээ дамжуулж залуусын хүндлэлийн хүлээж байна уу? Мөн үүгээр дамжуулан залуусд бусад томчуудыг хүндлэх сэтгэлгээ сууж байна уу? Ялж, ялагдах, тэнцэх зэрэг тоглоомын үед ажилчид хүүхдүүдтэй адил дүрмийг дагаж байна уу? Залуус ажилчдыг зөвхөн ажлаа хийж байна гэж харахаас илүү өөрсдийн багийн нэг гишүүн болоод өөрсдөд нь тусалж дэмжихийг хүсэж байгаагаар харж байна уу? Тэдний чөлөөт цагаар болон хичээл, тэмцээний үеэр ажилчид үйл ажиллагаан тэдэнтэй хамтран оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлдэг үү? Залуус үргэлж ажилчдын зөв гэж харахаас илүү бүх зүйлд шударгаар харилцана гэдэгт итгэдэг үү?
- Залуусын сонирхол болон хандлага өдрийн турш өөрчлөгдөж байгааг ажилчид ажигладаг уу? Үйл ажиллагаа бүрийн дараа ажилчид залуусын мэдлэг ур чадварт гарч буй өөрчлөлтийг харьцуулан тэмдэглэдэг үү? Ажилчид залуусын хооронд гарч буй харилцааны өөрчлөлтөд нарийн мэдрэмжтэй ханддаг уу? Ажилчид залуустай төрөл бүрийн харилцаа үүсгэснээр энэ нь тэдний хоорондох холбоог яаж өөрчилж байгааг анзаарч байна уу? Хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь оролцогчдод өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө, сэдэлжүүлэлт өгч байна уу?

Зорилгодоо чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах нь ажилчдын үндсэн үүрэг юм. Гэсэн хэдий ч ажилчид хөтөлбөрийн үйл ажиллагаанаас

залуус юу сурч байгааг анхааралтай ажиглаж идэвхтэй харилцаатай байх хэрэгтэй. Америкийн сэтгэл судлаач, боловсролын онолч Дэвид А.Колб "Туршилгад суурилсан суралцахуй: Туршлага нь суралцах ба хөгжлийн эх үүсвэр" хэмээх ном бичиж, туршлагаар дамжуулж суралцах онолыг анх танилцуулсан байна. Доорх диаграм нь Колб-ийн Туршилгад суурилсан суралцахуй сургалтын загварыг дүрслэн харуулсан бөгөөд үүнийг хэрхэн залуучуудтай хийх үйл ажиллагаанд ашиглаж болохыг харуулсан болно.

**Туршлагад суурилсан суралцахуй загвар**




**Үйл ажиллагаа.** Ажилчид ямар үйл ажиллагаа зохион байгуулах, ямар зорилго тавих, оролцсоны дараа юу олж авах талаар шийдвэр гаргана. Харин залуус биеийн болон оюуны үйл ажиллагаанд оролцно

**Ажиглалт.** Үйл ажиллагааны үеэр залуус хэрхэн хоорондоо харилцаж байгааг ажиглах. Залуус ч гэсэн өөрийн мэдэлгүй нэгнийгээ ажиглаж байдаг. Харин ажилчид тэдэнд өөрийн мэдрэмж ажиглалтаа хуваалцах боломж олгох хэрэгтэй. Мөн ажилчид өөрийн ажигласнаа хуваалцах хэрэгтэй.

**Үйл явц.** Үйл ажиллагаа дууссаны дараа ажилчид албан болон албан бусаар үйл ажиллагааны явцад юу юу болсныг бодож боловсруулж үзнэ. (Жишээ нь: Та эсвэл бусад нь хэрхэн оролцсон бэ?, Та өөрийн зорилгодоо хүрч, үйл ажиллагаагаа амжилттай дуусгасан уу? Хэрэв дуусгаагүй, зорилгодоо хүрээгүй бол яагаад хүрч чадаагүй вэ? Юу нь болж юу нь болохгүй байсан бэ? Юуг хийхэд амархан, юуг хийхэд хэцүү байсан бэ? Бүлгийн гишүүд ямар үед үйл ажиллагааг амжилттай эсвэл амжилтгүй дуусгаж байсан бэ?

**Ерөнхийлөн дүгнэх.** Залуус үйл ажиллагаанаас юу сурч, ямар туршлага олж авсан талаар ярилцах. Ингэснээр залуучуудад юу сурч мэдэж, ямар ур чадвараа хөгжүүлсэнийг нь олж мэдэх, нээн илрүүлэхэд нь туслах. Жишээ нь: Багийн ажиллагаа, харилцааны ур чадвар, зорилгоо тодорхойлох, уур бухимдалаа хянах гэх мэт.

Үйл ажиллагаатай холбоотой ажилчид залуустай ярилцаж ямар чадвараа түлхүү ашигласан, өөр ямар ур чадвар ашигласан бол илүү амжилттай байж болох байсан зэргийг дүгнэн хэлэлцнэ.

**Хэрэглэх, нэвтрүүлэх.** Залуусын үйл ажиллагаанаас сурсан зүйлс нь тэдэнд хэрхэн бусад зорилгодоо хүрэхэд болон амьдралын олон төрлийн харилцаанд амжилттай ороход тус болж байгаа талаар асууж ярилцах. Тэд ямар нэг шинэ ур чадварт суралцсан уу? Амьдрал дээр сурсан зүйлсээ хэрхэн, яаж ашиглаж байна?

Энэхүү моделийн эхний 2 үе шат нь оролцогчид үйл ажиллагаанд оролцож байхад өөрөө аяндаа болдог үйл явц юм. Харин сүүлийн 3 үе шат нь ажилчдын хувиар гаргаж, төлөвлөн хэрэгжүүлэх үе шатууд юм. Жишээ нь. Нэг цагийн үйл ажиллагаа байлаа гэж үзэхэд 15-20 минутыг сүүлийн 3 алхамын дагуу төлөвлөсөн байна.

Ажилчдад залуусын суралцах үйл явцын талаар илүү сайн ойлгоход туслах маш олон төрлийн эх сурвалжууд бий. Нэмж дурдахад, асуулттай бөмбөг, асуулттай дугуй гэх мэт сургалтын янз бүрийн хэрэгслийг сургагч багш нар ашиглаж, тэдэнд нүүр хагарах буюу зохих ёсоор асуулт тавихад нь туслах болно. Энэ аргууд нь асуулт хариултын хэсэг нь илүү уйтгартай, ажилчид болон хүүхдүүдэд тогтсон хэв маягаас зайлсхийхэд тусална. Сургалтын аргуудын талаар холбогдох дурын вэбсайтаас олж авах боломжтой.

Туршилгад суурилсан суралцахуй болон (ЭЗХ) арга барил нь тодорхой сургалтын хөтөлбөр шаарддаггүй бөгөөд тийм ч төвөгтэй биш юм. Гэсэн хэдий ч ажилчид залууст үйл ажиллагааг зориудаар төлөвлөн ямар зорилго тавьж тэднийг юунд сургах талаар бодолцож төлөвлөх хэрэгтэй.

**Нотолгоонд тулгуурласан-сайн туршлага:**

Сүүлийн үед хууль шүүхийн тогтолцоонд хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагаанд нотолгоонд тулгуурласан аргыг ашиглах талаар онцгойлон яригдаж байна. Нотолгоонд тулгуурласан аргад маш олон төрлийн тодорхойлолт байдаг ч хамгийн сайн туршлага гэдэгтэй нэгэн ижил түвшинд яригддаг. Гэвч энэ 2 ойлголт нь өөр өөрийн гэсэн утга агуулгатай.

Нотолгоонд суурилсан практикийн хорооноос Остин / Травис мужийн

Рентри дугуй ширээний уулзалтад “Тогтмол асуудаг асуултууд: Эрүүгийн шүүхийн нөхцөл байдлын нотолгоонд суурилсан практикууд” дараахь харьцуулалтыг санал болгож байна.

| Нотолгоонд тулгуурласан арга | Сайн туршлага |
|---|---|
| • Эмпирик судалгаанд онцгой анхаарал хандуулах<br>• Төөрөгдүүлэгч хүчин зүйлсийг санамсаргүй байдлаар үнэлж үзэх<br>• Тогтвортой үр дүн<br>• Cross-site replication | • Мэргэн ухаан<br>• Цаг хугацааны явцад дахин давтагдан гарах үр дүн<br>• Судалгаагаар заавал батлагдах албагүй |

Өөрөөр хэлбэл, нотолгоонд суурилсан практик нь хяналт эсвэл харьцуулалтын бүлгүүдийн судалгаа, янз бүрийн сайтуудын олон төрлийн програм дээр явуулсан, урт хугацааны туршид үнэлэгдсэн үнэлгээ гэх мэт шинжлэх ухааны аргууд дээр суурилсан байдаг. Харин сайн туршлага нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, амьдрал дээр амжилттай хэрэгжсэн бөгөөд судалгаанд, нотолгоонд суурилаагүй санаанууд байдаг.

The National Institute of Corrections (NIC), нь “Гэмт хэрэгтний эрсдлийг бууруулах” төслийнхөө хүрээнд үр дүнтэй арга хэмжээ авах 8 зарчмыг доор тайлбарласан болно.

1. **Эрсдэлийг үнэлэх/Хэрэгцээ.** Хэрэгтнүүдийн эрсдэл болон хэрэгцээг үнэлэх (динамик ба статик эрсдэлт хүчин зүйлс, криминогенийн хэрэгцээнд анхаарлаа хандуулах) бол сайн туршлагыг хэрэгжүүлэх хамгийн чухал хэсэг юм.

2. **Урам зоригийг нь нэмэгдүүлэх.** Сэдэлжүүлэх ярилцлага хийх нь ятгах үнэмшүүлэх тактик хэрэглэсэнээс илүү залууст илүү урам зориг өгч зан үйлийг нь өөрчлөх эхлэл болдог.

3. **Зорилтот интэрвенц**

a. **Эрсдлийн зарчим.** Хамгийн өндөр эрсдэлтэй хүмүүжигч нарыг нэн тэргүүнд тавьж үйлчилгээ үзүүлж, нөөцийг хувиарлах

b. **Хэрэгцээний зарчим.** Криминогенийн хэрэгцээнд чиглэсэн интервенц хийх (гэмт хэрэг өдөөж болзошгүй зан үйлд чиглэсэн)

c. **Хариуцлагын зарчим.** Залуусын хувийн ааш, суралцах арга барил, хүсэл эрмэлзлэл, хүйс, болон соёлын ялгааг анхаарч хөтөлбөртөө хамруулах

d. **Тун хэмжээ.** Бүтэц нь өндөр эрсдэлтэй гэмт хэрэг үйлдсэн залуусын 40% -аас 70% -ийг 3-аас 9 сар хүртэл хугацаагаар авна.

e. **Эмчилгээ, үйлчилгээний зарчим.** Эмчилгээ, үйлчилгээг хорих ял шийтгэлийн нэг хэсэг болгон оруулах

4. **Шууд практикаар дамжуулж ур чадварт сургах.** Сайн бэлтгэгдсэн ажилтнаад дамжуулан нотолгоонд суурилсан танин мэдэхүйн зан үйлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

5. **Эерэг талыг нэмэгдүүлж бэхжүүлэх.** Зан үйлийн өөрчлөлтийг дэмжихийн тулд сөрөг зүйлийг (шийтгэл г.м) дэмжихээс илүү эерэг зүйлийг (урамшуулах) илүү бэхжүүлэх.

6. **Тасралтгүй дэмжлэг үзүүлэх.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нийгмийн дэмжлэг үзүүлэх ажлыг бодитой болгож, идэвхтэй оролцоог хангаж, шинэ эерэг зан үйлийг бэхжүүлэх

7. **Үйл явцыг тодорхойлон хэмжих,/дадлагажих.** Нотолгоонд суурилсан аргын үндсэн зарчим нь ажилчдын үр дүн, кэйсийн талаарх нарийн мэдээллийг баримтжуулан үр дүнг албан ёсны, хүчин төгөлдөр аргаар хэмжих юм.

8. **Хэмжилтийн эргэх холбоог бий болгох.** Үр дүнг илүү сайжруулахын тулд тогтвортой байдал болон эргэх холбоог бий болгох

*https://nicic.gov/theprinciplesofeffectiveinterventions*

Нотолгоо-мэдээлэлд тулгуурласан практик нь магадгүй нотолгоонд тулгуурласан болон сайн туршлага хоёрын холимог арга бөгөөд хамгийн сайн судалгаанд тулгуурласан, онол болон практик мэдлэгт тулгуурласан арга юм. Энэ арга нь одоо байгаа судалгаа нотолгоо нь тэр бүр өөрийн гэсэн онцлогтой хувь хүн, бүлгүүдэд тохиромжтой биш бөгөөд тэдний онцлогт тохируулах өөрчлөх хэрэгтэй харуулж байна.

Нотолгоонд суурилсан болон нотолгоо мэдээлэлд суурилсан аль аль аргууд нь хүсэж буй үр дүнг гаргахын тулд үйл явцыг нарийн тайлбарласан онолын хувьд өөрчлөлт хэрэгтэй байдаг; аль аль нь програмын бүрэлдэхүүн хэсэг, протоколд тусгайлан заасан програм эсвэл процедурын гарын авлага, сургалтын материалыг боловсруулж гаргах хэрэгтэй. Нотолгоо мэдээлэлд суурилсан арга нь нотолгоонд тулгуурласан аргатай ижил нотолгоотой үр нөлөө гаргахын тулд тасралтгүй үнэлэх, сайжруулах хэрэгтэй байдаг.

Нотолгоонд суурилсан болон нотолгоо мэдээлэлд суурилсан аль аль аргуудыг мөн эрүүгийн шүүхийн шийдвэр гаргах түвшинд мөн ашиглаж болно. 2008 оны 6-р сард НИК нь орон нутгийн эрүүгийн шүүхийн тогтолцоонд нотолгоонд суурилсан шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор олон нийтийн үр дүнтэй бодлогын төвтэй түншлэл байгуулсан

Орон нутгийн эрүүгийн шудрага ёсны тогтолцоонд нотлох баримтад

суурилсан шийдвэр гаргах хүрээний баримт бичиг” -ийг 3-р хэвлэлд гаргаад НИК-ийн вэбсайтад байрлуулсан байна.

Хөтөлбөрийн найдвартай байдал:

Нотолгоонд тулгуурласан практик, хөтөлбөрт онцгойлон анхаар ч байгаа үед хөтөлбөрийн найдвартай байдлын талаар насан хүрээгүйчүүдийн шүүх тогтолцоон түлхүү яригддаг. “Найдвартай байдал” гэдгийг “Мэрриам-Вебсрер”-ийн толь бичигт тодорхойлохдоо ямар нэг зүйл өөр нэг зүйлтэй таарч тохирч байх эсвэл яг хуулбарласан байх гэжээ.

OJJDP-ын , Загвар програмын гарын авлага, Нэр томьёоны тайлбар тольд Найдвартай байдал гэдгийг тодорхойлохдоо ямар нэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн хөтөлбөрийн үндсэн зорилго, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа нь яг анх төлөвлөсөн загварын дагуу явагдах хэрэгтэй гэсэн байна. Хөтөлбөрийг үнэн зөвөөр, яг таг хуулбарлан хэрэгжүүлсэн нөхцөлд гарах үр нь мөн тогтвортой байна гэж тэмдэглжээ.

Жеймс Белл Ассошиэйтс нь “Үнэлгээний товч мэдээлэл: Хэрэгжүүлэлтийн найдвартай байдлыг хэмжих нь”хэсэгтээ хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэн зөв, найдвартай байдлыг үнэлэхдээ анхаарах ёстой 5 хүчин зүйлсийг дор дурджээ.

**1.Дагаж мөрдөх.** Ямар нэг хөтөлбөрийн загварыг авч хэрэгжүүлэхдээ хөтөлбөрийн арга, үйл ажиллагаа, хэрэглэх аргуудыг нэг бүрчлэн, нарийвчлан хэрэгжүүлэх.

2.**Хүчин зүйл.** Хөтөлбөрийн үйл ажиллагаануудыг яг үндсэн хөтөлбөрийн загварт заасны дагуу илүү ч үгүй дутуу ч үгүй хэрэгжүүлнэ. Үүнд: хэдэн удаагийн сургалт хийх, үйл явц, давтамж, үргэлжлэх хугацаа, болон оролцогчдын хамрагдалт зэрэг багтана.

3.**Чанартай хүргэх.** Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өвөрмөц арга барил. Үүнд үйлчилгээ үзүүлэгчдийн идэвх чармайлт, өөртөө итгэх итгэл, хүндэтгэлтэй байдал, асуултанд хариулах, тодорхой харилцах чадвар зэрэг зүйлс орно. Мөн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан байдлаас хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжүүлэх эсэх нь хамаарна.

4.**Оролцогчдын хариу үйлдэл.**

Хөтөлбөрт оролцогчдын оролцоо, жишээ нь сонирхлын түвшин, хөтөлбөрийн агуулгын хамаарал, ашиг тустай байдлын талаарх ойлголт, идэвх чармайлтын түвшин, оролцогчдын хэлэлцүүлэгт оролцож буй байдал, үйл ажиллагаанд нэгдэх хүсэл эрмэлзэл зэрэг болно.

5.**Хөтөлбөрийн ялгаа.** Энэ нь эерэг, хүссэн үр дүнг гаргахад зайлшгүй шаардлагатай хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох үйл явцыг хэлдэг.

Мөн товчхон байдлаар хөтөлбөрийн найдвартай байдлыг үнэлэх

аргуудаас дурдвал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэлгч болон оролцогчдын хувийн тайлан;
- Оролцогчдоос авсан судалгаа;
- Хөтөлбөрийн хүргэж буй байдалд ажиглалт хийх;
- Дата мэдээлэл цуглуулах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг боловсруулсан хүнээр нь үнэлүүлэх.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн найдвартай хэрэгжүүлэлт чухал ч гэлээ түүнийг бага зэрэг өөрчилж, өөрийн хөрсөнд буулгаж болохгүй гэсэн үг биш юм. Гэсэн хэдий ч хөтөлбөрийн өөрийн хөрсөн буулгахдаа маш сайн бодож төлөвлөсөн байх ба ямар ч хөтөлбөрийн үндсэн гол зарчимыг өөрчлөж хийж болохгүй. Үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэхдээ, хөтөлбөр нт нотолгоонд тулгуурласан биш ч бай хэрэгжилтийн найдвартай байдлыг анхаарч үзэх хэрэгтэй.Найдвартай байдлыг үнэлэх нь хөтөлбөрийг хөгжүүлэх, өөрийн хөрсөнд буулгах үйл явцын нэгээхэн хэсэн юм.

**Хөтөлбөрийн өөрийн хөрсөнд буулгах үндсэн төрлүүд**

- **Хүлээн зөвшөөрөгдөхүйц байх**
  - Өөр хэл дээр буулгах—орчуулах эсвэл үг хэллэгийг өөрчлөх
  - Залуус, гэр бүл гэх мэт зорилтот бүлэгт чиглэсэн байдлаар зургийг нь солих
  - Соёл зан заншилтай холбоотой мэдээллийг солих
  - Бие биедээ хүрэлцэх гэх мэт зарим үйл ажиллагааг өөрчлөх
  - Хөтөлбөрийг оролцогчдын сонирхолд нийцүүлэн илүү амжилттай хэрэгжүүлэхийн тулд нотолгоонд тулгуурласан зарим нэг үйл ажиллагааг нэмж болно.
- **Эрсдэлтэй эсвэл хүлээн зөвшөөрч болохгүй өөрчлөлтүүд**
  - Сургалт болон уулзалтын үргэлжлэх хугацаа, тоо, эсвэл оролцогчдын хамрагдах хугацааг бууруулах
  - Оролцогчдын харилцаа холбоог багасгах
  - Үндсэн өгөх гэж буй мессеж болон сурах ёстой ур чадварыг үйл ажиллагаанаас хасах
  - Зарим сэдвийн хасах.
  - Онолд суурилсан арга барилыг өөрчлөх.
  - Мэргэжлийн бус, бэлтгэгдээгүй боловсон хүчин, сайн дурын ажилтыг ашиглах
  - Санал болгосон тооноос бага хүн ажиллуулах

Хөтөлбөрийн төрлүүд

**Танин мэдэхүйн зан үйлийн интервенц**

Нотолгоонд тулгуурласан хөтөлбөрийн зарчим нь залуучуудын эерэг өөрчлөлтийг дэмжихийн тулд хорих байгууллагад ажилж буй ажилчдын хариуцлага, үүрэг оролцоог нэмэгдүүлэх юм. Олон хүний хувьд энэ нь аюулгүй байдал, хамгаалалт, шийтгэлд чухал ач холбогдол өгсөн хуучны хүлээлтээс нилээд өөр санагдах байх.

Харин нотолгоонд тулгуурласан арга нь ажилчдыг илүү хоригдож буй залуустай энгийн уулзалт зохион байгуулах, харилцаа холбоо тогтоох болон залуусын ур чадварыг дээшлүүлэх, залуучуудын зан байдлыг аюулгүй, илүү үр дүнтэй аргаар удирдахад нь туслах явдал юм.

**Хамгийн үр дүнтэй хөтөлбөр нь зан үйлийн менежментийн систем, танин мэдэхүйн зан үйлийн интервэнцийг хослуулсан бөгөөд байгууллагын аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн дэмжсэн өөрчлөлтөд нөлөөлөх юм.**

Танин мэдэхүйн зан үйлийн онол нь 2 өөр төрлийн сэтгэл зүйн онолоос үүсэлтэй юм. Танин мэдэхүйн онол нь хүний сэтгэхүй, түүний зан авирыг тодорхойлдог гэж үздэг. Зан үйлийн онолоор тухайн хүний амьдарч буй орчин нь тэдний зан үйлд нөлөөлдөг гэж үздэг. Энэхүү гэмт хэрэг үйлдсэн залуустай ажиллах танин мэдэхүй, зан үйлийн онолын нийлбэр нь гэмт хэрэгт холбогдсон залуусын гол асуудал нь юмыг буруу талаас нь бодох болон нийгмийн харилцаанд орох ур чадвар дутагдсанаас үүдэлтэй гэж үздэг. Эргэн тойронд болж байгаа үйл явдалыг хүмүүс бодохдоо бусдын төсөөлөл, хандлага, итгэл үнэмшлээр өдөөгддөг гэж үздэг. Энэ бодол нь хүмүүсийн мэдрэмжийг удирдаж, зан үйлийн сонголт үр дагаварт нөлөөлдөг. Зан үйлийн онолчид үзэхдээ гэмт хэрэгтнүүд өөрсдийн зан үйлийн сонголтдоо хариуцлагатай ханддаг бөгөөд тэдний сурсан мэдсэн зүйлс нь насан туршид нь тогтсон байдаг гэжээ. Зан үйлийн онолыг ашигладаг мэргэжилтнүүд нь залууст өөрт төрж буй ашиг тусгүй бодлуудыг нээн, түүнийг өдөөж буй зүйлсийг олоход нь тусалдаг. Мөн түүнчлэн тэдэнд нийгмийн эерэг харилцааны ур чадвар суулгахын тулд аливаа зүйлийн олон өнцөгөөс харах, алтернатив бодлуудыг зааж сургадаг. Танин мэдэхүйн зан үйлийн интервэнц нь ямар нэг тодорхой бүтээгдэхүүн, брэндийн интервэнцид хамааралгүй болно.Энэ нь бидний бодол санаа бидний зан авирыг тодорхойлдог гэсэн энгийн итгэлд үндэслэгддэг. Хорих байгууллагад хэрэгжүүлж буй танин мэдэхүйн үндэстэй хөтөлбөрүүд нь залуустай өдөр бүр харилцаа холбоо тогтоож, шинэ ур чадварт сургах, нийгэм соёлын сэтгэлгээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, өөрсдийн нөхцөл байдлыг зөвөөр ойлгох боломж бололцоог олгодог.

Танин мэдэхүйн хөтөлбөр нь хоёр төрөлтэй байдаг: Танин мэдэхүйн

ур чадварт сургах болон танин мэдэхүйн бүтэцийн өөрчлөлт хийх. Энэ хоёр нь хоёулаа хэрэгцээтэй бөгөөд хоригдож буй залуучуудад зориулсан хөтөлбөр боловсруулахдаа хоёуланг нь оруулах нь ач холбогдолтой юм. Харви Милкман, Кеннет Ванберг нар хэлэхдээ энэ хоёр арга нь өөр өөрийн замаар хөгжиж бэхжсэн гэжээ. (1) эерэг зан үйлд чиглэсэн бодлуудыг бэхжүүлэх (2) эерэг үр дүнд хүргэсэн зан үйлээ бэхжүүлэх. Эхнийх нь танин мэдэхүйн эмчилгээний үндэстэй, сүүлийнх нь зан үйлийн эмчилгээ юм. Танин мэдэхүйн зан үйлийн үндэс суурийг бүрдүүлэхэд дээрх хоёр хандлага хоёулаа шаардлагатай гэж зохиогчид санал нэгджээ.

**Танин мэдэхүйн бүтцийн өөрчлөлт**

Танин мэдэхүйн загвар нь тухайн нөхцөл байдлыг хэн нэгэн тайлбарлаж, бодож байгаа нь түүний зан төлөвийн сонголтод нөлөөлдөг гэсэн итгэл үнэмшилд төвлөрдөг. Тиймээс хорих байгууллагын ажилчид зан үйлийн өөрчлөлт хийхийг хүсэж байвал тэд залуусын гаргаж буй зан үйлд чиглэхээс илүү цаад учир шалтгааныг олж харах мөн тэдэнд үйлдэл хийхээс өмнө төрж буй бодлуудаа хянахад нь туслах хэрэгтэй. Танин мэдэхүйн бүтэцийн өөрчлөлт хийхээр зорьж буй хорих байгууллагын ажилчид залуусд ямар нэг асуудалтай зан авир гаргахаасаа өмнө төрж буй бодлуудаа олж мэдэхэд нь туслах юм.

Үүнийг таниж мэдсэн тохиолдолд хамгийн түрүүнд залуусд илүү бодитой, зөв зүйлд бодол санаагаа чиглүүлэхэд нь туслах мөн ижил төрлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ аргаа давтах хэрэгтэйг сануулах. Танин мэдэхүйн бүтэцийн өөрчлөлтийн интервенц нь залуусд өөрсдийг нь гэмт хэрэг үйлдэж болохуйц эрсдэлд оруулах, хэрэгцээгүй бодол санаа, сэтгэлгээний хэв маягаа ойлгоход нь туслах юм. Энэхүү ойлголтыг ойлгож, заахдаа “сэтгэлгээний гинж” хэмээх ойлголтыг ашиглаж болно. Доорх текст нь сэтгэхүй, мэдрэмж, зан байдал хоорондоо уялдаатай, дараалсан хэмээх ойлголтыг илэрхийлдэг; Ямар нэг нөхцөл байдалд төрсөн бодлууд нь бидэнд янз бүрийн мэдрэмж төрүүлдэг ба ингэснээр бид ямар зан үйл, хариу үйлдэл үзүүлэхээ сонгодог. Эцэст нт үүнээс үүдэн янз бүрийн үр дагавар гардаг.

**Нөхцөл байдал-->Бодол санаа-->Мэдрэмж-->Зан төлөв-->Үр дагавар**

Дээр дурдсан сэтгэлгээний гинж нь Иллинойс мужийн ДуПэйж орон нутагт ашигладаг Рациональ зан төлөвийн сургалт (RBT) хөтөлбөрт заагдсан, АНУ-ын олон тооны хорих газруудад хуулбарлан ашигладаг арга юм. Сэтгэлгээний гинжийн дагуу бодол санаагаа дагаж гарах зан үйл нь автоматаар болдог гэж Аарон Бек тэмдэглэжээ. Автоматаар төрж буй бодлууд нь ямарч ухамсаргүйгээр явагдаж үйлдэл хийгддэг учир хүн

өөрийгөө хянах боломжгүй байдаг байна.[16] Бэкийн хэлсэнээр зан үйл гэдэг нь хүний амьдарлынх нь турш гүн гүнзгийн тогтсон итгэл үнэмшлээс үүдэн гардаг байна. Хүний үндсэн итгэл үнэмшил нь дэлхийн талаар ерөнхий итгэл үнэмшлийн хэв шинж юм. Бусад хүмүү танд яаж хандаж байгаа шиг нь тэдэнд хандах ёстой гэж итгэдэг. Энэхүү итгэл үнэмшил нь тухайн хүн нөхцөл байдлыг хэрхэн зохицуулахад нь нөлөөлдөг байна. Хэрэв хоригдож буй залуус сөрөг үр дагавартай зүйлийг биеэрээ туулсан бол зан үйлийн менежментийн хөтөлбөрийн ажилтан залуусын сэтгэлгээний гинжийг шинжилж, хянаж үзэх хэрэгтэй. Ихэнхдээ үндсэн итгэл үнэмшил зан үйлийн хоорондоо зөрөө гардаг байна. Энэхүү аргийг ашигладаг газруудад ажилчдын хэрэглэдэг үндсэн хэрэгсэл нь сэтгэлгээний (бодол санаа) тайлан гэж нэрлэгддэг эсвэл ДуПэйж орон нутагт ашигладаг Рациональ зан төлөвийн сургалт (РЗТ) хөтөлбөр юм. РЗТ хөтөлбөр нь залуучуудыг одоогийн нөхцөл байдал, сэтгэхүй, зан байдал зэргээ тоймлон ойлгоход туслах цаашлаад сайн үр дүнд хүргэх зан үйлийн ирээдүйн хувилбаруудыг тоймлоход туслах хэсгүүдтэй.

РЗТ эсвэл сэтгэлгээний тайланг хянаж үзэх нь ажилчид болон залуучуудын хамтарсан үйл ажиллагаа юм. Ажилчдын үндсэн үүрэг нь залуустаа яриа, хэлэлцүүлэг өрнүүлснээр тэднийг сэтгэлгээний алдаатай хэсгээ олж нээхэд нь тусална: Залуу хүүхдүүд ихэнх хэсгийг үйл ажиллагааны явцад ойлгосон байдаг. Үйл явцын гол хүсэж буй үр дүн нь залуус нь бодол санаандаа, гаргаж буй үйлдэлдээ хариуцлагатай хандснаар гарах үр дагаварууд юм.

Хэлэлцүүлэг нь 3 хэсгээс бүрнэ (Санамж: РЗТ нь 2 төрлийн сэтгэлгээний гинжийг тусгасан байдаг.) Эхний нь нөхцөл байдал аль хэдийн үүссэн (хэсэг A-C3) болон бодол санаагаа эерэг, тустай зүйлд чиглүүлсэнээр хэрхэн өөрчлөлт явагдаж байгааг:

1.Нэгдүгээрт, үүссэн нөхцөл байдлыг эргэн харах, зан үйлийн гинжин хэлхээг холбосон үйл явдлыг тоймлох. Үүнд эхлээд багадаа тухайн үүссэн нөхцөл байдалд орж ирсэн 5 бодлыг жагсаан бичих, мөн бодлоос урган гарсан мэдрэмжүүдээ бичнэ. Түүний дараа ямар хариу үйлдэл үзүүлэх байсан болон ямар үр дагавар гарч болох талаар ярилцна.

2.Дараа нь, ямар нэг муу үйлдэл хийхэд хүчтэй нөлөөлж буй хамгийн аюултай бодлуудаа нээн илрүүлэх (автоматаар орж ирдэг) тэгснээр залууст тухайн бодлууд нь тустай эсвэл хор хөнөөлтэй аль үр дагаварт хүргэж байгааг тодорхойлох боломж олгох. (хэсэг D2)

3.Эцэст нь, ажилчид залууст ижил төрлийн нөхцөл байдал үүссэн үед илүү бодитой, өөртөө тустай бодлуудыг түлхүү бодож байх талаар зааж сургах. Залуучуудтай ажилж байгаа ажилчид тэдний бодол санаагаа илүү

тустай, эерэг зүйлд чиглүүлэн өөрчлөх, шинчлэхэд нь туслах. Түүний үр дүнд, бодол санаагаа өөрчилснөөр илүү эрүүл мэдрэмжид чиглэсэн шинэ сэтгэлгээний гинжийг үүсгэж, үүнээс гарах хариу үйлдэл өөрчлөгдөж, эерэг үр дүн гарах боломжтой юм.

Энэ аргаас дүгнэж үзэхэд зан үйл нь бодол санаанаас үүсдэг ба аливаа нөхцөл байдлыг ойлгож хүлээн авч эерэг зүгт бодол санаагаа чиглүүлэх боломжтой юм. Энэ өнцөгөөс харж чадвал аливаа нөхцөл байдалд зөв зохистой хариу үйлдэл үзүүлэх чадварт суралцна. Залуусд аливаа сөрөг зан үйлд хөтөлж буй бодол санаагаа хянах ойлгоход нь туслах нь хорих байгууллагад ажилж буй ажилчдын үүрэг юм.

Танин мэдэхүйн чадварыг бий болгох

Хоёр дахь төрлийн танин мэдэхүйн зан үйлийн интервэнц нь ажилтнууд залуучуудад нийгмийн ур чадвар болон асуудлаа шийдвэрлэх ур чадварт сургах, үлгэр дуурайлал өгөх, ур чадварыг нь бэхжүүлэхэд тусална. Хоригдож буй залууст суурь харилцааны ур чадвараас эхлээд, асуудлаа шийдвэрлэх, уур омогоо зохицуулж сурах ур чадварууд дутагдаж байдаг. Сайн зан үйлийн хөтөлбөрөөр эерэг үр дүн хүлээгдэж байдаг ба залуусын зохистой зан үйл нь хөтөлбөрийн урамшуулал юм. Танин мэдэхүйн бүтцийн өөрчлөлтийн нэг хэсэг нь ажилчид залуусын өөртөө ярилцаж зайлс хийх ёстой зүйлс дээрээ бус хүсэж буй үр дүн дээрээ төвлөрхийг илүү ятгадаг. Жишээ нь: Бусдад юу ч амлахгүй гэхийн оронд бусадтай зөвөөр ярилцаж ойлголцож сурах (дууны өнгө, нүдний харц, эерэг үгийн сонголт гэх мэт) Түүнчлэн нэг чухал зүйл бол залуусын өөр байгаа суурь ур чадварт анхаарах явдал юм. Хоригдож буй залуус өөр хоорондоо ялгаатай янз бүрийн гэр бүлд өсөж хүмүүжсэн байдаг ба бие биенийхээ итгэл үнэмшил, нийгмийн хүлээлтийг ойлгож хүлээж авахгүй байх нь элбэг. Залуучуудын амьдралын туршлага харилцан адилгүй тиймээс тэднээс гарах боломжгүй ур чадварыг хүлээх хэрэггүй юм. Үр дүнтэй хөтөлбөрүүд нь хүлээлтдээ хүрэхийн тулд байнга үр дүнг эргэн харж хянаж байдаг ба залуусд эзэмшүүлэхийг хүссэн зан үйлээ зааж сурган хэвшүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Үүний хувь хүн болон бүлгийн аль алинд хэрэгжүүлж болно. Хөтөлбөрт урт хугацаанд хамрагдсан залуус өөрийн сурсан мэдсэн зан үйлээ хөтөлбөрт шинээр орж буй залууст зааж сургавал илүү үр дүнтэй байж болох юм.

Хөвгүүдийн хотхон сургалтын хөтөлбөр, залуучуудад нийгмийн ур чадварыг заах гэсэн хэсэгт зан үйлд чиглэсэн хэд хэдэн заах аргын ур чадварын модель болон дутагдалтай ур чадвараа сайжруулах талаар дурджээ. Сургалтын хөтөлбөр нь хувь хүн болон бүлэгт аль алинд нь чиглэсэн байна. Антекедентийн Зан төлөв-Үр дагавар загварыг иш

татснаар энэ нь залуус хоорондийн болон тэдний хүрээлэн буй орчинтойгоо үүсгэсэн харилцаа холбоог онцлон тэмдэглжээ. Энэ загварт вакум орчинд зан үйл бие болохгүйг тэмдгэлсэн байна. Хэрэв зан үйл нь дахин дахин давтагдаж байвал энэ нь нэгэнт бэхжиж тогтсон зан үйл юм. Өөрөөр хэлбэл хүмүүс нэгэнд хийж дадсан зүйлээ дахин дахин хийсээр байдаг. Мэргэжлийн зүгээс авч үзвэл бид залуучуудаас гарч буй зан үйлийг ойлгохгүй байж болох ч тэнд тэндээс ямар нэг зүйлийг олж авч байдаг эсвэл тэдний хүссэн үр дүнг гаргаж байдаг. Хэрэв илүү хөгжлийн түвшны арга барил ашиглавал залуус зан үйлээ өөрчлөх хүчин чармайлт оролдлого гаргасны үр дүнд тухайн хувь хүний авч буй урамшуулал нь юу вэ гэдэг дээр төвлөрөх ёстой гэж үзжээ. Нийгмийн ур чадварыг хөгжүүлэхийн тулд хоёр зүйлийг хийж гүйцэтгэсэн байх ёстой гэж үздэг. Энэ нь эерэг зан үйлээ урамшуулж, буруу зан үйлээ засах юм. Буруу зан үйлээ засахын тулд өөртөө үнэнч, зарчимч байх ба түүнийгээ дагаж мөрдөх хэрэгтэй гэжээ. Ажилчдын зүгээс нэн даруй тохиромжтой авах нь дараа нь шийтгэл өгч байснаас хавь илүү гэж үздэг байна. Хорих байгууллагын хөтөлбөрүүд нь эерэг зан үйлийн дэмжсэн орчин бүрдүүлэх, эерэг зан үйлийн сонголтыг хүлээн зөвшөөрч дэмжсэн байх хэрэгтэй байдаг байна. Магтаал сайшаал болон бусад урамшуулалын аргуудыг ашиглах нь эерэг зан үйлд хөтөлдөг хамгийн үр дүнтэй аргууд юм.

Хөтөлбөр нь зохих зан үйлийг урамшуулах олон хэрэгсэлтэй байх ёстой. Урамшуулал нь нэн даруй олгох эсвэл богино болон ур хугацааны гэсэн ангилалтай байна. Зорилго нь залуусын эрхлүүлэх бус зан үйлийг нь эерэгээр өөрчлөхөд чиглэнэ.

Дупэйж орон нутгийн насанд хүрээгүй хүүхдийг саатуулах төвд ажиллаж байсан доктор асан Бернард Глос хорих байгууллагын шинэ ажилчдад дараах мессежийг үргэлж хэлдэг “Never take any positive behavior for granted.” Сэтгэлгээний энэхүү өөрчлөлт нь ажилчдад эерэг зан үйлийг бэхжүүлэх нь сөрөг зан байдлыг засахаас илүү чухал гэдгийг хүлээн зөвшөөрөхөд тусалдаг. Энэ нь огт буруу зүйлийг тоолгүй орхих эсвэл ямар нэг буруу үр дагаварт хүргэхгүй гэсэн үг биш юм. Гэсэн хэдий ч эерэг зан үйлийг бэхжүүлэх нь бидний тогтмол хийх ажил гэдгийг бид мэдэж байх ёстой. Бидний нэгэнт тогтсон зан үйлүүд давтагдсаар байдаг.

Танин мэдэхүйн зан үйлийн арга нь хорих байгууллагын ажилчдийн мэргэжлийн түвшийн дээшлүүлж байдаг. Тэдний үүрэг роль мөн ажиглагч, үүрэг даалгавар өгөгч байхаас илүү оролцогчдыг эерэг зүйлд зоригжуулагч болдог. Ажилтнууд залуучуудтай хамтран ажиллаж, өндөр эрсдэлтэй нөхцөл байдал, сэтгэлгээг олж илрүүлж, өөрөөр сэтгэж, биеэ авч явахыг уриалдаг.Ажилчид асуудалтай зан авирыг хүлээн

зөвшөөрдөггүй, залуусын талаар үнэлэлт дүгнэлт өгдөггүй ч тэдний илүү сайн зүйл хийхийг уриалдаг. Ажилтнууд нийгмийн эерэг зан үйлийн загвар жишээ гаргаж залуус түүнд суралцаж байдаг. Эерэг зан үйлийг өөрийн болгож, автоматаар хийдэг болтол нь тэднийг дэмждэг. Хөтөлбөрийн (бодол санааг төлөвшүүлэх-зан үйлийн харилцан холбоо) болон зан үйлийн менежтентийн систем аль аль нь нэгдэн сайжруулсан байгууламжийн аюулгүй байдал, болон нийгмийн эерэг зан үйлт нөлөөлөх гэдэг зорилгод хүрч болно. Залуус өөрдийн нөхцөл байдлыг харах өнцөгөө өөрчилснөөр тэд илүү эерэг зан үйлд суралцдаг.

Магадгүй танин мэдэхүйн зан үйлийн онолын хамгийн гол өгөөжтэй зүйл нь загварыг хэрэгжүүлж байх үед тэдний соёл ч мөн дагаад өөрчлөгддөг. Байгууллага нь илүү бие биенээ хүндэтгэх, халамжлах, хариуцлагад тулгуурласан олон нийт болдог. Ажилтнуудын үнэ цэнэ, хүлээлт нь залуучуудын үнэлэмж, хүлээлтээс ялгаатай биш болдог байна.

Ажилтнууд таагүй байдлаас урьдчилан сэргийл, урьдаас олж харах боломжгүй юм. Ажилчид зөвхөн сөрөг зан үйлийн үр дагавараас хамааралтай байх нь сөрөг зан үйлийг даамжруулах эрсдэлтэй. Энэ арга нь заахад хязгаарлагдмал анхаарах хандуулдаг бөгөөд залхаан цээрлүүлсэн шинжтэй арга юм. Ажилчид бодол санаандаа анхаарах хандуулах нь залуучуудын зохисгүй зан авирыг давж гарахад тусална. Энэ нь ажилчид залууст аливаа зүйлийг хүлээж авах байдлаа хянах, өөрийн сонголтондоо эзэн байхад нь туслах боломж олгодог. Ажилчид өөрийн бодож боловсруулсан зүйл, гаргаж буй шийдвэрээрээ залуусын чадавхжуулах чухал үүрэгтэй гэдгээ ухамсарлах хэрэгтэй. Залуус суллагдах үедээ хэцүү шийдвэрүүд гаргахад илүү сайн бэлтгэгдсэн байх ёстой.

Буруу хандлага зан үйлд чиглэсэн менежтент орчин нөхцөлөөс эерэг зан үйлд сургах орчин нөхцөл, соёл бий болгох түүнийгээ бэхжүүлэх нь хичээл зүтгэл шаардсан ажил юм. Энэхүү өөрчлөлтийг хийхэд залуустай хамгийн ойр байж харилцдаг хорих байгууллагын ажилчдаас ихээхэн үүрэг хариуцлагатай байхыг шаарддаг. Энэхүү соёл, орчны өөрлөлтийн хийхэд ажилчдын уялдаа холбоог хангах гол түлхүүр нь C.A.R.E хэмээх ойлголтоос эхэлдэг.[18]

- **Харилцаа холбоо:**Ямар ч байгууллагын ажилчид өөрчлөтөд эмзэг ханддаг (жишээ нь яагаад өөрчлөлт хийх болов?, энэ нь хэр удаан үргэлжлэх вэ?, энэ нь миний ажилд хэрхэн нөлөөлөх вэ ?гэх мэт) Тэдэнтэй холбоотой өөрчлөлт хийх үйл явц болон шийдвэр гаргахдаа тэдэнд асуулт асуух, санаа бодлоо хуваалцах, өөрчлөлтөд өөрийн

биеэр оролцож эхлэх боломж олгох хэрэгтэй. Албан бус ажилчид эхний ээлжинд өөрчлөлтийн ойлгож, ашиг тусыг нь мэдрэх юм бол бусад ажилчдад нөлөөлж эхэлдэг.

- **Хариуцлагатай байдал:** Байгууллагын удирдлагууд өөрсдийн гаргаж буй үйлдлээрээ тухайн соёлын өөрчлөлтийг дэмжих тал дээр хариуцлагатай хандах хэрэгтэй. Ажилчдад өөрчлөлттийг ойлгох, түүнд суралцахад цаг хэрэгтэй. Хүсэж буй өөрчлөлтийг хийж эхлэхэд нь тэдний дасгалжуулах хэрэгтэй.
- **Урамшуулах болон хүлээн зөвшөөрөх:** Шинэ өөрчлөлт, соёлыг дэмжиж буй ажилчдыг урамшуулах нь бас нэг түлхүүр ойлголт юм. Гэсэн хэдий ч өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх нь тийм ч амаргүй бөгөөд удирдлагын зүгээс өөрчлөлтийг дэмжиж буй ажилчдыг онцлон, хамт олны дунд талархалаа илэрхийлэх хэрэгтэй.
- **Өөрчлөлтийн орчин:** Хөтөлбөрийн шууд ажилтнууд нь хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлтийн явцад тулгамдаж оролцогч залуус болон ажилчдад буй бэрхшээлд мэдрэмжтэй хандах хэрэгтэй. Ингэснээр өөрчлөлтийн өөрийн гэсэн онцлогийг илүү гаргаж өгнө. Өөрчлөл хийхэд анхаарч үзэх үнэтэй саналууд ч ажилчдаас гарч болно. Ажилчдаас санаа бодлыг нь асууснаар удирдлагад ажилчдын оруулж буй хувь нэмэрийг үнэлэх боломж олгодог

**Амьдралын ур чадвар болон бие даасан амьдралын хөтөлбөр**

Хоригдож буй залууст амьдралын суурь ур чадваруудыг суулгах нь тэдэнд хамгийн үр өгөөжтэй бөгөөд хөтөлбөрийн нэг анхаарах хэрэгтэй зүйл юм. Хөтөлбөр нь залуусын нийгмийн харилцаанд бэлтгэн гаргахын тулд эерэг, үр дүнтэй харилцааны ур чадвар суулгахад анхаардаг. Амьдралын ур чадвар суулгах хөтөлбөрүүдийг насанд хүрэгчдийн хорих байгууллага болон насанд хүрэгчдийн хорих байгууллага зэрэг олон газруудад өргөн хүрээнд хэрэгжүүлдэг.

Залуучуудыг нийгэмд дахин амжилттай оруулж нийгэмшүүлэхийн тулд тэдэнд амьдралын суурь ур чадваруудыг суулгахад онцгой анхаарч хөрөнгө оруулдаг. Амьдралын суурь ур чадварууд суулгах хөтөлбөрийн үндсэн зорилго нь залууст нийгэмдээ хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй амьдрах нарийн ур чадвар суулгахад чиглэнэ. Амьдралын ур чадвар суулгах хөтөлбөр нь дараах үндсэн чиглэлүүдтэй. Үүнд:

- Боловсролын ур чадвар
- Мэргэжлийн ур чадвар
- Ажлын ур чадвар
- Нийгмийн ур чадвар

- Уур уцаараа зохицуулах,/зөрчлийг шийдвэрлэх ур чадвар
- Танин мэдэхүйн шалтгаан ба хувийн хариуцлагын ур чадвар
- Өдөр тутмын амьдралын ур чадвар

Амьдралын ур чадвар суулгах хөтөлбөрүүдийг хорих байгууллагын залууст амжилттай хэрэгжүүлэх явц нь хэд хэдэн хүчийн зүйлээс ихээхэн хамааралтай. Залуучуудад амьдралын ур чадвар суулгах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ажилнуудын мэргэжлийн түвшин, мэдлэг ур чадвар, хичээл зүтгэлээс ихээхэн хамааралтай. Хичээл зүтгэлтэй, тууштай, сэтгэлтэй ажилчид нь зүгээр нэг энгийн өдөр тутмын ажлаа хийж явдаг ажилтнуудаас илүү залууст хөтөлбөрт заасны дагуу ур чадвараа хөгжүүлэхэд нь тусламж, дэмжлэг болдог. Мөн түүнчлэн удирдлагын зүгээс хөтөлбөрийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж, нөөц бололцоо бүрдүүлэх нь мөн дэмжлэг үзүүлж ажилчид болон хөтөлбөрт оролцож буй залуусын урамшуулах, зоригжуулж байх хэрэгтэй.

Амьдралын ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрүүд нь ажилчид тогтмол дагаж мөрдөх сургалтын хөтөлбөртэй байх хэрэгтэй. Хөтөлбөрийн сэдвүүд нь бодит байдалт нийцсэн маш сайн эерэг үр дүн, үр нөлөөнд чиглэсэн байх ёстой. Хөтөлбөрийн сэдвийг бодитойгоор хүргэхэд залуучууд, ажилтнууд идэвхтэй оролцож, дахин хэлэлцэх асуудал болон байгууллагатай холбоотой асуудлыг хэрхэн оролцож шийдвэрлэх талаар төлөвлөгөө стратеги гаргана. Яагаад гэвэл хорих байгууллагад хоригдож буй залуус ерөнхийдөө богино хугацааны анхаарал төвлөрөлттэй байдаг тиймээс залуучуудыг хамруулсан лекц явуулахаас зайлсхийх хэрэгтэй.

Амьдралын ур чадварын хөтөлбөр нь бусад байгууллагад хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн нэгэн адил зорилго, зорилтдоо хүрч буй эсэхийг нь үнэлдэг байх хэрэгтэй.Ажилчид болон залуучууд хөтөлбөрийн үнэлгээнд хувь нэмэр оруулах ёстой. Энэхүү үнэлгээг зохион байгуулалттай ярилцлага, санал асуулга, сэтгэгдэл, саналын хэлбэрийг ашиглан цуглуулж болно. Цуглуулсан үнэлгээ, мэдээлэл нт хөтөлбөрийг сайжруулахад ашиглагдна.

Үр дүнтэй хэрэгжүүлсэн хөтөлбөр нь залууст нийгэмд амжилттай эргэн нэгдэхэд нь туслахаас гадна тэдний хорих байгууллагад гаргаж буй ахиц дэвшилд нөлөөлдөг. Бие даасан амьдралын хөтөлбөр нь залуусыг мөн нийгэмд амжилттай эргэн нэгтгэх үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг юм. Бие даасан амьдралын хөтөлбөр нь ерөнхийдөө гэр бүлийн орчиндоо эргэн нэгдэх боломжгүй, арай ахимаг насны залууст зориулсан хөтөлбөр юм. Эдгээр залуусыг хорих байгууллагаас амьдрах орон байраар хангаж хорих байгууллагын зүгээс эсвэл гэрээт байгууллагаар дамжуулан дэмжлэг

үзүүлсээр байдаг. Амьдралын ур чадварын хөтөлбөр нь тэдний нийгэм бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлдэг. Залуусд тогтвортой ажил хийх, гэр бүлийн санхүүгээ төлөвлөх, зохицуулах, боловсрол, эрүүл мэнд, сайн сайхан байдлаа хангах зэрэгт заавар, чиглэл авдаг.

Бие даан амьдрах хөтөлбөрт залуус ерөнхийдөө аль нэг түвшний кейс менежментийн үйлчилгээ авч, мөн нийгэмшүүлэх үйл ажиллагааны ажилтнаас зөвөлгөө (батлан даалт,тэнсэн харгалзах, нөхөн сэргээх үйлчилгээ, эргэн нэгтгэх ) авч хяналтанд байдаг. Залуучуудыг бие даан амьдрахад шаардлагатай ур чадвар олж авах, улмаар бие даасан амьдралын хөтөлбөрөөс албан ёсоор чөлөөлөхөд чиглэсэн зорилгоор харьяа байгууллагууд эсвэл бусад байгууллагууд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлдэг. Бие даасан амьдрах хөтөлбөрийн хүлээлт, гэрээний заалтуудыг биелүүлээгүй бол залуучуудад хөтөлбөрөөс хасагдах, залуусын хорих анги эсвэл өөр газруудад буцаж орох зэрэг олон үр дагаварт хүргэж болзошгүй юм.

**Хүүхдийн хорих газрын эцэг эхчүүдэд үзүүлэх нөлөө**

Ихэвчлэн хүмүүс хорих газар, түүнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн талаар бодохдоо тэнд хоригдож буй хүүхдүүд дээр нэн даруй төвлөрдөг. Хорих ял авсан залууст маш том цохилтод ордог, ялангуяа анх удаа хоригдож байгаа бол. Тэд ихэвчлэн гэр бүлээсээ тусдаа байх, хувийн аюулгүй байдал нь алдагдах, зэргээс айдаг ба бусдаас тусгаарлагдсан, бүтэлгүйтсэн мэт мэдрэмж авдаг. Үр дүнтэй хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд тэдний энэ сөрөг мэдрэмжүүд нь үр дүнтэй суралцах байдалд шилждэг. Хорих байгууллага нь зөвхөн залууст нөлөөлөөд зогсохгүй эцэг эхчүүдэд ч мөн танил бус мэдрэмж төрүүлдэг. Эцэг эхчүүд ихэвчлэн өөрийн хүүхдийн аюулгүй, байдалд санаа зовдог.Мөн хорих хугацаа хэр удаан үргэлжлэх тал дээр эргэлзээтэй байдаг. Тэд шүүх тогтолцооны талаар өөрсдөө суралцах хэрэгтэй болдог. Тэд мөн хорих цагдахтай холбоотой гарах зардал нь гэр бүлд нь нэмж эдийн засгийн асуудал үүсгэхээс санаа зовдог.

Маш олон эцэг эхчүүд хүүхдээ хоригдох үед хаана ямар алдаа гаргаж хүүхдээ ийм байдалд хүргэснээ гайхдаг. Зарим нь хүүхдээ буруу хүмүүжүүлсэн гэж харамсаж, зарим нь магадгүй одоо хорих байгууллага тэдний хүүхдийг хүмүүжүүлнэ хэмээн найдаж хүүхдээсээ татгалзаж хаях ч тохиолдол байдаг. Хүүхэд нь хоригдсоноор эцэг, эх асран хамгаалагчид нэгэн шинэ төрлийн асуудал үүсч байгаа юм. Эдгээр асуудлууд нь өмгөөлөгч авах, шүүх дээр очих, цагдан хорих байрны ажилтнуудтай уулзах, асрамжийн газрын ажилтнууд, нийгмийн ажилтнууд, сэтгэл судлаач нартай уулзах гэх мэт асуудлуудыг давж гардаг. Хэрэв хоригдож

буй хүүхэд нь айлын том хүүхэд бол түүний хариуцлага, үүрэг роль нь түүний дүү нарт шилждэг. Зарим тохиолдолд гэр бүлийн хориглож буй залуу гишүүд гэр бүлийн орлогын эх үүсвэрийг олдог бол цагдах хорих үйл ажиллагаа нь гэр бүлийн эдийн засагт сөрөг нөлөөтэй юм.

Энэ нь тус байгууллагын ажилтнуудад залуучуудын эцэг эхтэй хамтран ажиллах, манлайллын үүрэг гүйцэтгэх маш том боломж юм. Хорих анги нь эцэг эх, асран хамгаалагч, насанд хүрээгүй хүмүүсийн шүүх, эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоотой харилцах хамгийн эхний цэг байж болно. Байгууллагын ажилтнууд зөвхөн залуучуудад төдийгүй тэдний гэр бүлийн гишүүдэд мэдээлэл, туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд бэлэн байх ёстой.

Эцэг эхчүүдэд чиглэсэн хөтөлбөр болон үйлчилгээ:

Ямааны мах халуун дээрээ гэдэг хуучны үг байдаг. Залуус цагдан хоригдох үед ямар нэгэн хөтөлбөр, үйлчилгээгээр дамжуулан тэдэнтэй харилцаа холбоо тогтоох бүрэн боломжтой байдаг. Эцэг эхчүүд нь хүүхдийнхээ талаар өөр хэний ч мэдэхгүй хамгийн ховор зүйлийг сайн мэдэх нэгэн бөгөөд тэднийг үйлчилгээ, интервенц үзүүлэх хамтрагчаа гэж харах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд эцэг эхчүүд нь залуус хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг.Мөн түүнчлэн хүүхдийг нийгэмд амжилттай эргэн нэгтгэх төлөвлөгөөг эцэг эхтэй хамтран гаргахад чухал.

Маш олон эцэг эх, асран хамгаалагч нар өөрсдийгөө хүүхэд асран хүмүүжүүлэх шинэ ур чадварт суралцах хэрэгтэй гэж үзэж янз бүрийн сургалт, курс, уулзалтанд хамрагдахад бэлэн байдаг. Зарим нь бүр хувьчилсан зөвөлгөө авахыг хүсдэг. Сайн бэлтгэгдсэн байгууллага болон ажилтнууд нь хүүхэд болон гэр бүлүүдэд хямралын үеийн интервэнц, гэр бүлийн зөвөлгөө, эцэг эхчүүдийн өөртөө туслах бүлэг, хорт зуршлаас сэргийлэх хөтөлбөр зэрэг үйлчилгэг санал болгож болно. Гэр бүлийн бүлгүүдэд чиглэсэн зөвөлгөөг мэргэшсэн сургагч багш хэд хэдэн эцэг эхчүүдэд долл хоног бүр 60-90 минут зохион байгуулснаар эцэг эхчүүдэд хямралаа даван туулах болон асран хамгаалах ур чадвараа нэмэгдүүлэхэд маш их үр нөлөө үзүүлдэг байна. Эцэг эхчүүдийн өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааны үеэр тэд бие биенээсээ шинэ зүйл суралцаж, сурсан аргаа гэр бүлийн нөхцөл байдалдаа тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой болдог. Тэд магадгүй ижил төрлийн асуудлаа амжилттай шийдэж чадсан эцэг эхчүүдээс зааварчилгаа авдаг. Ихэвчлэн сургагч нар зөвхөн уулзалтыг зохион байгуулахад л хангалттай бөгөөд эцэг эхчүүд өөрсдөө тулгамдаж буй асуудлуудаа ярилцдаг. Эцэг эхчүүд өөрсөдтэйгөө ижил хямралд өртсөн бусад эцэг эхчүүдтэй уулзах боломжтой. Үүний үр дүнд тэд хүүхэдтэйгээ

ажиллах шинэ арга барилд суралцдаг. Эцэг эхчүүдийн бүлэг нь одоо хүүхэд нь хоригдож буй эцэг эхчүүд болон өмнө нь хүүхэд нь хоригдож буй эцэг эхчүүдээс бүрдэж болно.

Сургагч багш нар мөн бүлгийн хэлэлцүүлэгт түр саатуулах байгууллагын ажилтан болон халамжийн ажилтны хамруулж болно. Энэ тохиолдол эдгээр ажилтнууд бүлгийн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэн хүүхэд нь суллагдсан ч хөтөлбөрийн хяналтан байгаа хүүхдүүдийн эцэг эхчүүдийг хамруулж болно.

Бусад төрлийн эцэг эхчүүдийн бүлэг ч мөн ажмилттай хэрэгжих боломжтой. Мансууруулах бодисын чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдээр дамжуулан эцэг эхчүүдэд боловсрол олгох боломжтой. Ингэснээр тэд хүүхдэдээ мансууруулах бодис хэрэглэж буй шинж тэмдгийг олж мэдэж, асуудлыг шийдвэрлэх боломжтой эх үүсвэрүүдийг мэддэг болно. Энэ үед эцэг эхчүүд өөрсдийн хорт зуршлийг олж мэдсэнээр мөн өөртөө туслах боломжтой. Зарим тохиолдолд, хямралын үеийн интервенц болон хохирогчийн мэдлэг нь эцэг эхчүүд болон бусад гэр бүлийн гишүүдэд хэрэг болдог. Тиймээс эцэг эхчүүдийг бүлгийн үйл ажиллагаанд оруулснаар гэр бүлд нь ач тустай юм.

Гэсэн хэдий ч залуусын хоригдох хугацаа ихэвчлэн богино байдаг гэсэн ч энэ богино хугацаанд гэр бүлийн хэрэгцээнд чиглэсэн хөтөлбөр үйлчилгээг хэрэгжүүлж болно.

Гэр бүлийн хөтөлбөр нь гэр бүлийн нөхөрсөг айлчлалын бодлогоос эхэлдэг. Хорих байгууллагууд нь гэр бүлийн айлчлалыг хамгийн багадаа долоо хоногт хоёроос доошгүй удаа байхаар зохион байгуулах хэрэгтэй. Гэр бүлийн гишүүд ч мөн өөрсдийн цаг заваа зохицуулан хувиарын дагуу хүүхэдтэйгээ  уулзаж байх хэрэгтэй.

Анни Э.Кейси Juvenile Detention Alternatives Initiative (JDAI) байгууллагын үнэлгээний стандартад айлчлалтай холбоотой дараахь зүйлийг зөвлөж байна.

1.Хоригдож буй залуус дээр эцэг эх, асран хамгаалагч, хамаатан садангууд нь зочилж болно. Мөн тэд утас болон емэйлээр харилцах боломжийг ажилчид олгодог. Бага насны хүүхдүүд (дүү нар эсвэл үеэлүүд) хорих байгууллагын ажилтны зөвшөөрөлтэйгөөр уулзаж болно. Уулзалттай холбоотой дүрэм журам, зөвшөөрөл зэргийг зочилж буй хүмүүс тодорхой тайлбарлаж өгөх.

2.Гэр бүлийн уулзалт долоо хоногт хэд хэдэн удаа байж болно. Хорих байгууллагын ажилчид уулзалтын хугацаа, дүрэм журам зэргийг гаргана.

3.Хэрэв гэр бүлийн гишүүд хувиараас өөр цагт уулзах болвол байгууллагын удирдлага болон хувиар гаргасан хүнтэй уулзаж зөвшөөрөл

авна.

4.Биечлэн уулзах хугацаа нь багадаа нэг цаг байна. Байгууллагын аюулгүй байдалд эрсдэлтэй гэж үзвэл биечлэн уулзахыг зөвшөөрөхгүй байж болно.

5.Ажилчид сахилгын хариуцлагад орсон залуусын уулзалтын тоог хасаж болохгүй. Хэрэв уулзалтын нөхцөл байдал нь байгууллагын аюулгүй байдалд эрсдэлгүй гэж үзвэл.

6.Уулзалтын үеээр гэмт хэрэг, оргон зайлах, байгууллагын аюулгүй байдалд заналхийлж болзошгүй үндэслэл бүхий сэжиг байхгүй тохиолдолд ажилчид уулзалтыг ойроос хянах шаардлагагүй бөгөөд, зөвхөн өрөөг гаднаас нь хянана.

7.Ажилчид уулзалтын явцан хорих байгууллагад ямар нэг хууль бус, хориглосон эд зүйлс оруулахаас сэргийлнэ. Үүнтэй холбоотой дүрэм журмыг нарийн тодорхой гаргана.

8.Хэрэв шаардлагатай гэж үзсэн онцгой тохиолдолд, зочилж буй хүмүүсийн хориотой зүйл авч орох эрсдэлтэй гэж үзвэл гаргасан дүрэм журмын дагуу металь хайгч зэрэг багаж зэмсэг ашиглаж болно. Үүнтэй холбоотой дүрэм журмаа тухайн хүнд тодорхой танилцуулна.

9.Зочилж буй хүмүүс залууст үзүүлж буй үйлчилгээний талаар асуух болон гомдол мэдүүлж болно. Байгууллагын ажилтан болон удирдлагын зүгээс гомдол саналд нэн даруй хариу өгч ажиллана.

10.Хоригдож буй залуучуудын гэр бүлүүд тэдний санаа зовоох асуудлын талаар санал бодлоо солилцож, сайжруулах санал боловсруулж, байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээллийг олж авах боломжтой.

11.Хорих байгууллагад нийтийн унаагаар очих боломжгүй бол холбогдох унаа тээврийн асуудлыг зочдод зориулж зохион байгуулах хэрэгтэй.

Нэмэлт хөтөлбөр

Сайн дурын ажилтан, сургагч ( мэнтор) хөтөлбөр

Сайн дурын ажилтнууд, сургагч нар нь тухайн байгууллагийн үйлчилгээ, идэвхтэй ажил, үйл ажиллагаануудыг сайжруулахад өөрсдийн цаг зав, хүч хөдөлмөрөө зориулдаг хүмүүс юм. Сайн дурын ажилтнууд, сургагч нарыг хөгжлийн бэрхшээл ,арьс өнгө, хүйс эсвэл үндэс угсаанаас үл хамааран тэдний ур чадвар, хувийн шинж чанаруудыг суурьлаж сонгосон байдаг. Үйлчилгээнүүдийн зарим нийтлэг жишээ бол сайн дурын ажилтан ,сургагч нар амралт зугаалга, зөвлөгөө өгөх, сургалт эсвэл хувийн сургагч багш хийх болон бичиг хэргийн ажилуудыг хийж чаддаг. Сайн дурын ажилтнууд, сургагч нарын ашиглах тухай дагаж мөрдөх асуудлууд

нь чухал ач холбогдолтой юм.

- Сайн дурын ажил, сургагч нар доод тал нь 21настай байх, хэрэг болсон үед лицензтэй эсвэл зохих сургалт дүүргэсэн байх .
- Бүх сайн дурын ажилтнууд, сургагч нар уг байгууллагын болон сайн дурын ажилтан, сургагч хөтөлбөрт зориулсан бодлого, журмыг мэдэж, дагаж мөрдөх ёстой. Сайн дурын ажилтнууд, сургагч нар агентлагийн статус болон тухайн хүний нэр нь үүнийг тодорхойлдог гэсэн зарим тодорхойлолтын маягтыг хүлээн авах ёстой.
- Сайн дурын ажилтнууд, сургагч нар байгууллагын ажилчидтай адил даатгал болон  хариуцлагын дүрэм, журмуудын дагуу ажиллах ёстой.
- Сайн дурын ажилтнууд, сургагч нар байгууллагын ажилчидтай төстэй байдлаар ажлын ярилцлагын явц явигдах ёстой бөгөөд сайн  дурын ажилтнууд, сургагчдийн албан тушаал бүрт ажлын байрны тодорхололтыг боловсруулсан байх, ирээдүйн сайн дурын ажилтнууд, сургагч нар нь багадаа гурван тайлбар захиа бэлдэж өгөх ёстой бөгөөд тэдгээрийн нэг нь ажилтай холбоотой байх ба мэдээллийг зөвшөөрөх гарын үсэгтэй байх.
- Аливаа хөтөлбөррүү сайн дурын ажилтан, сургагчийг албанд томилохоос өмнө гэмт хэрэгт холбогдож байсан эсэх хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн хүчилхийллийн бүртгэлийг шалган явуулсан байх ёстой учир нь залуучуудтай шууд харилцан нөлөөнд оруулдаг тул. Хяналт шалгалтуудыг ажилтны суурь сурвалжууд болон бусад асуулгуудтай нийцүүлэн төлөвлөсөн байх.
- Сайн дурын ажилтан, сургагч нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд уг байгууллага нь боловсон хүчний файл үүсгэж, сайн дурынхан насанд хүрээгүй хүүхдийн  мэдээлэл  нууцийн тухай мэдэгдэлд гарын үсэг зурсан байх.
- Бүх сайн дурын ажилтан, сургагч нар цалинтай ажилчин гишүүдтэй адил журам, байгууллагын бодлогын талаарх тойм, ижил чиг хандлага хүлээж авах ёстой мөн аливаа сургалтад оролцохыг нь дэмждэг байх ёстой тул агентлагийн ажилтнуудад орон зайг нь хүлээн зөвшөөрч тогтмол санал болгодог.
- Байгууллагын удирдах албан тушаалтан нь сайн дурын ажилтан, сургагч нарын залуучуудад болон байгууллагад үзүүлдэг хувь нэмрийг албаны үүднээс хүлээн зөвшөөрч, таниж мэдэх.
- Бүх сайн дурын ажилтан, сургагч нар нь хянагдсан байх ёстой. Сайн дурын ажилчид, сургагч нар байгууллагын бодлого, журмуудыг зөрчсөн зөрчлүүдийг өнгө үзэмж харалгүй шударга байдлаар шийдвэрлэсэн байх .
- Боломжтой бол сайн дурын ажилтан, сургагч үйлчилгээнүүд тухайн байгууллагын бэлдсэн жилийн төсөвт багтсан  байх .

- Байгууллагад ажиллаж байгаа оюутнууд, томилогдсон дадлагажигч нь тухайн сургууль, сургалтын хөтөлбөр болон байгууллагын хооронд байгуулсан дадлагажигчийн гэрээний дагуу ажиллах ёстой болохоос сайн дурын ажилчин, сургагч хөтөлбөрийн бодлого, журмуудийн дагуу биш юм.
- Сайн дурын ажилтан, сургагч үйлчилгээнүүдийн талаарх тайланг жил бүр бэлтгэж, хэрэгцээний тооцоо болон хөтөлбөр дуусах үнэлэлт зэргийг тухайн байгууллагын захиргаанд хүргүүлсэн байх.

Тэгш эрх болон олон нийтийн сэргээгдэх шудрага ёс

дунд үеэс тэгш эрх, шударга ёсыг сэргээх загвар 1980-аад оны сүүлчээр түгээмэл болсон нь гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн боломжит хувилбар болж ирсэн.

Тэгш эрх, сэргээгдэх шудрага ёс нь тусгайлан бэлдсэн хөтөлбөр гэхээс илүүтэй гүн ухааны бүтэцтэй гэж үздэг боловч энэ нь хорих ангиудын дунд ашиг тустай залуучуудад үйлчилдэг хөтөлбөр бөгөөд, нөлөөллийн хэрэгжилт ба хөгжилд үндсэн бүрэлдэхүүн ажлыг бэлдэж өгдөг.

Хөтөлбөрийн хөгжилд тэгш эрх, сэргээгдэх шудрага ёсны зарчмуудыг ашигласнаар байгууллагууд нь залхаан цээрлүүлэх болон шийтгэлийн төвлөрлөөс эерэг өөрчлөлт, сэргээгдэхийн нэгрүү шилжиж чадах юм.

Сэргээгдэх шударга ёсны үндсэн зарчимууд нь дараах байдлаар байна.

- Гэмт хэрэг бол гэмтэл
- Гэмт хэрэг нь хувь хохирогчид, олон нийт болон насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд хохирол учлуулдаг бөгөөд аливаа зүйлийг зөв хийх үүргийг бий болгодог.
- Бүх талууд тухайн хохирогч (хэрвээ тэр эрэгтэй эмэгтэй хүсвэл), олон нийт, насанд хүрээгүй гэмт хэрэгтэнг оролцуулаад тухайн гэмт хэрэгт хариу арга хэмжээ авах хэсэг байх ёстой.
- Тухайн хохирогчийн хэтийн байдал нь гэмт хэргээс шалтгаалсан хохиролыг хэрхэн арилгахыг шийдвэрлэхэд голлох юм.
- Насанд хүрээгүй гэмт хэрэгтэнд хариуцлага тооцох гэдэг нь тухайн хийсэн хор хөнөөлийг арилгахын туд хариуцлагаа хүлээн авч, үзүүлж байгаа үйлдлийг хэлнэ.
- Тухайн олон нийт нь хохирогч болон гэмт хэрэгтэн хоёуланг нь оролцуулан бүх гишүүдийн сайн сайхан байдалд хариуцлага хүлээдэг.
- Бүх л хүн үнэ цэнэтэй , эрхэм зан чанартай байдаг.
- Сэргээгдэх гэдэг нь хор хөнөөлийн арилгаж, олон нийтийн харилцааг сэргээх болон шудрага ёсыг сэргээх гэсэн нэн тэргүүний зорилго юм.

- Үр дүнгүүд нь хэр их шийтгэл ноогдуулсан гэдгээс илүүтэйгээр хохирлыг хэр их хэмжээгээр барагдуулсан гэдгээр хэмжигдсэн байна.
- Гэмт хэрэгтэй тэмцэх нь олон нийтийн идэвх, оролцоогүйгээр амжилттай байж чадахгүй байх.
- Насанд хүрээгүй хүүхдийг шүүх үйл явц нь гэр бүлийн байдал, бэлгийн чиг хандлага, чадвар, олон янзын соёлыг хүндэтгэн үзэх бөгөөд арьс өнгө, үндэс угсаа, газарзүй, шашин шүтлэг, эдийн засаг болон бусад бүх зүйл хэрэг үүсэх явц, хамгаалагдах эрхүүд нь ижил тэнцүү өгчихсөн байдаг.

Эдгээр зарчимууд нь "эрх тэгш байдал"-д суурьлан зөвшөөрөгддөг. Энэ нь хариуцлага, хөгжих чадвар , олон нийтийн аюулгүй байдлын хангах гэсэн гурван үндсэн зорилгод хаяглагддаг.

Байгууллагууд хөгжиж чаддаг болон тэгш эрх, шударга ёсыг сэргээхтэй нийцсэн залуу хүмүүст зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нь дээрх гурван хүрээнд оршидог. Ийм төрлийн хөтөлбөрүүд нь байгууллагын урьдчилсан дүгнэлт эсвэл албан тушаалын дараах үйл ажиллагаанаас хамааран ялгагдах бловч бүх байгууллагууд тэгш эрх, сэргээгдэх шудрага ёс гүн ухаантай нийцсэн үр өгөөжтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж чаддаг.

Хариуцлагын зорилго нь зан байдлын тухайд түүнээс гарсан үр дагавартай холбоотой үйлдсэн гэм бурууг олон нийтэд болон бусдад засахын тулд хичээх, өөрсдийн зан байдлын хариуцлагаа хүлээн авахад оршидог. Нэг хүний зан бадлыг эзэмшилд өмчлөн авах болон хохирогчидод нэмэлт өөрчлөлтүүд хийх нь байгалийн залхаан цээрлүүлэлтийн эсрэг сэргээлт үзүүлж байгаа хэрэг. Хариуцлага нь тэгш эрх, сэргээгдэх шудрага ёсний хувьд шийтгэлийн арга барилууд ердийн биш олдсон залуучуудад суралцах боломжийг олгодог. Байгууллагын удирдагчид нь тухайн хариуцлагын зорилгод залуучуудад зориулсан хөтөлбөрүүд боловсруулж, хөгжүүлэх ёстой нь тэдгээрийн гэмт хэргээс шалтгаалсан зан байдал, хариуцлагаа хүлээж авч байгаа байдал дээр анхаарал хандуулдаг, онцгойлсон харилцаа холбоо нь гэм буруудсан тэдгээрийг өмчлөх. Байгууламжийн бүтэц, орчноос хамаарч хариуцлагад төвлөрсөн хөтөлбөрт гэр бүлийн бүлгийн хурал, нөхөн сэргээлт, нүүр тулсан уулзалт, зуучлал, аман болон бичгээр уучлал гуйх зэрэг багтсан байдаг. Хохирогчдын татан оролцуулсанаар хариуцлагын зорилгод оршин тогтонох хүчирхэг хэрэгсэл байж чадах хэдий ч сайтар төлөвлөж, хяналт тавих шаардлагатай байна. Хэрэв хохирогч нарт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бол тэдэнд ямар нэг хохирол нэмж учруулах, сэтгэл зүйн цочрол өгөхгүйн тулд болгоомжтой ажиллах хэрэгтэй. Хоригдож

байгаа, хараахан яллагдаагүй залуучуудыг чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тодорхой гэмт хэрэг дээр үндэслэн биш ерөнхий шинж чанартай хөтөлбөрүүд байж болно.

Өрсөлдөх чадварын хөгжүүлэх зорилго нь залуусыг нийгмийн харилцаанд илүү эерэг үр дүнтэй оролцуулахын тулд тэдэнд шинэ ур чадвар хөгжүүлэхэд чиглэнэ. Маш олон байгууллагад энэ чиглэлд хандсан үр дүнтэй хөтөлбөрүүд хэрэгждэг. Хөтөлбөрүүд нь нийгмийн ур чадвар, амьдрах ур чадвар, уур уцаараа хянах, бусдыг ойлгох, асуудлаа шийдвэрлэх, танин мэдэхүйн зан үйлийн сургалт, харилцааны ур чадвар, ажил мэргэжлийн ур чадвар зэрэгт түлхүү анхаарсан байна. Хариуцлагын зорилгоос ялгаатай нь залуус хоригдохоос өмнө болон хоригдсны дараа ч үр дүнтэй хэрэгжүүлсэн өрсөлдөх ур чадварын хөтөлбөрөөс үр шимийг нь хүртэж байдаг.

Олон нийтийн аюулгүй байдлын зорилго залуучуудыг нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн цаашид гэмт хэрэг үйлдэхээс сэргийлсэн зан үйлд сургах, ингэснээр хувь хүн олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оршино.

Залуусыг олон нийтээс тусгаарлаж шийтгэл эдлүүлэхээс илүү тэднийг нийгэмд бэлтгэн гаргахад чиглэсэн тэднийг нийгмийн хариуцлагатай иргэн болгоход чиглэнэ. Нийгэмд эргэн нэгтгэх хөтөлбөрийг залуусын хоригдож эхэлснээс авахуулан хувь хүн бүр дээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилго нь дээрх хөтөлбөрийн амжилттай хэрэгжүүлэхээс хамаарна.

Олон нийтийн үйлчилгээний хөтөлбөр

Залуус үйлдсэн хэрэгтээ харамсаж буй тохиолдолд шүүхийн зүгээс тэдний хорихын оронд оногдуулсан цагаар олон нийтэд үйлчлэх ажил хийлгэх шийдвэр гаргадаг. Энэ тохиолдолд ихэвчлэн олон нийтийн ажил нь төрийн болон төрийн бус байгууллагуудад үйлчлэх ажил байдаг. Ихэнх тохиолдолд албадан ажил хийж буй залуучууд хорих байгууллагын ажилтны хяналтан дор ажилдаг. Тэднээр олон нийтийн ажил хийлгэснээр, ажил хийж байх хугацаандаа хорих газар хоригдож байснаас илүү аюулгүй, амар тайван байх боломжтой юм. Тийм учраас, байгууллагын гадна буй залуучуудаас илүү байгууллагын дотор хэрэгжиж буй хөтөлбөрийг анхаарч үзэх хэрэгтэй. Залуучуудын аюулгүй байдал хангагдсан байлаа ч тэднийг хоригдож байх хугацаанд нь олон нийтийн ажил хийх боломжийг нь хангах хэрэгтэй.

Хорих байгууллагад хийж болох зарим олон нийтийн ажлын жишээ:

- Иргэний болон төрийн бус байгууллагад олон нийтэд чиглэсэн мэдээлэл хүргэх, шуудан явуулахад нь туслах. Мөн дугтуй эвхэх болон

наахад нь туслаж болно. Байгууллагын ашиг сонирхолын зөрчлийн үүднээс хоригдож буй хүүхдүүдийг ямар нэг улс төрийн компанит ажилд оролцуулах, хэн нэгэн улс төрчдөд ажиллуулахыг хориглоно. Байгууллагын удирдлага болон ажилчид нь тэдний хооронд янз бүрийн зөрчил гарахаас боломжтой бүх үедээ сэргийлж ажиллана.

- Зүрх судас, амьсгалын замын сэхээн амьдруулах болон анхны тусламж үзүүлэх чадвартай болох. Энэ нь шууд утгаар олон нийтийн ажил биш ч гэлээ энэхүү олж авсан мэдлэг нь дараа олон нийтэд тус болох боломжтой юм.
- Ахмадын төвүүд, асрамжийн газрууд болон хотын захиргаан дээр уран зураг, гар урлалын төслүүд. Хоригдож буй олон хүүхдүүд маш олон төрлийн авъяастай байдаг. Гэсэн хэдий ч тэдний ур чадвараа бусдад нээн харуулахад урам зориг хэрэгтэй байдаг. Ахмадын төв, асрамжийн газар, эмнэлгүүдэд ажилж, өөрийн ур чадвараараа бусдад тусалснаар тэд бусдын амьдралын чанарыг дээшлүүлж буй мэдрэмж авдаг. Ихэнх төрийн байгууллагууд захиргааны ордон, хурлын танхим, номын сан зэрэг газруудад уран зураг, чимэглэлүүдийн хоригдож буй залуучууд хийсэн байдаг. Уран бүтээлийн ажил нь ямарн нэг том төслийн нэг хэсэг, эсвэл тусдаа нэг жижиг төсөл ч байж болно. Энэхүү ажлууд нь олон нийтийн зүгээс хоригдож залуусыг илүү ойлгож, тэнд маш олон авъяас ур чадвартай хүүхэд, залуус өөрийн гэсэн хувь нэмрийг нийгэмд оруулах боломжтой ойлгож хүлээн авна.
- Гэр бүл хүүхдийн хэрэгцээнд чиглэсэн улирлын шинжтэй арга хэмжээнд оролцуулж болно. Энэ төрлийн арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж болно.

Хорих ангид байгаа залуучуудын аюулгүй байдлыг хангаснаар нийгэмд эерэг, үнэцэнэтэй хувь нэмэр оруулах боломжтой. Залуусын авъяас чадварыг нээн илрүүлж бусдад туслах боломж олгосноор тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлж, мөн нийгмийн зүгээс тэдний ойлгох боломж олгодог. Бүтээлч болон шинэлэг байдал нь чанартай олон нийтийн хөтөлбөрийг хорих байгууллагад хөгжүүлэхэд хамгийн чухал юм.

**Шашны үйлчилгээ**

АСА шашны үйлчилгээнд зориулсан тодорхой чиглэл өгсөн. Америкийн нэгдсэн улсын үндсэн хуулиар, хоригдож буй залууст шашны үйлчилгээ хүргэх ёстойг хуулиар баталгаажуулсан. АСА-аас шашны үйлчилгээний тодорхойлолт болон шашны үйлчилгээний мэдээллийн нээлттэй байдал, хорих байгууллагын ажилчдад тавигдах шаардлага зэргийг гаргасан байна.[22] Мөн тэднээс шашны хөтөлбөрүүдийн үйл явцыг баримтжуулсан бодлоготой байхыг шаарддаг. Гэсэн хэдий ч АСА-аас

шашны үйлчилгээний хөтөлбөрийг онцлон тэмдгэлсэн ч хөтөлбөр бүрийн үйл ажиллагааг нарийвчлан тусгаагүй байна.

Залуучуудад чиглэсэн шашны үйлчилгээний зорилго юу вэ?

- Залуусыг өөрсдийн оюун санааны хүчээ нээн илрүүлэхэд нь туслах зоригжуулах
- Өөрийн итгэл үнэмшлээ олох боломжуудыг олгох
- Тэдэнд залбирахыг заах мөн өөртөө залбирах боломжуудыг бий болгоход нь туслах
- Тэдний оюун санааны хэрэгцээг хангах нь тэдэнд үзүүлж буй цогц үйлчилгээний нэгэн хэсэг юм.
- Тэдний асуудалд орсон үед нь дэмжих зоригжуулах хэрэгтэй.

Ямар нэг шашны үйлчилгээнд хамрагдснаар залуучуудад ямар үр ашигтай вэ?

- Энэ нь тэдэнд тав тухтай мэдрэмж өгдөг
- Янз бүрийн шашин шүтлэгтэй сайн дурын ажилтнуудтай харилцах боломж олгодог. Амлалтандаа хүрэхгүй байх нь хоригдож буй хүүхдүүдэд хэвийн зүйл болсон байдаг. Ялангуяа сайн дураар бус зөвхөн төлбөр авч ажил хийдэг хүмүүсээс.
- Сайн дурын ажилтнууд ирэхийг хүсдэг болохоор ирдэг. Мөн сард нэг удаа ирэх байсан ч найдвартай ирдэг.
- Энэ нь залуучуудад оюун санааны хүмүүжил өгдөг.
- Энэ нь мөн тэдэнд ерөнхий сэтгэл санаагаа цэгцлэх,
- Энэ нь аливаа зүйлийг тунгаан бодох мессеж болон санаанууд өгдөг.
- Тэдэнд мөн аливаа зүйл дээр сонголт өгдөг. (оролцох болон эс оролцох)

Хэн тэдэнтэй шашны үзэл санаагаа хуваалцвал илүү үр нөлөөтэй вэ?

- Хүмүүст, ялангуяа залуус илт таалагддаг нэгэн
- Бусдыг шүүдэггүй нэгэн
- Залуучуудыг сэтгэлээсээ ханддаг, залуусаас ирж буй хариу үйлдэл хангалтгүй байсан ч тэдэн дээр ирсээр байдаг.
- Эхлээд сонсдог, дараа нь алхдаг болон өөрийгөө тунхагладаггүй нэгэн байх
- Өөрийнхөө хүлээн зөвшөөрдөг зүйлээр амьдардаг итгэл бишрэлтэй хүмүүс: залуус хүүхдүүд худалч хуурмаг нэгнийг амархан мэддэг
- Тэдний оюун санааны хэрэгцээг ойлгодог, тэднийг өөрчлөх гэж оролддоггүй, тамд унана гэх мэтчилэн заналхийлдэггүй
- Тэдэнтэй итгэл үнэмшлээ хуваалцаж тэдэнтэй харилцаа холбоо тогтоохыг чухалчилдаг. Энэ маш их тэвчээр болон цаг хугацаа шаарддаг.
- Бүрэн гүйцэд дуусгаагүй зүйлд тэвчээртэй ханддаг.

- Залуусын дунд найз байхаас илүү насанд хүрсэн нэгэн байгаадаа сэтгэл ханамжтай
- Ямар нэг өш хонзон, буруушаалт, эргэлзээгүйгээр үгүй гэж хэлж чаддаг. Мөн өөрийн хэмжээ хязгаарын мэдэж дүрэм журмын дагуу гэхээс илүү өөрийн үнэ цэнэд тулгуурлан ярьдаг
- Төлөвлөгөөт хувиарын дагуу тогтмол ирж өөрийн итгэл үнэмшлээ тууштай хуваалцдаг.
- Залуучуудын хүндэлдэг хэн нэгэн санваартан, сайн дурын ажилтан гэх мэт

Залуучуудтай шашны талаар үзэл бодлоо хуваалцах хамгийн үр дүнтэй аргууд

- Жижиг бүлгүүдээр дамжуулан хуваалцах, ховор тохиолдолд том бүлгүүдээр
- Өөрсдийн оролцоотой дасгалуудаар
- Өөрсдийнх нь мэддэг хэлээр ярих
- Оролцохгүй байх эрхийг нь олгох
- Хувийн залбирал хийх цаг өгөх
- Шашны боловсрол олгох загварын дагуу залуучуудын асуудалд чиглэн итгэл үнэмшлийг зааж сургах
- Дүрд тоглох замаар залуучуудад оюун санааны зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар сурахад туслах
- Дуугаар дамжуулан. Дуу хоолойгоо хуваалцах авъяас чадвартай эсвэл хүсэл эрмэлзэлтэй залуучуудад дуулах боломж олгох нь маш үр дүнтэй байдаг.

Залуусын оюун санааны хөгжлийн дэмжих үр дүнтэй аргууд юу вэ?

- Хэт түрэмгийлэлгүйгээр оюун санааны зарчмыг загварчлах

Зарим байгууллагад шашны үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийг санваартан гэж нэрлэдэг. Зарим томоохон газруудад бүтэн цагаар цалинжиж ажилдаг. Жишээ нь Христэд зориулсан залуучуудын байгууллагууд өөрсдийн үйлчлэлд орон нутгийн насанд хүрээгүй хүүхдүүдийг хамруулдаг. Жижиг байгууллагад шашны үйлчилгээг тухайн орон нутгийн лам санваартнууд сайн дурын үндсэн дээр хүргэдэг.

Лам санваартнууд болон хорих байгууллагын удирдлагуудын харилцаа ямар байх хэрэгтэй вэ?

- Бүх хүнд ойлгомжтой, хүндэтгэлтэй ханддахын тулд хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Лам санваартан нь байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй бөгөөд мөн байгууллагын нэг зохион байгуулалтын хэрэгсэл биш юм. Мөн тэдний үнэнч шудрага байдал нь залуусын итгэлийг хүлээх ганц боломж юм. Мөн тэднийг өөрсдийн талын хүн гэж харах ёстой байдаг.

Залуучууд болон тэдэнд үйлчилж байгаа ажилчдад лам санваартнууд ямар үүрэгтэй ажиллах вэ?

- Сэтгэлээ уудлан гаргах боломж олгох, дэмжлэг үзүүлэх
- Бие биетэйгээ хүнлэгээр харьцах харьцааг бэхжүүлэх.

Жонг Вон Чон, Эдвард Канда нарын хэлснээр бол "Өсвөр насныхан бол үзэл суртлын өлсгөлөн, амьлралын утга учир, зорилгодоо хүрэх, харилцаа холбоо, уялдаа холбоотой байх хүсэл эрмэлзэлтэй үе юм. Ялангуяа залуучуудын оюун санааг залуучуудын амьдрал, амьдралын хамгийн чухал зүйлтэй холбож, холбож, холбож өгдөг хайлтын систем гэж үздэг.

Хоригдож буй олон залуусын хувьд шашны болон оюун санааны үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдах нь тэдний оюун санааны эрэлт хэрэгцээг хангахад туслах болно.

**Амралт чөлөөт цагийн хөтөлбөрүүд**

Хөтөлбөрийн нэг чухал хэсэг нь залуучуудад эрч хүч энерги өгөх үйл ажиллагаа байх хэрэгтэй юм. (дасгал хөдөлгөө.) Хүч чадал, эвдүй, биеийн хэмжээ хамаарахгүй нөхөрсбөг спортын тэмцээнд тэднийг татан оролцуулах хэрэгтэй. Амралт чөлөөт цагийн хөтөлбөрүүд нь залуусын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлж ажилчид болон залуусын хооронд эерэг харилцаа холбоог бий болгоно.

Нөхөрсөг тэмцээн уралдааны арга хэмжээ

Хориход буй хүүхдүүдийн ихэнх нь эрсдэлд өртсөн, ямар нэр шалтгаанаар олон нийтийг хамарсан тэмцээн уралдаанд оролцож үзээгүй байдаг.

Ихэнх хорих байгууллагууд ихэнх дасгалын өрөөтэй байдаг ба хоригдогч нар ямар нэг байдлаар сагс тоглож байсан их бага хэмжээний туршлагатай байдаг. Сагсан бөмбөг нь амралт чөлөөт цагийн гол үйл ажиллагаа юм. Гэвч эмэгтэйчүүд оролцох нь бага. Сагсан бөмбөг нь ажилтнуудын зүгээс хамгийн бага оролцоо, төлөвлөлт шаардагддаг зугаа цэнгэлийн тохиромжтой стратеги болдог.

Амралт чөлөөт цагийн арга хэмжээнд тэдний өргөнөөр хамруулах зорилготой бол тэднийг урамшуулж зоригжуулах хэрэгтэй. Оролцооны хамгийн үр дүнтэй арга бол өрсөлдөөнт бус нөхөрсөг тэмцээнүүд юм. Үүнд олон залуучуудыг хамруулсан тэдэнд аюулгүй арга хэмжээ юм. Энэ арга хэмжээний үеэр ажилчдад залуусыг магтах, урамшуулах боломж олгодог. Арга хэмжээний үр дүнд залуус илүү өөртөө итгэлтэй болж, бусдад итгэх, тэдэнтэй хамтрах болох ажилчдын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, биеийн хөдөлгөөний хувьд илүү идэвхтэй болдог.

Аажмаар өрсөлдөөнт бус тоглоомууд нь залуучуудыг илүү өөрийгөө

сорих хүсэл эрмэлзлэлтэй болгож ингэснээр тэд фитнэсс, аэробик зэрэгт татагдан ордог.

Шинэ тоглоомын хөдөлгөөн 1960-аад оны сүүл үеэс эхэлсэн бөгөөд өрсөлдөөнт бус нөхөрсөг тоглоом ашиглахыг дэмждэг. Энэ төрлийн тоглоомууд нь хорих байгууллагуудад амжилттай хэрэгжсээр ирсэн. Энэхүү төрлийн тоглоомууд нь бүх оролцогчид биеийн хүч, ур чадвараар ялгагдахгүй ижил тэгш оролцох боломжтой юм.

Биеийн дасгал хөдөлгөөн

Төлөвлөсөн хөтөлбөр, тогтмол дасгал хөдөлгөөн хийхгүйгээр эрүүл чийрэг байх бараг л боломжгүй юм. Тийм учраас, насанд хүрээгүйчүүдийн хорих газарт тусгай төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дасгал хөдөлгөөн хийх үйл ажиллагааг зохион байгуулж, тэднийг эрүүл чийрэг бие бялдраа хадгалах боломж олгох. Өдөр бүр тохирсон дасгал хөдөлгөөн хийснээр эрүүл чийрэг байж, урт наслах, амьдралын чанарыг дээшлүүлнэ. Мөн дасгал хөдөлгөөн нь сэтгэл түгшилт, стрессийн түвшинг бууруулдаг болох нь батлагдсан.

Байгууллагын ажилтнууд тухайн байгууллагын эрхэм зорилгод нийцүүлэн амралтын хөтөлбөрийг боловсруулж гаргана. Хөтөлбөрт уламжлалт дасгал хөдөлгөөнийг (гимнастик, гүйлт болон хүчний бэлтгэл) төрөл бүрийн спорт тоглоомуудтай хослуулан зохион байгуулна.

Фитнесс хөтөлбөрүүдийг шат дараалан хэрэгжүүлнэ. Залуучууд өндөр идэвхтэй, эрч хүчтэй дасгал хөдөлгөөний хэв маягтай байх боломжоор хангагдах хэрэгтэй. Боломжтой бүх замаар ажилчид тэднийг дасгах хөдөлгөөн хийхэд нь урам зориг өгөх, оролцоог нь хангах, дасгал хөдөлгөөнөөс авч буй эрүүл мэдрэмж, хүчээл зүтгэл, хүрсэн үр дүнг нь урамшуулах хэрэгтэй.

Дасгал хөдөлгөөний хөтөлбөр нь дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд: сунгалтын дасгал, гимнастик, аэробик, гүйлт, эсвэл шогших мөн хүчний дасгалууд гэх мэт

Эрч хүч энерги өгөх дасгалууд нь сайн хөтөлбөрийн нэгэн чухал хэсэг юм. Энэ төрлийн эмчилгээний дасгал хөдөлгөөний хэв маяг нь цэргийн хэв маягийн дасгал сургуулилттай харьцуулахад хэт их ачаалалтай, энерги шаардсан дасгалууд биш юм. Мөн энэхүү дасгал хөдөлгөөний хөтөлбөрүүд нь хуучны хэв маягаар ажилчид залуучуудыг дарамтлах, тэдэн рүү орилж хашгирах гэх мэтээр тэднийг сул дорой дуулгавартай болгоход чиглээгүй болно. Мөн хорих газарт тэдний заавал дагаж мөрдөх үүрэгт хамаарахгүй бөгөөд гэр орноосоо хол нийгмээс тусгаарлагдсан хүнд хэцүү үед нь нэмж дарамт учруулах зорилгогүй болно.

Бие бялдрын чийрэгжүүлэх хөтөлбөр нь хүн бүрт зориулсан тэсвэр

хатуужлын хөтөлбөртэй байх ёстой. Ажилчдын зүгээс аль хөгжөөнтэй байдлаар үйл ажиллагааг зохион байгуулж, залуусыг харагдах байдлаар нь ямар нэг сөрөг зүйлийг хэзээ ч ярьж болохгүй.

Жингийн илүүдэлтэй залууст чиглэсэн өөх шатаах, өндөр ачаалалтай дасгал өгнө. Мөн алхах болон шогших хөтөлбөрүүдийг санал болгоно. Мөн түүнчлэн, тэдэнд чанар муу, түргэн хоолноос илүү эрүүл амьдралын хэв маягтай байхын давуу талыг ойлгуулна.

Дасгал хөдөлгөөний ач холбогдлыг ойлгуулахдаа залуусыг дасгал хөдөлгөөний хөтөлбөрт оролц гэж хэзээ ч шахаж шаардаж болохгүй гэвч тэднийг хөтөлбөрт хамруулахын тулд сэдэлжүүлж, хөхүүлэн дэмжиж болно. Хичээл зүтгэл нь хамгийн чухал юм. Залуучуудыг ялангуяа өөртөө итгэлгүй залуусыг магтах, урамшуулах хэрэгцээ үргэлж байдаг. Ихэнх залуус дасгал хөдөлгөөнд эерэг хариу үзүүлдэг бөгөөд тэдний зан үйл хөтөлбөрийн бусад хэсэгт сайжирч байдаг.

Өдөр тутмын хөтөлбөрийн тасралтгүй оролцоо нь эерэг зан үйлийг дэмждэг. Зохион байгуулалттай багийн , спорт, тоглоомууд нь тэдэнд олон төрлийн туршлага өгдөг. Спорт, спорт бас дахин спорт гэсэн зарчим нь залуучуудад чиглэсэн амралт чөлөөт цагийн цогц хөтөлбөрийн үндэс юм. Аль болох олон төрлийн спортын төрлийн арга хэмжээг тэдэнд санал болгосноор залуус бүр өөрт тохирсон, сонирхолд нь нийцсэн төрлийг олж хөгжүүлнэ.

Сдорт үйл ажиллагааны өмнө ажилчид тэдэнд тухайн спортын төрлийн үндсэн ойлголт дүрэм журмыг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй. Спортын төрлүүд нь сагс, хөл бөмбөг, шалны хоккей, софтбол, гар бөмбөг, хүндийн өргөлт, гүйлт, аэробек, гольф гэх мэт байна. Хамгаалах хэрэгсэл, тохирсон тоног төхөөрөмж, тусгай хөөсөн бөмбөг гэх мэт зориулалтын хэрэгслүүд нь залуучуудад аюул багатай бөгөөд тэдний спортын боловсролд ч ашиг тустай, мөн дотор танхим, амралтын өрөө зэрэгт тоглоход тохиромжтой юм.

**Чөлөөт цаг**

Хорих ангид байгаа залууст ерөнхийдөө өндөр зохион байгуулалт шаарддаг өндөр эрсдэлтэй бүлэг юм. Гэсэн хэдий ч чөлөөт цагийн хөтөлбөр нь бүх хорих газруудад байх ёстой чухал нэг хэсэг юм. Хэзээ, хэрхэн чөлөөт цагийг төлөвлөх нь чухал байдаг. Олон газруудад үйл ажиллагаа нь шахуу хөтөлбөрийн дагуу явагдаж, залууст чөлөөт цаг бага гардаг. Бусад тохиолдолд ажилчид тоо цөөн болон нөөц бололцоо дутмаг эсвэл хөтөлбөрүүдийн урамшуулал нэрийдлээр тэдэнд олон цагаар зурагт үзэх, хөзөр тоглох боломж олгодог. Сүүлийн үеийн энэ хандлага нь үр дүнтэй чөлөөт цагийн үйл ажиллагаа биш юм.

Ажилчид өөрсдийн хариуцлагаа ухамсарлан хөтөлбөрийн үйл ажиллагаанд зохих хянал тавьж байх хэрэгтэй. Өндөр чанартай хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд зохих ёсны орон зай, тоног төхөөрөмж хэрэгтэй.

Чөлөөт цагийн үйл ажиллагаа нь нарийн анхааралтай бодож төлөвлөсөн, өдрийн хувиартай уялдуулан нарийвчлан цаг гаргана. Мөн чөлөөт цагийн үйл ажиллагааг ажлын өдрүүдэд өдөр эсвэл оройн цагаар амралтын өдрүүдэд өдрийн аль ч цагт зохион байгуулж болно. Чөлөөт цагийн үйл ажиллагаанд зурагт бичлэг үзэх, хөгжим сонсох, видео тоглоом тоглох, ном сэтгүүл унших, захиа бичих, хичээл давтах, хөлөгт тоглоом тоглох, эсвэл карт тоглоом тоглох зэрэг багтна. Карт тоглоомыг ямар нэг байдлаар мөрийтэй тоглохгүй байх тал дээр ажилчид хяналт тавина.

Зарим байгууламжууд чөлөөт цагийн үйл ажиллагаа нэмэлтээр зохион байгуулах тусдаа өрөөтэй байдаг. Тоглоомын өрөө нь бусад төрлийн амралт чөлөөт цагийн хөтөлбөрт багтсан спортын төрлүүдээс өөр байх хэрэгтэй. Олон газруудад мөн залуучууд ном унших, компютер дээр хөгжим сонсох, тоглоом тоглох медиа номын сантай байдаг.

Чөлөөт цагаар ажилчдын харилцаа холбоо мөн тогтмол үргэлжилж байх ёстой. Энэ нь биеийн тамирын заал, тоглоомын өрөө зэрэгт энгийн яриа өрнүүлэх маягаар өрнөж болно. Ажилчид залуучуудын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөхөд оролцсноор харилцан хүндэтгэл, ажлын эерэг харилцааг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

Амжилттай, тогтвортой хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах нь

Байгууллагын төрөл хэмжээ, төсөв зэргээс үл хамааран байгууллагын удирдлагууд байгууллагаас хэрэгжүүлж буй залуучуудад чиглэсэн хөтөлбөрийг дэмжин ажиллах ба хэрэгжилтийн чанар анхаарах хэрэгтэй. Мөн тэнд ажиллаж байгаа ажилчид нь маш сайн бэлтгэгдсэн ба хэрэгцээтэй нөөц бололцоогоор (байр, тоног төхөөрөмж, хангамж) хангагдсан байна. Орон нутгийн сүмүүд, үйлчилгээний клубууд болох Кванис, Ротари ба Арслан Клубууд-сайн дурын бүлгүүд, орон нутгийн филантропийн байгууллагууд залуучуудад хөтөлбөрийг хаанаас ч хүргэхэд санхүүгийн болон бусад хэлбэрээр тусламж үзүүлэхэд бэлэн байдаг. Байгууллагын удирдлагаас гаргасан идэвхтэй дэмжлэг, тууштай байдал нь ажилтнууд болон залуучуудад эдгээр хөтөлбөрүүд нэн тэргүүний зорилт болж байгааг харуулж, ирээдүйд дэмжигдэх болно гэдгийг ойлгуулна.

Байгууллагын тэргүүлэх чиглэл, алсын хараа, зорилго зорилт, удирдамж зарчимтай уялдуулан хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулна. Мөн түүнчлэн хөтөлбөрүүдийн талаар байгууллагын бодлого, үйл ажиллагааны баримт бичгүүдэд дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө. Хөтөлбөрийн гарын авлага, сургалтын төлөвлөгөө болон бусад

материалуудыг тогтмол хянаж шинэчлэлт хийж байх хэрэгтэй: Мөн баримт бичгүүд нь хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ажилчдад нээлттэй ашиглах боломжтой байх хэрэгтэй. Удирдлагын зүгээс ажилчдын ажлыг үнэлж хариуцлагажуулна.

Чанартай хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь эерэг өөрчлөлтүүдийг бие болгохоос гадна ажилчид болох хүүхдүүдэд илүү эерэг, бүтээлч орчинг бий болгоно.

Эргэн нэгтгэх

Хоригдож буй залуусын дийлэнх нь суллагдаж гэртээ эргэн очдог. Гэр бүлд нь амжилттай эргэн нэгтгэх үйл явц нь тэдэнд хэрэгцээтэй байгаа үйчилгээ, дэмжлэг, хяналтын дүнд амжилттай хэрэгжинэ.

Насанд хүрээгүйчүүд болон гэр бүлийн шүүх сэтгүүл хэвлэгдсэн "Насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих байранд үзүүлэх үр нөлөө" өгүүлэлд Дэвид Роус, Жеймс Моусер, Тимоти Уолш нар "JOR [Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийг эргэн нэгтгэх] хэлэхдээ: иргэд, засгийн газрын агентлагууд, нийгмийн үйлчилгээний байгууллагууд, итгэл үнэмшилд суурилсан байгууллагууд гэх мэт олон нийтийн байгууллагуудыг хорих байгууллагуудаас суллагдаж буй залуусыг нийгэмд амжилттай эргэн нэгтгэхэд хөтөлбөр үйлчилгээний тэргүүлэх чиглэлээ хандуулах хэрэгтэй гэсэн байна. Мөн тэд хэлэхдээ "залуусыг хорих байгууллагуудад олон нийтэд суурилсан хөтөлбөрүүдэд системтэйгээр хамруулснаар нийгэмд амжилттай эргэн нэгтгэх боломжийг нэмэгдүүлнэ" гэжээ. Хүмүүсийн зүгээс энэхүү олон нийтэд суурилсан хөтөлбөрүүдийн талаар мэддэг, итгэдэг мөн насанд хүрээгүйчүүдийг тус хөтөлбөрт хамруулснаар, эргэн нэгтгэх хөтөлбөр олон нийтийн хамтын ажиллагааг хангах болно.

Нийгэмд эргэн нэгтгэх хөтөлбөр нь хорих байгууллагад хэрэгжүүлж буй үндсэн хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд залуучуудыг ямар ч төрлийн цагдан хорих байранд байрлуулах цэгээс эхлэн хэрэгжинэ. Үүний хамгийн чухал хэсэг нь "төлөвлөлт" залуучуудыг хорих байгууллагаас сулласнаар тэдний нийгэмд ажилттай эргэн нэгтгэж байна гэж ойлгож болохгүй юм. Эргэн нэгтгэх үйл явцын төлөвлөгөөний эцсийн зорилго нь тэднийг гэр бүл, сургууль болон ажлын байранд амжилттай эргэн нэтгэх явдал юм. Амжилттай эргэн нэгтгэсний үр дүн нь нийгмийн аюулгүй байдлыг нэмэгдүүлж эерэг үр дүн гаргаж буй залуус юм. (амжилттай суралцах, ажиллах болон иргэний нийгмийн оролцоо, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл буурах

Шей Билчикийн хэлснээр залуучуудыг эргэн нэгтгэх бодлого үйл явцад таван үндсэн чиглэл байна.

1.Насанд хүрээгүйчүүдийн тархины хөгжлийг судлах шинжлэх

ухааныг эргэн нэгтгэх хөтөлбөртэй уялдуулан холбох;

2.Эргэн нэгтгэх үйл явц тэдний давуу тал болон нийгмийн эерэг хөгжил дээр тулгуурлан эхлүүлэхэд анхаарах;

3.Эргэн нэгтгэх үйл явцад гэр бүл болон олон нийттэй уялдаа холбоотой ажиллах;

4.Боловсрол болон ажил эрхлэлтийн байдлыг эргэн нэгтгэх үйл явцын нэн тэргүүнд тавих;

5.Насан хүрсэн хүний амьдралаар амьдрахад нь тогтвортой дэмжлэг үзүүлэх.

Дээр дурдсан хүчин зүйлс нь эргэн нэгтгэх үйл ажиллагааг төлөвлөж буй хувь хүн, байгууллага заавал анхаарч үзэх чухал хүчин зүйлс юм.

1987 оноос OJJDP насанд хүрээгүйчүүдийн шүүх тогтолцоонд хэрэгжиж буй суллагдсны дараах хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг санхүүжүүлж, үнэлгээ судалгаа явуулсаар ирсэн. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд суллагдсны дараах хөтөлбөрүүдийн загвар эрчимтэй хөгжиж эхэлсэн.

Энэхүү хөтөлбөрийн загвар нь эргэн нэгтгэх хөтөлбөрийг хөгжүүлэхэд дараах 5 зарчмыг баримтладаг.

1.Залуучуудыг олон нийтийн дунд эрх чөлөөтэй болох үед хариуцлагыг аажмаар нэмэгдүүлэх, нийгэмд бэлтгэн гаргах;

2.Насанд хүрээгүйчүүд болон олон нийтийн харилцаа холбоо, оролцоог хангах

3.Насан хүрээгүйчүүдийг нийгэмд дахин нэгдэхэд туслах зорилгоор тэдэнтэй болон тэдний зорилтот дэмжлэгт бүлэгтэй ажиллах (гэр бүл, үе тэнгийхэн, сургууль, ажил олгогч);

4.Хэрэгцээтэй бол шинээр дэмжлэг нөөц бололцоог бий болгох;

5.Насан хүрээгүйчүүдийн нөөц, боломж бололцоо, олон нийтийг өгч чадах үйлчилгээ дэмжлэгийг хянаж үнэлэх.

Энэхүү зарчмууд нь шүүх тогтолцоонд залуучуудад чиглэсэн үйлчилгээг хөгжүүлж тэднийг нийгэмд эргэн нэгтгэх болон суллагдсаны дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй олон нийтийн үйлчилгээний ажилтан боловсон хүчингүүдэд зааварчилгаа болох боломжтой.

Үүн дээр нэмээд эргэн нэгтгэх төлөвлөгөө гаргахад зориулсан маш олон эх сурвалжууд байдаг.

• Насанд хүрээгүйчүүдийн шударга ёс, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын алба (OJJDP-ийн) Програмын гарын авлагад (MPG) нотолгоонд тулгуурласан шүүх тогтолцоо, залуучуудыг гэмт хэргээс сэргийлэх, үйлчилгээ үзүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх хөтөлбөрийн талаар мэдээллийг багтаасан. Энэ нь мэргэжилтнүүд болон олон нийтэд чиглэсэн мэдээллийн

эх сурвалж бөгөөд яаж ажиллах, амлалт гэж юу болох, юуг шүүх тогтолцоонд хэрэгжүүлж болохгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, аюулгүй байдал зэрэг мэдээлэл багтаасан байна.

- "Үндэсний эргэн нэгтгэх нөөцийн төв"-өөс улс, орон нутгийн засаг захиргаа, үйлчилгээ үзүүлэгч, ашгийн бус байгууллага, гэмт хэрэгтнүүдийг эргэн нэгтгэх чиглэлээр ажилладаг байгууллагуудад сургалт, боловсрол, арга зүйн дэмжлэг үзүүлдэг.

Дүгнэлт

Насанд хүрээгүйчүүдийн хорих байгууллага нь зарим улс орны хувьд хамгийн асуудал бэрхшээл ихтэй газар юм. Тэд хорих байгууллагад байх хугацаандаа цаг хугацааг юу хийж өнгөрүүлж байгаа нь нэн чухал асуудал юм. Тэдний олонх нь өөрийгөө амьдралдаа хазгай гишгэж хөл алдсан, итгэл найдвараа алдсан гэж итгэдэг. Тэдний хүсэл тэмүүлэл нь хоригдож, гэр бүл олон нийттэй харицлах харилцаа холбоо нь цоожтой хаалганы цаана ормогц өөрчлөгдөж эсвэл холбоо тасардаг.

Хөтөлбөр нь байгууллагын хэмжээ, зорилго, санхүүгийн нөөц боломж болон бусад нөөц бололцоо, ажилчлдын тоо болон бусад ямар нэг хүчин зүйлээс хамаарч байгууллагуудад өөр өөр бүтэцтэй хэрэгжиж болно. Ямар бүтэц, загвартай хэрэгжихээс үл хамааран ажилчид нь залуучуудын зан үйлд чиглэсэн хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал юм. Хөтөлбөрүүд нь ажилтнууд болон хүүхдүүдийн хооронд харилцаа холбоо тогтоох боломж олгосон, залууст шинэ ур чадвар сурахад нь туслах, өөрсдийгөө илүү эерэгээр мэдрэх боломж олгох бүтээлч үйл ажиллагаагаар хангана. Хөтөлбөрт бүх залуучууд хамрагдах боломжтой байх ёстой бөгөөд залуучуудын хувь хүний өсөлт, хөгжилтөд хамгийн их чиглэсэн байна. Хорих байгууллагын ажилчид өөрийн үүргээ ухамсарлан нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэж ажиллана.

# ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ

## 4.1.Дүгнэлт

Монгол Улсад өсвөр насны этгээдээс гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан олон боловч хамгийн гол нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын хараа хяналт, анхаарал халамж муу байх, хүүхдийн нас, биеийн онцлогт тохируулан харьцахгүй байх, тэднийг үл хайхрах, тэднийг ойлгохыг хүсэхгүй байх, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээр хангаж чадахгүй, эсхүл хэт эрхлүүлэх, хүссэн бүгдийг нь биелүүлдэг зэрэг алдаатай үйлдлээс болж байна. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлалт, тэтгэлэг гаргуулах хэрэг маргааны тоо буурахгүй байгаа бөгөөд үүний улмаас олон хүүхдүүдийн амьдралын баталгаа эрсдэлд орж байна.

Өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан хэд хэдэн хүчин зүйлээс үүдэлтэй гэж дүгнэлээ. Үүнд: Гэр бүл салалт,  гэр бүлийн байдал хойд эцэг, эхтэй болон хагас өнчин, ар гэрийн хараа хяналтгүй байдал, бусдын сөрөг нөлөө, сониуч, гэнэн томоогүй зан, архины хамаарал, сургууль завсардалт, амар хялбар аргаар мөнгө олох, PC тоглоомонд донтох, ядуурал, ажилгүйдэл зэрэг шалтгаан нөхцлүүдээс болж хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүхээс өсвөр насны этгээдэд албадлагын арга хэмжээ түлхүү хэрэглэж байгаа боловч хорих ял оногдуулах явдал төдийлөн буурахгүй байна.

Монгол Улс хэдийгээр насанд хүрээгүй буюу өсвөр насны этгээдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын болон практик туршлага бий боловч 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага гэсэн шинэ нэр томьёонд хэрхэн ял эдлүүлэх талаар нэгдсэн ойлголт үгүй байна.

Учир нь хуучин насанд хүрээгүйчүүдийн хорих анги, өнөөгийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь нэр томьёоны болон үйл ажиллагааны онцлогтой болох нь дамжиггүй юм.

Олон Улсын жишгээс харахад Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь ял эдлүүлэх чиг үүргээсээ илүү сургалтын болон нийгэмшүүлэх үйл явцыг хэрэгжүүлдэг сургалтын орчин нөхцөлтэй байгуулллага байна.

Гэвч манай улсад Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын орчин нөхцөл нь хорих ангийн орчин нөхцөлтэй ижил, зарим талаараа тааруу байгаа нь учир дутагдалтай байна.Түүнчлэн албан хаагчдын 15 нь буюу 50 хувь нь эрх зүйч, 2 нь буюу 6 хувь нь багш мэргэжилтэй байна. Тэр

дундаа хүүхэдтэй хамгийн ойр 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг харуул хамгаалалтын алба хаагчдыг чадваржуулан сургах ба хүүхэдтэй ажиллах заах арга зүйн зохих мэргэжил боловсрол эзэмшсэн багш мэргэжилтэй хүмүүсийг түлхүү авч алба хаагчдыг мэргэшүүлж ажиллуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хамгийн гол асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны этгээдийг хорих, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөл, журам, сургалтын үйл ажиллагааны талаарх зохицуулалт нь хэт ерөнхий, насанд хүрэгчидтэй адил зохицуулалттай байгаа нь анхаарал татаж байна.

Иймээс Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын сургалтын болон нийгэмшүүлэх, нөхцөл, журамтай холбоотой журмыг батлан үйл ажиллагаандаа дагаж мөрдөх нь зүйтэй гэж үзлээ.

### 4.2.Зөвлөмж

Судалгааны ажлын хүрээнд дараах зөвлөмжийг Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүргүүлж байна.

1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь сургалтын байгууллага байхаар зохицуулсан дотоод журмыг боловсруулан Боловсролын асуудал эрхэлсэн болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлуулах

2.Байгуулллагын нийт алба хаагчдыг хүүхэдтэй ажиллах арга барил эзэмшсэн багш мэргэжилтэй хүмүүсийг түлхүү авч алба хаагчдыг мэргэшүүлж ажиллуулах,

3.Тус байгууллагын хоригдлын хоолны газар, хоригдлын байр, Баянзүрх дүүргийн 110 дугаар сургууль, номын сан байрлаж байгаа барилга нь 1978 онд анх цэргийн казармын зориулалтаар баригдаж ашиглалтад орсон. Мөн захиргааны байр, хоригдлын халуун ус, гадна, дотно шалган нэвтрүүлэх байрны барилгууд нь 2002 онд ашиглалтад орсон. Мэргэжлийн хяналтын 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 07-208/638 дугаар улсын байцаагчийн дүгнэлтээр барилга байгууламжууд нь ашиглалтын шаардлага хангахгүй, хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна гэсэн дүгнэлт гарсан байх тул эрүүл ахуй, аюулгүй байдлыг шаардлага хангасан сургалтын байр, дотуур байрыг шинээр барих

4.Хүүхэд хамгаалалын тухай хуульд заасан төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулан, хорих ял эдлээд суллагдсан хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Нийгэм, хамгааллын хөдөлмөрийн яам, түүний салбар нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах зэрэг болно.

# ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль

Үндсэн хууль

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2015-12-03

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-06-09

Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ 2017-05-11

Боловсролын тухай хууль 2002-05-03

Бага, дунд боловсролын тухай 2002-05-03

Хорих ангийн дотоод журам 2017-07-04

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага


Г.Совд "Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар" УБ.2002

Á.Áàòáàÿð, Ð.Øàæèíáàò íàð, Ìîíãîëûí õóóëü òîãòîîìæèéí òүүõýí ýìõòãýë Íýãäүãýýð áîòü, Çàðëèãààð òîãòîîñîí ãàäààä ìîíãîëûí òөðèéã çàñàõ ÿâäëûí ÿàìíû õóóëü çүéëèéí áè÷èã/1206-1910/ ÓÁ. 2010

Á.Áàÿðñàéõàí, Ñ.Æàíöàí íàð, Ìîíãîë óëñûí ýðүүãèéí õóóëü òîãòîîìæèéí òүүõýí óëàìæëàë /1911-2009/ ÓÁ. 2011

Д.Адъяабазар. "1921 оноос хойшхи Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт", УБ хот

Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх.УБ.1996 он

Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл.УБ.,1992 он

Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял. УБ.,2015 он

А.Лхагва. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.УБ.,2015 он

А.Лхагва.Монгол Улсын ШШГЭЗүй.УБ.2014 он

М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын Эрх зүй.УБ.,1999 он

Б.Ганчулуун. Английн Эрүүгийн эрх зүй. УБ.,2005 он

Д.Бадам, Б.Цэрэнчимэд "Монгол Улсын Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй" /схемчилсэн тайлбар/ УБ.,2003 он

О. Пүрэвсүрэн.Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа".УБ. 2014 он


Гурав.Бусад материал

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын 2015-2020 оны үйл ажиллагааны тайлан

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүн таслах ажиллагааны тайлан

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгаа, шинжилгээний төвийн мэдээ, тайлан

Кристина-Нобелийн сангийн материал

**Хавсралт**

# СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ЖУРАМ /төсөл/

## Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өдөр тутмын үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг хангах чиглэлээрх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Журмын зорилго нь шүүхээс өсвөр насны этгээдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах сургалт, нийгэмшүүлэх болон сургалтын болон дотуур байрны дотоод дэг, цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдүүлэхэд оршино.

1.3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдлүүлэх ажиллагаа нь өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлан хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

1.4.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах ерөнхий боловсролын сургалт нь Боловсролын тухай болон Бага, дунд боловсролын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрхийн актад нийцсэн байна.

## Хоёр.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын чиг үүрэг

2.1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь дараах чиг үүрэгтэй.

2.1.1.Шүүхээс өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх;

2.1.2.Өсвөр насны хүнд албан болон албан бус сургалтыг зохион байгуулах;

2.1.3.Өсвөр насны хүний хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

2.1.4.Өсвөр насны хүнд шаардагдах эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх;

2.1.5.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж буй өсвөр насны этгээдүүдийн дунд байрны дэг журам, цагийн хуваарь сахиулах;

2.1.6.Байрны дотоод дэг журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах;

2.1.7.Сургалтын үйл ажиллагаандаа идэвхтэй, үр дүнтэй

хамрагдсан этгээдийг урамшуулах;

2.1.8.Өсвөр насны этгээдийн хүсэл сонирхлыг нь харгалзан нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулах;

2.1.9.Хуульд заасан бусад.

2.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ерөнхий боловсролын сургууль, сургалт, нийгэмшүүлэх, ахуй нөхцлийг хангах болон дүн шинжилгээ, аюулгүй байдлын алба ажиллана.

2.3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхдээ боловсролын болон бусад байгууллага, иргэдийн туслалцааг авч болно.

**Гурав.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад өсвөр насны этгээдийг хүлээн авах**

3.1. Өсвөр насны этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хорих ангийн дотоод журамд заасны дагуу нийгэмшүүлэх болон аюулгүй байдал, сургалтын ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр хүлээн авна.

3.2.Хүлээн авах бүрэлдэхүүн өсвөр насны этгээдийг сургалтын болон нийгэмшүүлэх аль хөтөлбөрт хамруулах асуудлыг шийдвэрлэн, өрөөнд хувиарлана.

3.3.Нийгмийн ажилтан шинээр ирсэн өсвөр насны этгээдэд сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журам, цагийн хуваарь, нийгэмшүүлэх хөтөлбөр, түүний үр дагавар, эрх, үүргийн талаар мэдээлэл өгнө.

**Дөрөв.Өсвөр насны этгээдийн эрх зүйн байдал**

4.1.Өсвөр насны этгээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210, 211 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээхээс гадна дараах нэмэлт эрх зүйн баталгаагаар хангагдана.

4.1.1.Сургалт, нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий өөрсдийн хүсэл санаачилгаар дугуйлан, секц, клуб байгуулах, гишүүнээр элсэх, уралдаан, тэмцээн зохион байгуулах, оролцох;

4.1.2.Байгууллагын захиргаанд ерөнхий боловсролын сургалтад шаардлагатай ном, сурах бичиг, сургалтын орчныг шаардах;

4.1.3.Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлдэх, өгөх зорилгоор чөлөө авах.

**Тав.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын сургалтын болон дотуур байр**

5.1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь боловсролын үйлчилгээг стандартын шаардлага, эрүүл, аюулгүй байдал хангасан орчин нөхцөлд зохион байгуулах бөгөөд үйл ажиллагаандаа өсвөр насны этгээдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад холбогдох дүрэм,

журмыг мөрдөнө.

5.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь хичээлийн танхимаас гадна осол аюулгүйн болон эрүүл ахуйн дүрмийн дагуу тоноглосон хичээлийн төрөлжсөн кабинет, лаборатори, номын сан, уншлагын танхим, хөгжлийн төв, биеийн тамирын зал, талбай, ногоон байгууламж, эмчийн өрөө, цайны газар /хоол, хүнсний үйлчилгээ/, захиргаа, аж ахуйн өрөө, тасалгаатай байна.

5.3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь холбогдох мэргэжлийн байгууллага баталгаажуулсан эдэлбэр газрыг биеийн тамир, хичээл туршлагын болон тоглоомын талбай байгуулах зэрэгт ашиглана.

5.4.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт нийцсэн дэд бүтэц, суралцах орчныг бүрдүүлж ажиллана.

5.5.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь мэдээллийн нууцлал, аюулгүй ажиллагааг хanган ажилласан интернетийн орчинд суралцах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн, цахим хуудастай байна.

5.6. Өсвөр насны этгээдийн байрлах дотуур байр нь эрүүл ахуйн болон аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

## Зургаа.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага дахь сургалт, нийгэмшүүлэх ажил

6.1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын сургалтын ажил нь хичээл болон хичээлээс гадуурх сургалт, өсвөр насны этгээдийн хөгжил, төлөвшлийг хангах тэдгээртэй холбоотой бусад ажлаас бүрдэнэ.

6.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллана.

6.3.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

6.3.1.сөрөг зан үйл засах хөтөлбөр;

6.3.2.мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох хөтөлбөр;

6.3.3.урлаг, спортын авьяасыг дэмжин хөгжүүлэх хөтөлбөр;

6.3.4.бэлгийн боловсрол олгох хөтөлбөр;

6.3.5.харилцааны ур чадвар олгох хөтөлбөр;

6.3.6.бусад

## Долоо.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотуур байрны нөхцөл

7.1.Сургалт-хүмүүжлийн дотуур байр нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан тасалгаанаас бүрдэнэ.

7.2.Дотуур байрны нэг тасалгаанд өсвөр насны этгээдүүдийг 4-өөс

илүү байлгахгүйгээр зохион байгуулна.

7.3.Тасалгаанд дараах эд хогшил байлгахыг зөвшөөрнө.

7.3.1.Хүн нэг бүрийн унтах ор, цагаан хэрэглэл бүхий гудас, хөнжил, дэр;

7.3.2.Хичээлийн хэрэглэлээ хийх шүүгээ;

7.3.3.Хичээлээ давтах зориулалт бүхий ширээ, сандал;

7.3.4.Ахуйн хэрэглээний /оо, саван, сойз/ шүүгээ.

7.4.Өсвөр насны этгээдийн хоол, бусад ахуй нөхцлийг хорих ангийн дотоод журамд заасны адилтган үзнэ.

## Найм. Өсвөр насны этгээдийг урамшуулах

8.1.Сургалтын болон нийгэмшүүлэх ажилд идэвх зүтгэлтэй оролцсон өсвөр насны этгээдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын тушаалаар дараах хэлбэрээр урамшуулна.

8.1.1.сард 10 хүртэл хоногийн шагналын хоног олгох;

8.1.2.тэргүүний сурагч өргөмжлөлөөр шагнах;

8.1.3.тэргүүний авьяастан өргөмжлөл.

8.2.Өсвөр насны этгээдийг урамшуулах асуудлыг хариуцсан багш, нийгмийн ажилтны тодорхойлолт, саналыг харгалзан шийдвэрлэнэ.

## Ес.Сахилгын шийтгэл

9.1.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын тушаалаар сургалтын болон дотуур байрны дэг журам зөрчсөн, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд өсвөр насны этгээдэд дараах сахилгын шийтгэл ногдуулна

9.1.1.урьд олгосон шагналын хоногийн хураах;

9.1.2.тухайн сарын уулзалт, утсаар ярих эрхийг хасах;

9.1.3.сурагчийн хувийн хэрэг, тодорхойлолтод сануулга бичих.

## Арав.Сургалт-хүмүүжлийн тусгай нэгж

10.1.Өсвөр насны эмэгтэй этгээдийг тусгай нэгжид байлгана.

10.2.Тусгай нэгж нь эрэгтэй хүүхдийн дотуур байрнаас тусдаа байж, хичээлийн болон нийгэмшүүлэх ажилд эрэгтэй хүүхэдтэй цуг байж болно.

## Арван нэг.Өсвөр насны этгээдийг суллах

11.1.Өсвөр насны этгээдийг суллахдаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг байлцуулан хүлээлгэн өгнө.

11.2. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч байхгүй тохиолдолд орон нутгийн цагдаагийн байгууллага эсвэл халамжийн байгууллагад хүлээлгэн өгнө.